



ГОПОМТ БАНК



АГУУЛГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ	3
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ	6
ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	11
ДНБ ба Гадаад Худалдаа	11
Улсын төсөв	14
Инфляци ба Валютын ханш	15
Банкны систем	17
Монголын хөрөнгийн зах зээл	19
БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ	20
Хэтийн зорилго, Эрхэм зорилго	20
Компанийн засаглал	20
Бодь Интернэшил ХХК	21
Бүтэц зохион байгуулалт	23
Удирдлагын баг	25
Хүний нөөц	26
Дэд бүтэц	29
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ	30
Иргэдэд хандсан бизнесийн үйл ажиллагаа	30
Байгууллагад хандсан бизнесийн үйл ажиллагаа	33
Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа	34
Худалдааны санхүүжилт ба Олон улсын төлбөр тооцоо	35
Нөөцийн үйл ажиллагаа	36
САНХҮҮГИЙН ТОЙМ	37
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ	41
НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ	54
БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	56
САЛБАР НЭГЖИЙН СУЛЖЭЭ	58
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ	61
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	61

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Д.Баясгалан

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

Эрхэм хүндэт хувь нийлүүлэгчид, харилцагчид, түнш байгууллагууд, ажиллагасад аа

Та бүхэнд тасралтгүй амжилттай ажиллаж буй 16 дахь жил болох 2010 оны бизнесийн үйл ажиллагааныхаа үр дүнг тайлagnаж буйдаа таатай байна.

Монгол орны цас зудтай хахир хүйтэн өвлийн нөлөө эдийн засагт бэрхшээл учруулсан хэдий ч 2008 оны сүүл, 2009 оны эхээр тохиосон сорил бэрхшээлийг амжилттай даван туулсан эдийн засгийн бусад салбар дахь сэргэлт эрчимтэй байлаа. Энэхүү эрчимтэй өсөлтөд эрдэс баялгийн үнийн өсөлт, дэлхийн хэмжээнд үнэлгэдсэн манай эрдэс баялгийн нөөц, ялангуяа Оюу Толгойн алт, зэсийн ордын төслөөс үүдэлтэй экспортын өсөлт, үүнийг дагасан ханганд нийлүүлэх үйлчилгээний өсөлт, нийлүүлэлтийн сураг гэсэн дөрвөн хүчин зүйл түлхэц үзүүлсэн байна.

Бид тайлан тэнцлийн өсөлтөөрөө дахин дээд амжилт тогтоож, Голомт Банкны нийт актив 561 тэрбум төгрөг (446 сая ам.доллар)-өөр буюу 55 хувиар өсч 1.574 их наяд төгрөг (1.25 тэрбум ам.доллар)-т хүрч Монгол улсын хамгийн том банк гэсэн байр суурийг дахин эзэллээ...

2009 онд эдийн засаг багахан сэргэсний дараагаар тайлант онд ДНБ-ий өсөлт уламжлалт өсөлтийн замдаа эргэн орж 6.1 хувиийн өсөлттэй гарсан ба гадаад валютын албан нөөц хамгийн өндөр хэмжээнд хүрлээ. Олон Улсын Валютын Сантай Байгуулсан хөтөлбөр амжилттай хэрэгжсэний үр дүнд төсвийн алдагдлыг 4 хувиас доош түвшинд барьж, төгрөгийн худалдан авах чадвар улам сайжирнаар эдийн засаг, санхүүгийн системд итгэх итгэл сэргэлээ.

Макро эдийн засгийн таатай орчны үр дүнд Голомт банк санхүүгийн болон бусад зорилтуудаа аль алиныг биелүүлсэн ололт амжилт дүүрэн жилийг ардаа үдэж байна.

Бид тайлан тэнцлийн өсөлтөөрөө дахин дээд амжилт тогтоож, Голомт Банкны нийт актив 561 тэрбум төгрөг (446 сая ам.доллар)-өөр буюу 55 хувиар өсч 1.574 их наяд төгрөг (1.25 тэрбум ам.доллар)-т хүрч Монгол Улсын хамгийн том банк гэсэн байр суурийг дахин эзэллээ. 2008 онд дэлхийн болон дотоодын эдийн засагт огцом уналт

Болох магадлалтай гэж бид зөв таамаглаж байсан учраас санхүүгийн хувьд хүчирхэг байхад анхаарч, хамгийн том банк байх гэсэн зорилтыг хоёрт тавьж ирсэн. Монголын банкны системд хамгийн их татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй банк гэсэн манай банкны тэргүүлэх байр суурь нь Голомт банкийг сонгон үйлчлүүлж буй харилцагчдын итгэлд үндэслэгдэж байгаа бөгөөд тайлант онд Голомт банкны харилцах, хадгаламжийн хэмжээ 66 хувиар өссөн нь Монголын банкны системийн 41 хувийн өсөлтөөс өндөр үзүүлэлт юм.

Балансын актив тал нь мөн сайн өсөлттэй байсан ба банкны системийн цэвэр зээл 25 хувиар өссөн байхад Голомт банкны цэвэр зээл 279 тэрбум төгрөг (222 сая ам.доллар) буюу 55 хувиар өссөн байна.

Тоон өсөлтөөс илүүтэйгээр зохистой, тогтвортой өсөлтийг хангаж, улмаар Монгол Улсын санхүүгийн системд оролцогч бүхий л талын итгэж үйлчлүүлэх банк нь байх стратегийн зорилгодоо хүрэх нь хамгийн чухал зүйл юм. Энэхүү зорилгын хүрээнд зээл болон харилцах, хадгаламжийн харьцааг 60 хувиас доош (бусад тэргүүлэх банкуудтай харьцуулахад хамгийн хүчирхэг) түвшинд барьсан нь төлбөрийн чадварын харьцааг 50 хувиас дээш түвшинд хадгасан хэвээр зээлийн үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой байгааг илэрхийлж буй юм.

Банкны салбартаа татан төвлөрүүлсэн хөрөнгө, зээл, активын хэмжээгээр тэргүүлэгч байр суурь эзэлж байгаа нь бидэнд итгэл хүлээлгэж үйлчлүүлдэг харилцагчдын маань ач тус бөгөөд бид үүндээ сэтгэл ханалгүй, цаашдын манлайллын маань гол үндэс болсон харилцагч төвтэй үйлчилгээгээ үзүүлж, улсынхаа хамгийн шилдэг банк нь байж ажиллах болно.

Ашигт ажиллагааны гол амжилтыг дурьдвал татварын дараах ашиг 6.9 тэрбум төгрөг (5.5 сая ам.доллар) -өөр өсч, 20 тэрбум төгрөг (16 сая ам.доллар) -т хүрснээр, нэгж хувьцаанд ноогох өгөөж 914 төгрөгт хүрч, 2009 оны үзүүлэлтээс даруй 52 хувиар нэмэгдсэн нь (гадаад, дотоодын олон банкуудаас давсан) онцгой амжилтыг нэгээр баяжуулсан жил болгосон юм.

Банкны ашигт ажиллагааны амжилт болох дундаж активын өгөөж 1.7 хувь, дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 26.6 хувьд хүрсэн нь өөрийн хөрөнгийг 31 хувиар нэмэгдүүлж, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 28.7 тэрбум төгрөг (22.9 сая ам.доллар)-өөр нэмэгдүүлсэнтэй холбоотой. Тайлант онд банкны өөрийн хөрөнгө 128 тэрбум төгрөг (102 сая ам.доллар)-т хүрч, өөрийн хөрөнгийн хүрэлцээ 13.5 хувь буюу Төв Банкнаас тавьдаг шалгуурыг хангалттай биелүүлж 10 хувиас илүү гарлаа.

Энэхүү өсөлтөд тайлант оны дундуур дэлхийд тэргүүлэгч хөрөнгө оруулалтын сан болох Абу Дабигийн Хөрөнгө Оруулалтын Зөвлөлтэй байгуулсан нийт 35 сая ам.долларын хөрвөх чадвар бүхий хоёрдогч өглөгийн зээлийн гэрээний дагуу эхний 25 сая ам.долларыг байршуулсан нь чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг ийнхүү нэмэгдүүлсэн нь 2007 оноос хойш урт хугацаанд хамтран ажиллаж буй бидний түнш болох Кредит Свисс банктай байгуулсан хамтын ажиллагаатай ижил төстэй юм. Голомт банкийг хүлээн зөвшөөрсөн энэхүү хоёр стратегийн хөрөнгө оруулалт нь дэлхийн нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудаас ирээдүйд Монголын банкны хувьцаанд хөрвөх хөрөнгө оруулалт хийсэн анхны бөгөөд одоогоор байгаа цор ганц тохиолдол болж буй юм.

Оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, далайц, эдийн засагт шинээр бий болж буй боломж бололцоог судлан хамтарч ажиллах зорилгоор Абу Дабигийн Хөрөнгө Оруулалтын Зөвлөлөөс өөрийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал ноён Марк Кютисийг манай банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр томилсон юм. Мөн 2010 онд шинэчлэгдэн батлагдсан Банкны тухай хуулийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгч асан, Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх захирал бөгөөд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийн Санхүүгийн тэнхмийн эрхлэгч ноён Ж.Үнэнбатыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр томилон ажиллуулж байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бусад гишүүдийнхээ нэрийн өмнөөс шинээр томилогдсон гишүүддээ баяр хүргэхийн ялдамд шинэ

гишүүдийн маань санхүүгийн олон талт мэдлэг, арвин их туршлагад үндэслэсэн зөвлөгөө, санал нь манай банкны үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Банкны ажилтнуудын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр, гүйцэтгэлд суурисан цалин урамшууллын бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ банк болон түүний хувь нийлүүлэгчид, ажилтнуудын урт удаан хугацааны ашиг сонирхлыг нэгтгэх зорилгоор Монгол Улсын анхны хувийн тэтгэврийн сан болох Тэтгэврийн Ууган Санг үүсгэн байгуулж, мөн "Ажилтнууддаа Хувьцаа Эзэмшүүлэх Хөтөлбөр"-ийг анхлан хэрэгжүүллээ.

Дүгнэж хэлэхэд бидний урагшлан тэмүүлж буй 2011 он болон ирж буй он жилүүд Монгол Улс, Монголчуудын хувьд итгэл дүүрэн байж болох өөдрөг төлөв байдалтай байна. Дэлхийн болон зарим бус нутагт эдийн засгийн тодорхойгүй хандлага үргэлжилж байхад эдийн засгийн хурдацтай өргөжилтийн гол хөдөлгөгч хүчний зэргэлдээ оршин буй болон гол эрдэс баялгийн экспортын эрчимтэй өсөлт, дунд хугацаан дахь үнийн тогтвортой байдлын таатай нөлөөгөөр өмнөх жилүүд дэх эдийн засгийн бага өсөлтийнхөө дараагаар Монгол Улсын эдийн засагт үсрэнгүй өсөлт гарах нөхцөл бүрдээд байна.

Товчхондоо, байгалийн арвин их нөөц баялагт тулгуурласан дэлхийн хэмжээний байгаль орчинд ээлтэй олборлолт явуулж, хөрөнгийг эргэлтэд оруулах замаар эрчимтэй хөгжлийн замд эргэлт буцалтгүйгээр орж байгаа юм.

Бидний хувьд Монгол Улсын хөгжлийн өнөөгийн онцлогт тохируулан өөрийн өвөрмөц зах зээлийн мэдлэг, өрсөлдөх чадвараа ашиглан, хамтран ажиллагч түншүүдийнхээ нөөц бололцоог татан дайчлахаар шамдан ажиллах болно. Иймд бидний өмнө тулгарах аливаа сорилтыг сайтар тандан мэдэж, өсөлт үргэлж дардан байдаггүйг ухамсарлан, банкны түүхийн 17 дахь жилийг улс түмэн, харилцагчиддаа өөрсдийн хамгийн дээд оюун мэдлэг, чадварыг дайчлан сонирхогч бүх талд өнөд хадгалагдах үнэ цэнийг цогцлоон бүтээхээ батлан илэрхийлж байна.



Д.Баясгалан

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Жон П. Финиган

Гүйцэтгэх захирал

**Эрхэм хүндэт харилцагч, түнш,
хувь нийлүүлэгч, хамтран ажиллагсад аа**

Сорил, бэрхшээл үргэлжилсэн хоёр оны дараагаар хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өсөлт дахин сэргэж, олон улсын болон дотоодын эдийн засгийн ерөнхий чиг хандлагад онцлон тэмдэглэхүйц зерэг өөрчлөлтүүд гарсан жилийг үнэлэн дүгнэж байгаадаа нэн таатай байна.

Санхүүгийн хямралын оргил үед дэлхий нийтээрээ мөнгөний тэлэх бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр ихэнх хөгжингүй орнуудад хүлээж байснаас нь илүү өсөлт гарч, эдийн засгийн тогтвортой байдал сэргэж, олон улсын худалдаа, арилжааны хэмжээ хямралын өмнөх үеэс илүү нэмэгдлээ.

2010 онд дэлхийн ДНБ-ий өсөлт 4 хувь байна гэж тооцсон боловч гурван өөр хөгжлийн хурд бүхий эдийн засгийт орнуудад өсөлт харьцангуй зөрөөтэй байлаа. Хөгжиж

Өөрийн хөрөнгө 63 хувиар өсч 128 тэрбум төгрөг (102 сая ам. доллар)-т хүрсэн ба 66 хувийг нь I зэрэглэлийн өөрийн хөрөнгө бүрдүүлснээр нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ 13.5 хувь, I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 8.85 хувьд хүрсэн билээ...

буй эдийн засгийт орнуудад эдийн засгийн өсөлт б орчим хувь байсан бол АНУ болон Европын орнуудад эдийн засгийн өсөлт арай бага буюу тус тус 3 хувь, 2 хувьтай байв.

АНУ-ын эдийн засгийн сэргэлт удаашралтай байгаа нь хувийн хэвшлийн салбар дахь ажлын байрны өсөлт хангартгүй, үнийн өсөлт сул хэвээр буюу өргөн хэрэглээний гол бутээгдэхүүний үнийн инфляци 1 хувиас доош, мөн орон сууцны илүүдэл нийлүүлэлтээс үүдэлтэй үл хөдлөх хөрөнгийн үнийн бууралт зэрэгтэй холбоотой юм.

Европын орнуудын хувьд Герман улс 3.6 хувийн эдийн засгийн өсөлттэй гарсан бол Европ даяар ДНБ ердөө л 1.7 хувийн өсөлттэй байсан ба хүчин чадлын илүүдэл, төсвийн тулгамдсан хэрэгцээтэй холбоотой бөгөөд энэ нь ажилгүйдлийг улам нэмэгдүүлсээр байна.

Ази тивд Японы эдийн засаг гамшигт цунамид нэрвэгдэхээс өмнө буурч байсан нь дотоодын эрэлт хэрэгцээ багассанаас үүдсэн үнийн бууралт, мөнгөний

эргэлт багассантай холбоотой ба энэ нь мөн л төсвийн хатуу бодлого баримтлах хэрэгцээтэй уялдаатай юм.

Нөгөөтэйгүүр хөгжиж буй эдийн засагтай орнууд улам илүү хүчирхэгжих байна. Тухайлбал Бразил улс гол түүхий эдийн тогтвортой үнээс үр ашиг хүртэж, Энэтхэг улсын дотоодын өндөр эрэлт хэрэгцээ нь хөгжих үндэс болж, цаашилбал манай хөршүүд болох ОХУ-ын хувьд газрын тосны өндөр үнийн нөлөөгөөр оны сүүлийн улиралд 4.5 хувийн өсөлттэй гарч, Хятад Улсын эдийн засаг 9.8 хувийн өсөлтийг бий болгож Япон Улсын эдийн засгийг даван дэлхийн хоёр дахь томоохон эдийн засаг бүхий улс болж өргөжин тэллээ.

Энэ бүхний зэрэгцээ Монгол Улсын ДНБ-ий өсөлт өөрийн орны онцлог болох эрдэс баялаг, газар зүйн таатай байршлын нөлөөгөөр 6.1 хувьд хүрч, эцсийн хэрэглээ 68 хувь, гадаад худалдааны тэнцэл дэх цэвэр экспортыг багтаасан хөрөнгө оруулалт 41 хувьд тус тус хүрлээ.

Оны эхний сарууд нилээд хүндхэн байсан ба жилийн эхний хагаст үргэлжилсэн зудын гамшгийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар ихээхэн бэрхшээлтэй тулгарав. Урт удаан, тэсгим хүйтэн өвлийн улирал малчдын хувьд сүйрэл авчирч, мал сургийнхээ бараг 20 хувийг алдсанаар хөдөө аж ахуйн салбарын бүтээмж эрс буурсан юм. Гэвч энэхүү зудын нөлөө, сөрөг хүчин зүйлс бүхий орчинд Голомт банк гол чиг шугамаа алдаагүйг дурьдахад нэн таатай байна.

Дэлгэрэнгүй мэдээллээр экспорт 54 хувиар өсч 2.9 их наяд төгрөг (2.3 тэрбум ам.доллар)-т, импорт мөн ойролцоогоор 53 хувиар өсч 3.3 их наяд төгрөг (2.6 тэрбум ам.доллар)-т хүрснээр гадаад худалдааны алдагдал 476 тэрбум төгрөг (379 сая ам.доллар) гарсан ба үүний 40 хувийг нь тоног төрөөхөмжийн импорт эзэлж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2009 онд 570 сая ам.доллар байсан бол 1.57 тэрбум ам.доллар болтлоо хурдацтай өсч 176 хувийн өсөлт гаргажээ.

Түүнчлэн Засгийн Газрын орлого 54 хувиар (1.08 их наяд төгрөг буюу 860 сая ам.доллар) нэмэгдэж 3.078 их наяд төгрөг (2.45 тэрбум ам. долларт)-т, харин зарлага 3.076 их наяд төгрөгт хүрч бараг тэнцүү байгаа нь алдагдалтай төлөвлөгдсөн төсвийг 2.2 тэрбум төгрөгийн ашигтай болгожээ.

Энэхүү зөврөг үр дүнгүүд нь төгрөгийн ханш жилийн турш үргэлжлэн 13 хувиар чангартсан, ялангуяа банкны салбарын амжилттай холбоотой байв. Тухайлбал Голомт банк тэргүүлэх байр сууриа хэвээр хадгалж нийт активаа 561 тэрбум төгрөг буюу 56 хувиар өсгөж 1.57 их наяд төгрөгт хүргэсэн нь дотоодын банкны системийн нийт активийн 41 хувийн өсөлттэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа юм.

Байгууллага болон иргэдээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтийг авч үзэхэд нийтдээ 71 хувиар өссөн нь нийт системийн 55 хувийн өсөлтөөс харьцангуй илүү, зээл 56 хувиар өссөн нь системийн 25 хувийн өсөлттэй харьцуулахад даруй 2 дахин илүү байна. Энэхүү өсөлтөөрөө бид нийт зээлийн багцаа нэмэгдүүлж чадсан бөгөөд зээл олголтонд тавих шаардлагагаа өндөрсгэж чанаргүй зээл 2009 онд 4.4 хувь байсныг 2010 онд 2.1 хувь хүртэл бууруулсан.

Өөрийн хөрөнгө 63 хувиар өсч 128 тэрбум төгрөг (102 сая ам.доллар)-т хүрсэн ба үүний 66 хувийг I зэрэглэлийн өөрийн хөрөнгөөр бүрдүүлснээр нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ 13.5 хувь, I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 8.85 хувьд хүрсэн билээ.

Голомт банк нь Монголын тэргүүлэх банкуудаас ганцаараа санхүүгийн хямралын үеэр ч ашиг орлогоо нэмэгдүүлсээр ирсэн бөгөөд тайлант онд 2009 онд гаргасан үр ашигийн дээд амжилтаа дахин үзүүлснийг санхүүгийн тайлангаас харж болно. Тайлант онд банкны татварын дараах ашиг 52 хувийн өсөлт гаргаж, 20 тэрбум төгрөг (15.95 сая ам.доллар)-т хүрснээр дундаж активын өгөөж 1.7 хувь,



дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 26.6 хувь боллоо. I зэрэглэлийн өөрийн хөрөнгийг үйл ажиллагааныхаа үр дүнгээр 31 хувиар өсгөх чадсан нь бид өөрийн хүчин чадлаар хөрөнгөө нэмэгдүүлэх чадамж өндөр байгааг баталж байна.

Орлогын өсөлтийн гол хөдөлгөх хүч нь цэвэр хүүгийн орлогын 24 хувиин өсөлт байсан ба энэ нь Монголын эдийн засгийн өсөлттэй шууд холбоотой. Энэхүү өсөлт нь үйл ажиллагааны орлогын 36 хувийг бурдүүлэх ба үйлчилгээ, шимтгэлийн хураамжийн орлогыг 26 хувиар өсөхөд нөлөөлсөн. Хураамжийн орлого 19.5 тэрбум төгрөг (15.5 сая ам.доллар)-т хүрсэн нь картын бизнес, төлбөр тооцоо, үйлчилгээний хураамж болон гадаад валютын ханшны орлогоос бүрдэж байгаа юм. Энэ нь байгууллагын өргөн хүрээ бүхий харилцагчидтайг харуулж байгаа юм.

Үйл ажиллагааны зардал 28 хувиар өссөн нь (актив болон ашгийн өсөлтийн бараг хагас нь) үл хөдлөх хөрөнгө, мэдээллийн технологи болон хүний нөөцийд оруулсан хөрөнгө оруулалттай холбоотой. Эдгээр хөрөнгө оруулалтууд нь харилцагчиддаа хүргэх үйлчилгээгээ сайжруулах, ирээдүйн орлогоо нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд тайлант онд банкны хүний нөөцийн зардал 30 хувиар өсч нийт зардлын 34 хувьтай тэнцлээ. Нэг ажилтанд ноогдох ашиг 2009 оноос хойш 15.6 сая төгрөгөөс 20.7 сая болж 33 хувиар өссөн байна.

Зардал орлогын харьцаа сайжирч 44 хувь болтлоо буурсан ба оны эцэс гэхэд (2009 онд 4.4 хувь) зээлийн багц дахь чанаргүй зээл 2.1 хувь болтлоо буурч чанаргүй зээлийн зохист удирдлага шинэчлэгдсэн болно.

Зээлийн зохистой удирдлага, худалдааны нөхцөл, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт гарсан сэргэлтийн үр дүнд зээлийн чанар сайжирснаар үйл ажиллагааны орлого сайжирч өмнөх жилтэй харьцуулахад 983 сая төгрөг болжээ.

Банк нь тайлант онд энэхүү ашиг орлогын нааштай өөрчлөлтүүдээс гадна олон чиглэлээр тэргүүлэх байр сууриа

хадгалж ирсэн ба харилцагчдад хүргэх үйлчилгээнийхээ боломжийг сайжруулах, үйл ажиллагаагаа илүү үр дүнтэй болгоход чиглэж ажиллалаа. Эдгээрээс онцлох амжилтуудыг дурьдвал:

- шинээр 18 нэгж нээж нийтдээ салбар, нэгжийн тоо 70 боллоо;
- ATM сүлжээг 40 хувиар нэмэгдүүлж тоо хэмжээг 100-д хүргэсэн;
- Хятад Улсаас бусад нутагт юаний карт гаргасан анхны гадаадын банк болсон;
- Төгрөг-Европийн хосолсон валюттай карт гаргасан;
- Монгол Улсад анхны банкны батлан даалтын үйлчилгээг нэвтрүүлсэн;
- Солонгост суугаа Монголчуудад үйлчилгээ үзүүлэх зорилгоор Сөүл хотод өөрийн төлөөлөгчийг ажиллуулж эхэлсэн;
- Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны Жижиг Дунд Үйлдвэрийн Хөгжлийн Хөтөлбөрийн бүрэн эрхт зохицуулагчийг томилсон;
- Салбарын бүхий л үйл ажиллагааг зохицуулсан журам бүхий дэлгэрэнгүй гарын авлага гаргасан.

Монгол Улсаас анхны дэлхийн хэмжээний банк болох стратегийн зорилгоо биелүүлэхийн тулд өсөн нэмэгдэж байгаа харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг хангах, ашигт малтмал, уул уурхайн салбарт илүү анхаарал хандуулах үүднээс шинээр Хөрөнгө Оруулалтын Банкны газар болон Мэдээлэл Технологийн газрыг байгуулсан. Мөн мэдээллийн технологийн системийн загвар, аюулгүй байдлыг байнга сайжруулж, цахим банкны үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэн, хүртээмжийг сайжруулж "Verified by VISA", "MasterCard Secure Code" зэрэг цахим арилжааг баталгаажуулах стандартуудыг нэвтрүүлэн карт эзэмшигч, картаар үйлчлэгч байгууллага, бизнесийн хамтрагчиддаа хамгийн найдвартай, сайн чанарын үйлчилгээг хүргэж байна.

Мөн нийгмийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх үүднээс ашиг орлогынхоо баагүй хэсгийг Монголын ард түмэнд тустай зүйлд, ялангуяа ядуурал, эмнэлэг, боловсрол ба спортын чиглэлийн үйл ажиллагааг дэмжихэд зарцуулж байна.

Түүнчлэн Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг дэмжих, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татахад үүрэг оролцоогоо улам нэмэгдүүлж ажиллаж байна. Тайлант онд Монгол Улсын Ерөнхий Сайдын зохион байгуулсан Хонг Конгийн Хөрөнгийн Бирж дэх Монголын аж ахуйн нэгжүүдийн жагсаалтын талаарх танилцуулга уулзалт, Монголын Эдийн Засгийн Чуулга уулзалт, бус нутгийн төвүүдэд зохион байгуулагдсан Бус нутгийн Хөрөнгө Оруулалтын Чуулга уулзалт, уул уурхайн салбарын тэргүүлэх үйл ажиллагаа болох "Discover Mongolia" уул уурхайн хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт зэргийг ивээн тэтгэж ажиллалаа. Мөн түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар Дэлхийн Эдийн Засгийн Форумтай хамтран Монгол Улсад зохион байгуулсан Хариуцлагатай уул уурхайн санаачлага, Авилигын эсрэг түншлэлийн санаачлага салбар хуралдаануудыг тус тус ивээн тэтгэсэн болно.

Байгууллагын хамгийн үнэ цэнэтэй зүйл болох хүний нөөцийн хувьд нийтдээ шинээр 200 ажилтан, албан хаагчдыг Голомт банкныхаа хамт олонд нэгтгэж, улам бүр өсөн нэмэгдэж буй харилцагч, үйлчлүүлэгчиддээ санхүүгийн цогц үйлчилгээг илүү үр дүнтэйгээр хүргэх үүднээс ажилтнуудаа мэргэжлийн сургалтад байнга хамруулсаар байна. Ажлын гүйцэтгэлд тулгуурласан урамшуулал, цалингийн нэмэгдэл зэргээс гадна бид Тэтгэврийн Ууган Санг үүсгэн байгуулсан. Энэхүү сан нь төрийн тэтгэврийн тогтолцоог дэмжин нэмэгдүүлэх анхны хувийн тэтгэврийн сан болж байгаа гэдэг нь нэрнээсээ л илт харагдаж буй юм. Уг сан нь ажилтнуудын болон харилцагч байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарсан хөтөлбөрийн нэгэн хэсэг бөгөөд тэдэнд ирээдүйдээ хөрөнгө оруулах онцгой боломжийг олгож байгаа юм.

2010 онд шинэчлэгдэн батлагдсан Банкны тухай хуулийн заалтын дагуу бид байгууллагын засаглал, эрсдэлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, шинээр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэд Эрсдэлийн Удирдлагын Хороо байгуулж, Банкны Дотоод Аудитын үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах үүднээс Аудитын Хорооны үйл

ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлсэн ба мөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд банкны салбарт арвин туршлага бүхий хоёр шинэ гишүүнийг элсүүллээ.

Эцэст нь хэлэхэд Голомт банкны хамт олны өмнөөс хамгийн түрүүнд бидний бизнесийг дэмждэг эрхэм хүндэт харилцагч, бизнесийн хамтрагч банкууддаа; хоёрдугаарт манай банкинд итгэж найддаг бүхий л Монгол Улсын иргэд, компаниуд, байгууллагуудад; гуравдугаарт Монгол улсын Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, бусад албан тушаалтнуудын удирдлага чиглүүлэгт (Монголын Эдийн Засгийн Чуулганы үеэр гаргасан үр ашиггүй хүнд суртлыг халах талаарх уриаг дэмжиж байгаагаа илэрхийлж байна); дөрөвдүгээрт хүндэт Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, Бодь Интернейшнл ХХК-д болон эцэст нь удирдлагын багийн гишүүдийнхээ өмнөөс байгууллагынхаа 1100 гаруй ажилтан, албан хаагчиддаа, ирээдүйн амжилтад хүрэх үндэс суурь болсон тэдний чин сэтгэл, шаргуу хөдөлмөр, хүч чармайлтад нь талархлаа илэрхийлье.

2011 он руу урагшлах тутам бид дотоодын болоод дэлхийн бус нутгийн хөгжил цэцэглэлтийг сайтар дүгнэн цэгнэж байх хэрэгтэй бөгөөд ингэснээрээ тулгарах асуудалд үр дүнтэй хариу өгөх, хөрөнгөжих боломжийг зүй зохистой ашиглах зөв байр суурийг сонгож чадах юм. Ойрхи Дорнодод үүсээд буй газрын тосны үнийн өсөлт дэлхийн эдийн засгийн хямралаас гарах хурдацаад муугаар нөлөөлж байгаа нь эдийн засгийн талаарх таамаглалыг бүрхэг болгож байна. Хойд Америкийн эдийн засгийн өсөлт хөрвөх чадварын хувьд хязгаарлагдаж, үл хөдлөх хөрөнгийн үнэ, хэрэглэгчдийн ханамж, ажил эрхлэгчдийн байдал нь Холбооны Нөөцийн Сангийн тогтвортой бодлогод нөлөөлж байна.

Евро бүсийн хувьд бас нэг санаа зовоосон асуудал бол хүүгийн түвшин хамгийн доод цэгтээ хүртэл буурч, эргээд өсөх хандлагатай болсноор дэлхийн хямралын дараах бодлого өөрчлөгдж байна. Энэхүү хандлага нь нилээд зөрөлдөөн үүсгэх ба хоёрдогч Евро нэгдэлд нөлөөлж, хүчирхэг түлхүүр улсад хүүгийн ханшийн шинэ инфляци үүсч, харин буурай улсууд их хэмжээний зээлийн дараа



хомс байдалтай тэмцэх болно. Энэ нь бие даасан төлбөрийн зах зээл дэх санхүүгийн тогтвортой байдлын асуудлыг улам хурцатгах юм.

Ази тивийн хувьд Японы эдийн засаг цунамигийн гамшигт хохирлыг арилгах зардлын бодлогоо шинэчилсэн байдалтай байгаа бол манай томоохон худалдааны хамтрагч Хятад Улс, ялангуяа хүнс болоод үйлчилгээний салбаруудад гарч байгаа инфляцийн асуудалдаа нилээд санаа зовж байна. Энэ нь Төв банкийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийнхээ мэдээллийн (PMI) тооны бууралтыг үл анхааран бодлогоо улам чангатгахад хүргэж байна. Гэвч Хятад Улсын ханшийн өсөлтийн ямар ч удаашрал нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нөлөөлөл бараг байхгүйтэй адил юм. Учир нь тус хоёр улсын эдийн засгийн бодит зөрөө их юм. Жишээлбэл, хамгийн бага буюу 8 хувийн өсөлттэйгээр Хятад Улсын ДНБ 5.87 их наяд ам.долларт хүрэх буюу 470 сая ам.долларын өсөлтийг үзүүлэх бол энэ нь Монгол Улсын ДНБ-ээс даруй 70 гаруй хувиар илүү байгаа юм.

Бага эрэлт хэрэгцээнээс үүдэх аж үйлдвэржсэн орууудын үнийн бууралтын айдсыг эс тооцвол бид экспортынхоо тоо хэмжээ, үнийн аль алинд өсөлтийг баталгаажуулах гол түүхий эдийн бүтээгдэхүүний тогтвортой үнийг зерэггээр төсөөлж байна. Цаашилбал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн өсөлт нь хөрөнгийн зардал ихээр нэмэгдэж байгаатай холбоотой бөгөөд энэ нь Оюу Толгой ордын зэс, алт, мөнгөний уурхайн барилга байгууламжийнхаа хамгийн оргил үед үйл ажиллагаагаа (дангаараа 2.3 тэрбум ам долларын хөрөнгийн зардалтай) явуулж байгаатай болон Засгийн Газар дэлхийн хэмжээний металлургийн ба коксжсон нүурсний нөөц болох Таван Толгойн ордыг ашиглалтад оруулах тал дээр шийдэмгийн хэлэлцээрүүдийг хийж эхэлсэнтэй шууд холбоотой билээ. Голомт банкны хувьд улс үндэстний гол ач холбогдол бүхий энэхүү төслүүд дээр санхүүгийн туслалцаа үзүүлэх чухал үүрэг хүлээсэн нь нэр төрийн хэрэг юм.

Энэхүү өөрчлөлт шинэчлэлтийн үйл ажиллагаатай нягт холбоотойгоор тээврийн салбар, олон улсын зах зээлд гарах гарц бүхий төмөр зам болоод засмал замын төслүүд, үүнийг дагаад эрчим хүч, усны дэд бүтэц, барилга байгууламж маш хурдацтай өргөжин тэлж худалдаа, орон сууц, боловсрол, эмнэлэг, чөлөөт цаг, жуулчны салбаруудыг хамарсан олон төрлийн төслүүд хэрэгжээд байна.

Нөгөө талаас өргөжин тэлж буй нөхцөл байдалд макро эдийн засгийн эрсдэл төсвийн хэт тэлэлтээс үүдэж байгаа ба гаднаас орж ирж байгаа шууд хөрөнгө оруулалтын эрс өсөлт нь валютын ханшны тогтвортгүй байдал болоод инфляцийн асуудлыг үүсгээд байгаа юм. Бусад анхаарууштай асуудлууд нь мөнгөний нийлүүлэлтийн болоод зээлийн хэт өсөлт юм. Энэхүү эдийн засгийн огцом өсөлт бүхий үед эрх баригчид маань зохистой тэнцвэрт байдлаа хадгалж, эрсдэлээс сэргийлж, зөв зүйтэй чиглүүлэх зорилгоо амжилттай хэрэгжүүлнэ гэдэгт бид итгэл төгс байна.

Ийм тааламжтай нөхцөлд Монгол Улс болоод ард иргэд нь гэрэл гэгээтэй сайхан ирээдүйг итгэл төгс харж болох юм. Өндөр боловсрол мэргэжилтэй, чин сэтгэлтэй ажилтан албан хаагчидтай, олон улсын өргөжин тэлж буй хамтын түншлэлтэй Голомт банк энэхүү өөрчлөлт цэцэглэлтэд гар бие оролцож буй бүхий л талуудад хамгийн үр ашигтай, өргөн сонголт бүхий банк санхүүгийн үйлчилгээг хүргэн, Монгол Улс дахь таны бизнесийг дэмжих нэн тэргүүний банк байх үүргээ биелүүлж тусалж дэмжихэд хээээд бэлэн байна.



Жон П. Финиган

Гүйцэтгэх захирал

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ДНБ БА ГАДААД ХУДАЛДАА

Дэлхийн эдийн засгийн хямралын үед уул уурхайн гол бүтээгдэхүүнийн экспортын хэмжээ болон үнийн тогтвортгуй байдал нь дотоод эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байсантай харьцуулахад өнгөрсөн 2010 онд хөдөө аж ахуйн салбарын уналтыг эс тооцвол бүхий л салбарт өсөлт ажиглагдлаа.

Нүүрс болон төмрийн худрийн экспортын огцом өсөлт, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт зэрэг нь улсын нэгдсэн төсвийн орлого эргэн өсч, гадаад валютын албан нөөц хямралын үетэй харьцуулахад 6 дахин өсөхөд голчлон нөлөөлсөн. Иргэдийн банк санхүүгийн системд итгэх итгэл сэргэж, үндэсний валют болох төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2009 оны 4 дүгээр сараас 21 хувиар чангарт, улсын нэгдсэн төсөв алдагдалтай гарна хэмээн таамаглаж байсантай харьцуулахад 2.2 тэрбум төгрөгийн ашигтай гарсан юм.

Өнгөрсөн оны 1 дүгээр улиралд болсон зудын уршгаар нийт малын 28 хувь буюу 12 сая тоо толгой мал үрэгдсэн нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл унахад хүргэсэн юм. Мал аж ахуйн сектор энэхүү гамшгийн улмаас жил орчим хугацаанд сэргэж чадаагүй ч хөдөө аж ахуйн секторын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 11.5 хувиар өсч 1.3 их наяд төгрөгт (төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал өссөний үр дүнд) хүрсэн байна. Харин бодит дүнгээр 16.8 хувиар буурч нийт ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 2009 онд 18 хувь байсан бол 2010 онд 16 хувь болж буурсан байна.

Харин 2011 оны эхээр өнгөрсөн жилд болсон шиг гамшиг хөдөө аж ахуйн салбарт тохиосонгүй. Тиймээс энэ жил аж үйлдвэрийн салбарын өсөлт голчлон нөлөөлснөөр бодит ДНБ-ий өсөлт хоёр оронтой тоонд байх таамаглал гарч байна.

Өнгөрсөн 2010 онд нэрлэсэн ДНБ 8 их наяд 255.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 25.3 хувиар өссөн байна. Харин дефлятор ашиглан тооцноор бодит ДНБ 2009 онд 1.3 хувиар буурч байсан бол 2010 онд 6.1 хувиар өсчээ.

2010 оны эцсийн байдлаар ДНБ-ийг эцсийн ашиглалтын бүтцээр авч үзвэл хувийн болон Засгийн Газрын нийт хэрэглээ 68 хувийг (өмнөх жилээс 20 хувиар өссөн), хөрөнгө оруулалт 41.4 хувийг (өмнөх жилээс 54 хувиар өссөн), гадаад худалдааны алдагдал сөрөг 9.4 хувийг (790 тэрбум төгрөг буюу өмнөх жилээс 65 хувиар өссөн) тус тус эзэлж байна.



ДНБ-ий өсөлт (салбараар)

	2006	2007	2008	2009	2010
ДНБ, нэрлэсэн үнээр (тэрбум.төгрөг)	4,027.6	4,956.6	6,555.6	6,590.6	8,255.1
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт	32.4%	23.1%	32.3%	0.5%	25.3%
Бодит ДНБ-ий өсөлт	8.6%	10.2%	8.9%	-1.3%	6.1%
ДНБ-ий салбаруудын өсөлт:					
Хөдөө аж ахуй	6.5%	14.4%	4.7%	3.6%	-16.8%
Уул уурхай, олборлолт	5.3%	1.1%	-1.6%	5.8%	6.3%
Боловсруулах үйлдвэрлэл	12.3%	27.5%	2.7%	-9.0%	11.3%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3.5%	6.2%	8.1%	6.3%	5.7%
Усан хангамж	3.8%	6.5%	8.7%	4.8%	4.8%
Барилга	4.1%	7.2%	-13.8%	-34.0%	15.6%
Бөөний болон жижиглэн худалдаа	14.3%	5.5%	15.0%	-11.8%	23.4%
Тээвэр ба агуулах	11.0%	25.2%	19.3%	8.0%	9.1%
Зочид буудал, ресторан	8.8%	14.7%	5.8%	-3.4%	6.9%
Мэдээлэл, холбоо	10.7%	24.2%	19.0%	7.5%	8.8%
Санхүү болон даатгал	-3.0%	19.5%	30.4%	-15.6%	-31.5%
Үл хөдлөх хөрөнгө	4.0%	-0.3%	8.3%	8.4%	-3.5%
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техник	6.3%	-12.1%	62.5%	11.1%	-3.7%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах	-0.5%	3.4%	3.1%	6.5%	0.9%
Боловсрол	3.5%	0.9%	6.3%	4.2%	2.2%
Эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	8.3%	9.4%	4.7%	2.9%	0.4%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	23.0%	6.8%	17.2%	-18.0%	54.2%

Эх сурвалж: Ундэсний Статистикийн Хороо

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2010 оны эцэст 4.09 их наяд төгрөгт (3.25 тэрбум ам.доллар) хүрч ДНБ-ий 31 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байна. Үүнээс уул уурхайн салбар 10.1 хувиар, боловсруулах салбар 11.4 хувиар, цахилгаан дулаан эрчим хүч, усан хангамжийн салбар 5.8 хувиар тус тус өссөн байна.

Уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлтөд голчлон нүүрсний олборлолт 91.8 хувиар өссөн, газрын тос шатдаг хий олборлолт 16.7 хувиар өссөн нь нөлөөлжээ. Харин боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлтөд голчлон хүнсний бүтээгдэхүүн 24 хувиар, төмрийн үйлдвэрлэл 26.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Уул уурхай, боловсруулах салбарын нийт аж үйлдвэрийн салбарт эзлэх хувь өмнөх оноос 4 пунктээр өсч 2010 оны эцэс гэхэд 69.4 хувьд хүрсэн. Харин боловсруулах салбар 21.5 хувь, цахилгаан дулаан эрчим хүч, усан хангамжийн салбар 9.1 хувийг тус тус эзэлж байна.


Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг авч үзвэл, нүүрс өмнөх жилээс 92 хувиар өсч 25.2 сая тонн, төмрийн хүдэр 132 хувиар өсч 3.2 сая тонн, газрын тос 16.7 хувиар өсч 2.2 сая баррельд тус тус хүрсэн байна. Харин нүүрсний экспортын хэмжээ 2009 онд 7.1 сая тонн байсан бол 2010 онд 134 хувиар өсч 16.6 сая тоннд хүрсэн нь үнийн дүнгээр 186.5 хувиар өсчээ.

Зэсийн баяжмалын үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 2 хувиар буурсан буюу харьцангуй тогтвортой байсан бол экспорт нь 53.5 хувиар өсч 770.6 сая ам.долларт хүрсэн байна. Алтны олборлолтын хэмжээ өнгөрсөн онд 38 хувиар буурсан статистик тоо гарсан нь Бороо Гоулд төслийн удаашралт болон 2011 оны 1 дүгээр сарын 1-нээс "Гэнэтийн ашгийн татвар"-ыг хүчингүй болгосонтой холбоотой юм.


Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлт нь маш болон бусад хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бууралт, хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт зэргээс хамаарч ихээхэн тогтвортгүй байлаа.

Боловсруулах салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг авч үзвэл үхрийн маш 37.4 хувиар буурч 5,800 тонн, хонинь маш 56 хувиар өсч 2,900 тонн, дээд гурил 54 хувиар өсч 33,500 тонн, нэгдүгээр гурил 34.3 хувиар өсч 97,600 тонн-д тус тус хүрчээ.

Бодит ДНБ-ий өсөлт (%)



Нэг хүнд ноогдох ДНБ (ам.доллар)



Эх сурвалж: Ундэсний Статистикийн Хороо

Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт эргэлт 2010 онд 6.2 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 53.5 хувиар өссөн байна. Үүнээс экспорт 53.8 хувиар өсч 2.9 тэрбум ам.доллар, импорт 53.3 хувиар өсч 3.3 тэрбум ам.долларт тус тус хүрсэн. Үүний үр дүнд, худалдааны алдагдал өнгөрсөн онд 379 сая ам.долларт хүрч өмнөх оноос 126.4 сая ам.доллар буюу 50.1 хувиар өссөн байна. Ингэснээр ДНБ-д эзлэх цэвэр экспорт 2009 онд 7.3 хувь байсан бол 2010 онд 9.4 хувь болж өссөн байна.

Нийт экспортын 80.8 хувийг уул уурхайн эрдэс бүтээгдэхүүн, 7.5 хувийг нэхмэл эдлэл, 6.2 хувийг үнэт эдлэл тус тус эзэлж байна. Эрдэс бүтээгдэхүүн дотроо нүүрсний экспортын орлого 2.9 дахин, төмрийн хүдэр 2.8 дахин тус тус өссөн бол боловсруулаагүй алт 42 хувиар буурчээ. Нүүрсний экспорт 2009 онд 7.1 сая тонн байсан бол энэ онд 134 хувиар өсч 16.6 сая тоннд хүрч, экспортын орлого нь 186.5 хувиар өссөн байна. Мөн төмрийн хүдрийн экспорт 3.5 сая тонн, алтны экспорт 5.1 тоннд тус тус хүрчээ. Өнгөрсөн онд нүүрсний экспорт зэсийн баяжмалаас давсан бөгөөд нүүрс нь ирэх хоёр жилийн хугацаанд дэд бүтцийн хөгжил болон тоног төхөөрөмж, бүтээн байгуулалттай холбоотойгоор экспортын тэргүүлэх түүхий эд хэвээр байна гэж таамаглаж байна.

2009 онд нийт экспортын 73.9 хувийг БНХАУ-тай хийсэн худалдаа эзэлж байсан бол өнгөрсөн онд 84.9 хувь болж өссөн байна. Харин хоёр дахь том экспортлогч орон болох Канадтай хийсэн худалдаа 7.8 хувиас 4.9 хувь болж буурсан байна.

Нийт экспорт (сая ам.доллар)

	2009	2010	2009-2010 %			
	Үнийн дүн	Хэмжээ	Үнийн дүн	Хэмжээ	Үнийн дүн	Хэмжээ
Нүүрс (мянган тонн)	306.3	7,113.2	877.6	16,635.1	187%	134%
Зэсийн баяжмал (мянган тонн)	501.9	587.0	770.6	568.7	54%	-3%
Төмрийн хүдэр (мянган тонн)	88.8	1,598.1	250.9	3,539.3	183%	122%
Алт (тонн)	308.5	10.9	178.3	5.1	-42%	-54%
Ноолуур (тонн)	160.0	5,199.9	173.7	4,080.4	9%	-22%
Нефть (мян. баррель)	115.6	1,938.5	154.9	2,078.7	34%	7%
Нийт экспорт	1,885.4		2,899.2		54%	

Эх сурвалж: Ундэсний Статистикийн Хороо

Импорт

Нийт импортын 33 хувийг ОХУ-тай, 31 хувийг БНХАУ-тай (тоног төхөөрөмжийн импортын татварын өсөлтөөр хурдассан), 6 хувийг Япон Улстай, 5.6 хувийг БНСҮ-тай хийсэн худалдаа эзэлж байна. Бараа бүтээгдэхүүнээр нь авч үзвэл, дизелийн импорт (тээвэр болон цахилгаан эрчим хүчний их хэмжээний хэрэглээнд зориулагдсан) өмнөх оны мөн үеэс 46 хувиар, автобензин 3.2 хувиар өсчээ. Мөн ачааны автомашины импорт 282 хувиар, суудлын автомашины импорт 132 хувиар тус тус өссөн байна. Хүнсний бүтээгдэхүүн дотроо голчлон гурил, гурилан бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, элсэн чихэр, цагаан будаа гэх мэт өргөн хэрэглээний хүнсний барааг импортлосон байна. Нийт импортын бүтцийг авч үзвэл 23 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 21 хувийг машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, 19.4 хувийг авто, агаар, төмөр замын тээврийн хэрэгсэл тус тус эзэлж байна. Харин хүнсний бэлэн бүтээгдэхүүн болон хими, төмөрлөг, ургамлын гаралтай зэрэг бүтээгдэхүүнүүдийн нийт импортод эзлэх хувь ойролцоо байна.

Нийт импорт (сая ам.доллар)

	2008	2009	2010	'08-'09 %	'09-'10 %	Бүтэц
Эрдэс бүтээгдэхүүн	964	570	759	-41%	33%	23%
Машин механик, төхөөрөмж	606	424	686	-30%	62%	21%
Тээврийн хэрэгсэл, эд анги	459	272	636	-41%	134%	19%
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	231	178	241	-23%	35%	7%
Химийн бүтээгдэхүүн	151	128	206	-15%	61%	6%
Төмөрлөг бүтээгдэхүүн	267	165	203	-38%	23%	6%
Хуванцар эдлэл	84	66	110	-21%	66%	3%
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	160	98	89	-39%	-9%	3%
Нийт импорт	3,245	2,138	3,278	-34%	53%	100%

Эх сурвалж: *Үндэсний Статистикийн Хороо*

УЛСЫН ТӨСӨВ

Экспортын гол эрдэс бүтээгдэхүүнүүдийн үнэ тогтвортой байсан нь өнгөрсөн оны төсөвт эерэг үр дүнг авчирсан бөгөөд сүүлийн хэдэн сард орлогоос давсан зардлыг үр ашигтайгаар зарцуулснаар оны эцэс гэхэд нэгдсэн төсвийн нийт орлого тусламжийн дун 3 их наяд 78.4 тэрбум төгрөг, нийт зарлага эргэж төлөгдөх цэвэр зээлийн дун 3 их наяд 76.3 тэрбум төгрөгт хүрч, төсвийн ашиг 2.2 тэрбум төгрөг болсон байна.

2011 оны төсөвт нэг тонн зэсийн үнийг дунджаар 8,425 ам.доллар, нэг унци алтны үнийг 1,350 ам.доллараас баагүй байхаар тусгасан.

Уг төсвийн төсөлд төсвийн нийт орлого тусламжийг 3 их наяд 305 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 7.3 хувиар, нийт зарлагыг 4 их наяд 84 тэрбум төгрөг (ДНБ-ий 52 хувьтай тэнцэх) буюу өмнөх оноос 32.8 хувиар өсгөн, нийт алдагдал 780 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 9.9 хувьтай тэнцэж байхаар тогтоожээ.

2011 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчингүй болсон алт, зэсийн үнийн өсөлтөд ноогдуулах “Гэнэтийн ашгийн татвар”-ыг хүчингүй болгосноор уул уурхайн татварын орлогын төсвийн нийт орлогод эзлэх хувь 2010 онд 32.3 хувь байсан бол 2011 онд 29.2 хувь болж буурахаар төлөвлөгджэй байна. Засгийн Газар экспортын орлогоос 2011 оны тогтвортжуулалтын санд 164.6 тэрбум төгрөгийг хуримтлуулахаар тооцсон. Харин зарлага талдаа, “Хүний хөгжил сан”-д 805.2 тэрбум төгрөг, 2010 оны үзүүлэлтүүдтэй харьцуулахад нийгмийн зардлыг 29 хувиар өсгөхөөр төлөвлөгджэй байгаа нь импортыг дэмжих, дотоодын инфляцийг хөөрөгдөх эрэлтийг урамшуулах хүлээлтийг бий болгож байна.

Улсын нэгдсэн төсөв (тэрбум төгрөг)

	2009	2010	2011*	'09-'10 %	'10-'11* %
Нийт орлого, тусlamжийн дүн	1,994.0	3,078.4	3,304.6	54%	7%
Татварын орлого	1,620.5	2,673.6	2,897.4	65%	8%
Татварын бус орлого	352.1	362.3	395.3	3%	9%
Хөрөнгийн орлого	2.3	8.0	3.3	246%	-58%
Тусlamжийн орлого	19.1	34.6	8.6	81%	-75%
Нийт зарлага, цэвэр зээлийн дүн	2,336.6	3,076.3	4,084.1	32%	33%
Цалин хөлс	575.9	650.6	789.5	13%	21%
Бараа үйлчилгээ	394.2	543.2	635.9	38%	17%
Зээлийн үйлчилгээний төлбөр	29.6	41.9	38.2	42%	-9%
Татаас ба ургал шилжүүлэг	788.4	1,035.5	1,682.8	31%	63%
Хөрөнгийн зардал	460.6	564.7	844.9	23%	50%
Цэвэр зээл	87.9	240.4	92.8	173%	-61%
Төсвийн тэнцэл	-342.6	2.2	-779.5		
Төсвийн тэнцэл/ДНБ %	-5.4%	0.0%	-9.9%		
Нийт зарлага/ДНБ %	37.1%	42.9%	52.1%		
Татварын ачаалал %	25.7%	37.3%	37.0%		

Эх сурвалж: Ундэсний Статистикийн Хороо

ИНФЛЯЦИ БА ВАЛЮТЫН ХАНШ

Инфляци

Өнгөрсөн 2010 онд хэрэглээний үнийн индексээр (ХҮИ) тооцсон жилийн инфляци 13 хувьд хүрч, үнээс хүнсний бүтээгдэхүүн 18.6 хувиар, орон сууц, усан хангамж, цахилгаан 12.7 хувиар, боловсролын үйлчилгээ 18.8 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн оны үнийн өсөлтийг 3 үед хувааж авч үзэж болохоор байна. Эхний үе буюу эхний 5 сард үнийн ерөнхий түвшин оны эхнээс 10.6 хувиар өссөн нь махны нийлүүлэлт огцом буурсантай холбоотой байлаа.


Засгийн газрын зүгээс инфляцийг бууруулах, махны үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор махны өргөтгесен худалдааг явуулж үнийг бууруулсны үр дүнд үнийн ерөнхий түвшин 6, 7 дугаар саруудад 4.3 хувиар буусан байна. Харин 3 дахь үе буюу 8 дугаар сараас хойш инфляци харьцангуй тогтвортож байсан боловч өнгөрсөн 12 дугаар сард өмнөх сараас эргээд махны үнэтэй холбоотойгоор 2.4 хувиар өссөн нь 11 дүгээр сарын 11 хувийн инфляцийг 13 хувьд хүргэж өсгөсөн юм.

Оны эцсийн инфляцийн түвшин Монголбанкны зорилтот 8 хувийн түвшнээс 5 пунктээр илүү гарчээ. Жилийн инфляцийн бүтцийг харвал 60 хувийг хүнсний инфляци дангаараа бүрдүүлж байгаа юм. Манай орон нийт хүнсний бүтээгдэхүүний хэрэглээнийхээ 45 хувийг импортоор оруулж ирж байгаагаас Монгол Улсын инфляцид гадаад эдийн засгийн шок хүчтэй нөлөөлсөн байна.

Экспортын орлого болон хөрөнгийн дотогшлох ургалтай холбоотой манай орны төгрөгийн ханш чангач байгаа нь инфляцийн дарамтыг бууруулж байгаа боловч эрэлтийн талын инфляци бий болох эрсдэл байсаар байна.



Инфляцийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Инфляцийн түвшин

	2009	2010
Хүнсний бараа, ундаа, ус	0.4%	18.6%
Согтууруулах ундаа, тамхи	20.2%	4.2%
Хувцас бөс бараа, гутал	10.9%	10.5%
Орон сууц, ус цахилгаан, түлш	0.6%	12.7%
Гэр ахуйн тавилга, бараа	9.2%	6.6%
Эмнэлгийн үйлчилгээ	9.7%	1.6%
Тээвэр	1.4%	1.3%
Холбоо, шуудангийн үйлчилгээ	4.8%	14.6%
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа	4.7%	2.4%
Боловсролын үйлчилгээ	9.9%	18.8%
Зочид буудал, зоогийн газар	11.1%	12.8%
Бусад бараа, үйлчилгээ	14.1%	4.2%
Үнийн ерөнхий индекс	4.2%	13.0%

Валютын ханш


Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2010 оны эхэн үед 1,444 байснаас хойш тасралтгүй чангарсаар оны эцэс гэхэд 1,257-д хүрч оны эхнээс 13 хувиар чангарсан. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтвортой чангаруулах зорилгоор Монголбанк гадаад валютын дуудлага худалдааг зохион байгуулсны үр дүнд гадаад валютын албан нөөц 2.3 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Монголбанк тогтвортой ханшийн дэглэмийг баримталж валютын дуудлага худалдаа зохион байгуулах замаар валютын интервенц хийж байгаа нь үр ашигтай байна. Энэхүү дуудлага худалдаагаар 2010 оны эцсийн байдлаар арилжааны банкуудаас 1.02 тэрбум ам.доллар худалдах санал ирсэнээс 585 сая ам.доллар буюу 57 хувийг нь худалдаж авсан байна.

Оны эцсийн байдлаар төгрөгийн евротой (EUR), Хятадын юаньтай (CNY), Оросын рубльтэй (RUB), Японы иентэй (JPY), Английн фунттэй (GBP) харьцах ханш харгалзан 19.7, 10, 13.3, 1.5, 15.1 хувиар тус тус чангарсан байна.

Монголбанк мөнгөний хатуу бодлого баримталж бодлогын хүүгээ харьцангуй өндөр буюу 11 хувь дээр 2010 оны 5 дугаар сараас хойш хадгалсан. Энэ нь зээл олголтыг бууруулах чиглэлд нөлөөлж, хэрэглээг хязгаарлахад чиглэгдэж байгаа бодлогын сонголт юм. Монголбанкны энэ оны мөнгөний бодлогын үндсэн зорилтод үнийг тогтвортой байлгах зорилгоор инфляцийг нэг оронтой тоонд байлгах, мөчлөгийн сөрөг нөлөөг бууруулах, бодит гарц, ажил эрхлэлтийг дэмжих чиглэл батлагдсан. Ингэснээр инфляци зорилтот түвшнээс бага байвал мөнгөний бодлогын хүү буурах орчин бүрдэх юм.

Ам.долларын дуудлага худалдаа (сая)



БАНКНЫ СИСТЕМ

Макро эдийн засгийн өсөлтийн зэрэгцээ банкны системийн нийт актив 4.42 их наяд төгрөгөөс (3.06 тэрбум ам.доллар) 41 хувиар өсч 6.25 их наяд төгрөг (4.97 тэрбум ам.доллар)-т хүрч, ДНБ-ий 76 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байна.

Банкны системийн нийт харилцах хадгаламж өнгөрсөн 2010 онд өмнөх жилийн 2.92 их наяд төгрөгөөс (2.02 тэрбум ам.доллар) 1.61 их наяд төгрөг буюу 55 хувиар өсч 4.53 их наяд төгрөгт (3.6 тэрбум ам.доллар) хүрсэн бол цэвэр зээлийн өрийн үлдэгдэл 2009 онд 2.4 их наяд төгрөг (1.66 тэрбум ам.доллар) байснаас 25 хувиар өсч, 2.99 их наяд төгрөг (2.38 тэрбум ам.доллар)-т хүрсэн байна. Үүний үр дүнд системийн зээл татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа 2009 онд 82 хувь байсан бол өнгөрсөн онд 66 хувь болж буурсан байна.

Банкны системийн чанаргүй зээлийн хэмжээ 432 тэрбум төгрөг (326 сая ам.доллар) 217 тэрбум төгрөг (173 сая ам.доллар) болж буурснаар нийт зээлийн багцын 7 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн жилийн хугацаанд M2 мөнгөний нийлүүлэлт 4.68 их наяд төгрөгт (3.72 тэрбум ам.доллар) хүрч өмнөх онтой харьцуулахад 62.5 хувиар өссөн байна. Ингэснээр санхүүгийн зах зээлийн хөгжлийг илэрхийлэгч үзүүлэлт буюу M2 мөнгөний ДНБ-д эзлэх хувь 2009 онд 44 хувь байснаас 2010 онд 57 хувь болж өсчээ.

Банкны системийн үндсэн үзүүлэлтүүд


	2008	2009	2010	'08-'09 %	'09-'10 %
Банкны тоо	16	15	14		
Төрийн эзэмшлийн банк	0	1	1		
Банкны систем (тэрбум төгрөг)					
Нийт актив	3,650	4,422	6,246	21%	41%
Нийт зээл	2,715	2,722	3,284	0%	21%
Чанаргүй зээл/Нийт зээл %	7.1	9.4	7.0		
Нийт харилцах, хадгаламж	2,269	2,917	4,530	29%	55%
M2 мөнгөний нийлүүлэлт	2,270	2,880	4,680	27%	62%
M1 мөнгөний нийлүүлэлт	647	651	1,158	1%	78%
Бараг мөнгө	1,623	2,229	3,522	37%	58%
ББСБ-ын тоо	132	177	187		
Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ	516	621	1,374	20%	121%
M2/ДНБ %	34.6%	43.7%	56.7%		
Нийт актив/ДНБ %	55.7%	67.1%	75.7%		
Нийт зээл/ДНБ %	41.4%	41.3%	39.8%		
Харилцах, хадгаламж/ДНБ %	34.6%	44.3%	54.9%		
Нийт өөрийн хөрөнгө/ДНБ %	5.2%	3.5%	4.6%		

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


2010 онд Голомт банк нийт актив, харилцагчдаас татсан харилцах, хадгаламж, зээлийн хэмжээгээрээ Монголын банк санхүүгийн систем дэх хамгийн том банк боллоо. Банкны системд тэргүүлэгч гол үзүүлэлтүүдийг дор тоймлон харуулав.




Нийт актив (тэрбум төгрөг)




Нийт харилцах, хадгаламж (тэрбум төгрөг)




Нийт цэвэр зээл (тэрбум төгрөг)




Нийт өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Гадаадын банк санхүүгийн байгууллагын хадгаламж (тэрбум төгрөг)



Нийт хөрвөх хөрөнгө (тэрбум төгрөг)



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголын Хөрөнгийн Биржийн Топ-20 индексийг зах зээлд тэргүүлэгч компаниудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон өдрийн дундаж мөнгөний эргэлтийг үндэслэн хагас жил буюу 6 сар тутамд шинэчилдэг.

МХБ Топ 20 Индекс 2010




2-ны өдөр 2.9 сая ширхэг арилжаалагдсан нь Монголын Хөрөнгийн Биржийн түүхэнд тохиосон хамгийн том хоёр үйл явдал байв.

Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нийт 336 компаниас 51 нь төрийн өмчит компани бөгөөд тайлант онд 22 компани бүртгэлээс гарч, зөвхөн 2 компани л нэмэлт нээлттэй хувьцаа гаргажээ.

Нийт бүртгэлтэй 336 компанийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ жилийн эхэнд 642 тэрбум төгрөг (495.1 сая ам.доллар) байснаас өсч, оны төгсгөлд 1.37 их наяд төгрөг (1.03 тэрбум ам.доллар)-т хүрчээ. Тайлант онд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1.37 их наяд төгрөгт хүрч ДНБ-ий 16.6 хувьд хүрсэн нь Өмнөх оны үзүүлэлтээс даруй 2.2 дахин өндөр байна.

Зах зээлийн үнэлгээ



Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс 2010 онд 136 хувиар өссөн нь MSCI Frontier болон MSCI EM Asia индексүүд 17 хувь, 13 хувиар тус тус өссөнтэй харьцуулашгүй өндөр хурдацтай өсөлт байлаа.

2010 оны туршид ТОП-20 индекс нээлтийн түвшин болох 6189.9-өөс 15040.0-д хүрж, жилийн төгсгөлд 14759.8 болжээ.

Багануурын нүүрсний уурхайн хувьцаа 2010 оны 4 сарын 8-ны өдөр 726.1 мянган ширхэг, мөн тус оны 11 сарын

Тайлантын үнэлгээ 92.9 тэрбум төгрөг (73.9 сая ам.доллар) байсан нь хувьцааны арилжаа, 30 тэрбум төгрөг нь Засгийн газрын бондоос тус тус бүрджээ. Өмнөх онтой харьцуулахад тайлант онд хувьцааны арилжааны хэмжээ 39.7 тэрбум төгрөгөөр буюу 171.1 хувиар өсчээ.

Өдрийн дундаж гүйлгээний хэмжээ 367 сая (292 мянган ам.доллар) байсан нь 2009 оны дунджаас ойролцоогоор 3 дахин их байв. Хувьцааны дундаж үнэ 974.6 төгрөг (77 ам.цент) байсан нь 2009 оны эцсээс 278 хувиар өссөн үзүүлэлт юм.

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ


ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэтийн зорилго

Монголын банкны салбарт тэргүүлэгч, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаатай, нэр хүнд бүхий найдвартай банк байна.

Эрхэм зорилго

Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлдэг, өндөр үр ашиг бүхий хөгжих чадвартай, нийгмийн хариуцлагатай, тэргүүлэгч банк байна.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төрийн эзэмшлийн бус хувийн хэвшлийн салбарт тэргүүлэгч байгууллагын хувьд Голомт банк нь компанийн засаглалын дээд хэм хэмжээ болон Олон Улсын Санхүүгийн Тайлагналын стандартыг дагаж мөрдөн үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй байлгахыг эрхэмлэн ажилладаг. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүнээ өргөжүүлэн 5 гишүүнтэй болгон хараат бус гишүүнийг томилсноор 2010 онд шинэчлэгдэн батлагдсан Банкны тухай хуулийн шаардлагыг биелүүлж, компанийн засаглалын хэм хэмжээний цогц байдлыг ханган ажиллаа.

2010 онд шинэчлэгдэн батлагдсан Банкны тухай хуульд нийцүүлэн Банк нь үндсэн дүрэм журмуудаа шинэчлэн сайжруулсан бөгөөд “Голомт банкны дүрэм”, “Хувь нийлүүлэгчдийн хурлын журам”, “ТҮЗ-ийн журам”-ыг шинэчлэн батлав. Мөн ТҮЗ-өөс “Голомт банкны зохистой удирдлагын бодлогын баримт”, “Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх журам”, “ТҮЗ-ийн хороодын журам”-ыг тус тус хэлэлцэн батлав.

ТҮЗ-д харьяалагдан үүрэг хариуцлага хүлээдэг Аудитын Хороо шинэчилсэн зохион байгуулалтад орж, улам хүчирхэгжихийн зэрэгцээ шинээр ТҮЗ-ийн дэргэд Эрсдэлийн Удирдлагын Хороог байгуулан ажиллаж, уг хороодын дүрэм журмыг шинэчлэн сайжрууллаа.

Компанийн засаглалын бүтэц



- Банк санхүү;
- Үл хөдлөх хөрөнгө;
- Инженер, Барилга;
- Худалдаа;
- Уул уурхай;
- Хөдөө аж ахуй;
- Хэвлэл мэдээлэл;
- Энтертэймэнт.

Групп нь 18 охин компани, олон улсын тэргүүлэгч түншүүдтэй хамтарсан 8 үйлдвэр, нийт 2300 гаруй ажилтантай.

Голомт банк нь удаан хугацааны турш группын хамгийн том бие даасан бүрэлдэхүүн хэсэг байсаар ирлээ.

Бодь группын санхүүгийн тайланг Хараат бус аудитын компани болох KMPG Самжонг Олон Улсын Санхүүгийн Тайллагналын Стандартын дагуу хянаж баталгаажуулдаг.

Санхүүгийн гол үзүүлэлтүүд

(мянган ам.доллар)	2008	2009	2010
Нийт актив	600,972	763,515	1,349,029
Хувь эзэмшигчийн өмч	55,440	59,535	104,701
Борлуулалт	83,019	80,239	124,225
Үйл ажиллагааны ашиг	16,667	16,421	22,292
Татварын дараах цэвэр ашиг	10,700	10,618	21,475

Төлөөлөн Удирдах зөвлөл

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувь нийлүүлэгчид болон банк санхүү, бизнесийн салбарт олон жил ажилласан, арвин туршлага бүхий таван гишүүнээс бүрддэг. 2010 онд ТҮЗ-ийн бүрэлдэхүүнийг дэлхийд тэргүүлэгч хөрөнгө оруулалтын сан болох Абу Дабигийн Хөрөнгө Оруулалтын Зөвлөлийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал ноён Марк Кютис болон Монголбанкны өрөнхийлөгч асан, Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (Монголд компанийн засаглалыг хөгжүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөө мэдээллээр ханган ажилладаг)-ийн Гүйцэтгэх захирал ноён Ж.Үнэнбат нарын банк санхүүгийн салбарт арвин туршлагатай 2 гишүүнээр өргөжүүллээ.

Төлөөлөн Удирдах зөвлөл



Зүүн талаас: М.Зоригт, Л.Болчуяаг, Д.Баясгалан, Марк Кютис, Ж.Үнэнбат

Аудитын хороо

Аудитын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон зөвлөлд ажлаа шууд тайлагнан ажиллах бөгөөд банкны үйл ажиллагаанд хяналтавих зорилгоор хяналтын систем, зохих баримтлал, тооцооны аргуудаар санхүүгийн бүхий л асуудалд шударга, үр дүнтэй санал зөвлөмжүүдийг гаргах замаар хяналтавин ажилладаг. Хороо нь Дотоод Аудитын Газарт хяналтавих үүрэгтэй бөгөөд хөндлөнгийн аудиторуудтай нягт хамтран ажиллана.

2010 оны Банкны тухай хуулийн дагуу Дотоод Аудитын Газрыг банкны удирдлагаас хараат бус байхаар зохицуулсан ба бүтцийг шинэчлэн, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох чиг үүргийг ТУЗ хариуцан ажиллахаар боллоо.

Эрсдэлийн удирдлагын хороо

Эрсдэлийн Удирдлагын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон, үйл ажиллагаагаа Зөвлөлд шууд тайлагнан ажиллах бөгөөд банкны эрсдэлийг урьдчилан илрүүлэх зорилгоор эрсдэлийн өсөлт болон хязгаар, тоон хэмжээ, хэмжилт дээр үндэслэн зохих санал зөвлөмжийг гарган ажилладаг.

Удирдлагын баг

Банк нь мэргэжлийн өндөр ур чадвар бүхий туршлагатай удирдлагын багтай бөгөөд энэ нь үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгээс тодорхой харагддаг. Тэдний зарим нь банк байгуулагдсан цагаас эхлэн өнөөг хүртэл ажиллаж байна. Бүтэц зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх захирал болон Тэргүүн дэд захирал, дэд захирал, газрын захирал, хэлтсийн захирал гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тайлант онд Монголын Менежментийн Холбооноос банкинд он удаан жил хүчин зүтгэж байгаа Тэргүүн дэд захирал Г.Ганболдыг "Монгол улсын банк санхүүгийн салбарын шилдэг удирдагч"-аар тодруулан цол, шижир алтан тэмдгээр шагналаа.


БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Банк 2007 онд бүтэц зохион байгуулалтаа бүхэлд нь шинэчлэн сайжруулж, томоохон бүтцийн өөрчлөлтийг хийсэн. Харин тайлант онд харилцагч төвтэй үйлчилгээ үзүүлэгч байгууллага байх үндсэн зорилгынхoo хүрээнд зарим нэг бүтцийн нэгжийг шинээр бий болгож, өөрчлөн зохион байгууллаа. Тухайлбал:

- Дотоод Аудитын Газар нь Салбар нэгжийн аудитын хэлтэс, Мэдээллийн технологи, зайн хяналтын хэлтэс, Бизнес аудитын хэлтэс гэсэн 3 хэлтэстэй болж өргөжлөө;
- Эрсдэлийн Удирдлагын Газрын Зээлийн Эрсдэлийн Хэлтсийн үйл ажиллагаа, хяналт болон гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэн хүчин чадлыг нь өргөжүүлэв;
- Хуучнаар Хөрөнгө оруулалтын хэлтсийг Хөрөнгө оруулалтын банкны газар болгон өөрчилж, Байгууллагын санхүүжилтийн, Шинэ хувьцаа болон өмч хувьчлалын, Хөрөнгийн удирдлагын гэсэн 3 хэлтэстэй болгон өргөжүүлэв;
- Хуучнаар Мэдээллийн Технологийн Хэлтсийг газар болгон өөрчилж, Системийн хэлтэс, Техник хангамжийн алба, Программын алба, Мэдээллийн аюулгүй байдлын алба гэсэн 4 нэгжид хуваав;
- Аюулгүй байдлын өндөр түвшний стандартыг хангасан цахим үйлчилгээний сувгийн өсөлт болон цахим банкны үйлчилгээний өргөжилттэй холбогдуулан Иргэдийн Банкны Газрын харьянд Цахим Банкны Хэлтсийг шинээр байгуулав.



БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



УДИРДЛАГЫН БАГ



Г.Ганболд

Үйл ажиллагаа хариуцсан
Тэргүүн Дэд захирал



М.Чимэгмөнх

Дэд захирал, Санхүүгийн
Удирдлагын Газрын захирал



Г.Ганхуяг

Дэд захирал, Хөрөнгийн
Удирдлагын Газрын захирал



Л.Оюун-Эрдэнэ

Дэд захирал, Байгууллагын
Банкны Газрын захирал



М.Чингүн

Дэд захирал, Эрсдэлийн
Удирдлагын Газрын захирал



Б.Энхтуяа

Дэд захирал, Иргэдийн Банкны
Газрын захирал



Б.Загал

Дэд захирал, Хөрөнгө Оруулалтын
Банкны Газрын захирал



Ж.Ганбат

Дотоод Аудитын Газрын захирал



Д.Мөнхтөр

Бүртгэл Тооцооны Газрын
захирал



Төлөөлөн Удирдах Зөвлөл

Д.Баясгалан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга
Л.Болдхуяг
М.Зоригт
Марк Кютис
Ж.Үнэнбат

Аудитын Хороо

Б.Моломжамц Дарга
Марк Кютис
С.Шинэжаргал Мэргэшсэн нягтлан бодогч
Б.Тамир
Ж.Үнэнбат

Эрсдэлийн Удирдлагын Хороо

Л.Болдхуяг Дарга
М.Зоригт
Жон П.Финиган
Ж.Үнэнбат
М.Чимэгмөнх
М.Чингун Нарийн бичгийн дарга

Удирдлагын Баг

Жон П.Финиган Гүйцэтгэх захирал
Г.Ганболд Тэргүүн дэд захирал
Г.Ганхуяг Дэд захирал, Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал
М.Чимэгмөнх Дэд захирал, Санхүүгийн Удирдлагын Газрын захирал
Л.Оюун-Эрдэнэ Дэд захирал, Байгууллагын Банкны Газрын захирал
Б.Энхтуяа Дэд захирал, Иргэдийн Банкны Газрын захирал
М.Чингун Дэд захирал, Эрсдэлийн Удирдлагын Газрын захирал
Б.Загал Дэд захирал, Хөрөнгө Оруулалтын Банкны Газрын захирал
Ж.Ганбат Дотоод Аудитын Газрын захирал
Д.Мөнхтөр Бүртгэл Тооцооны Газрын захирал
Н.Цэрэндаваа Мэдээллийн Технологийн Газрын захирал
Д.Батбилэг Картын Удирдлагын Төвийн захирал

ХҮНИЙ НӨӨЦ

Банкны ололт амжилтын үндэс нь чадвартай, мэргэжлийн ур чадвар бүхий, үнэнч шударга, бүтээмж өндөртэй ажилтнууд юм. Өнгөрөгч 2010 онд банкны хүний нөөцийн бодлого ажилтнууддаа урт хугацаанд тогтворт суурьшилтай, ур бүтээлтэй, бүтээмжтэй ажиллах таатай орчинг бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

Оны эцэст банкны ажилтнуудын тоо 1068-д хүрсэн ба жилийн туршид нийт 201 ажилтан шинээр ажилд авчээ. Нийт ажилтнуудын 61 хувь нь банкны үйлчилгээг 70 салбар тооцооны төвөөр дамжуулан харилцагчадад хүргэж, 39 хувь нь төв алба болон дэмжих үүрэг хүлээн ажиллаж байна.

Хүний Нөөцийн Үндсэн Үзүүлэлтүүд

	2009	2010
Ажилтны тоо	867	1068
Салбар, тооцооны төвүүд	60%	61%
Төв алба	40%	39%
Хүйсийн харьцаа (эрэгтэй/эмэгтэй)	30-70	30-70
Салбар, тооцооны төвүүд	23-77	21-79
Төв	41-59	40-60
Дунд түвшний удирдлага	45-55	45-55
Дээд түвшний удирдлага	50-50	70-30
Мэргэжлийн зэрэг		
Бакалаврын зэрэг	78%	76%
Магистрийн зэрэг	10%	14%
Тусгай мэргэжил	12%	10%
Нас		
< 25	25%	33%
25-34	56%	52%
36-44	14%	12%
45-54	4%	3%
>54	1%	1%

Хүний нөөцийн менежментийн тулгуур ойлголтын нэг болох Ажлын шинжилгээг банкны 260 гаруй ажил, албан тушаалд хийсэн бөгөөд уг ажлын үр дүнд бизнесийн зорилго, зорилттой уялдсан оновчтой хүний нөөцийн төлөвлөлтийг хийж, албан тушаалын зэрэглэл, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг оновчтой болгох ажлууд хийгдэж байна.

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг оновчтой болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх, цалин урамшууллын оновчтой систем нэвтрүүлэх зорилгоор харилцагчийн үйлчилгээний ажилтаны албан тушаалд гүйцэтгэлээр цалинжих системийг амжилттай нэвтрүүллээ.

Тайлант онд манай 80 орчим тэргүүний ажилтан Төр засгийн шагнал болон Сангийн Яам, Монголбанк, Монголын Залуучуудын Холбоо, Улаанбаатар Хотын Захирагчийн албанаас тус тус шагнагдлаа.

Монгол Улсын эдийн засаг өсөхийн хирээр банк санхүүгийн салбарт ажиллах хүний нөөцийн эрэлт хэрэгцээ, тавигдах шалгуур шаардлагууд улам өндөрсөх болсон. Банкны ирээдүйн чадварлаг ажилтнуудыг сонгон шалгаруулж, бэлтгэх зорилгоор хүний нөөцийн сонгон шалгаруулалтын цогц арга техникийг албан тушаал бүрийн онцлогт тохируулан амжилттай нэвтрүүлсэн.

Мөн компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд ажилтнуудад үзүүлэх нийгэм ахуйн хөнгөлөлттэй үйлчилгээг албан тушаалын онцлогт тохируулан багц хөтөлбөр болгон үзүүлж байна. Ажилтнуудын урт хугацааны амьдралын баталгаа болох “Тэтгэврийн Ууган Сан”, “Орон сууцны хөнгөлөлттэй зээл”, “Ажилтнуудад Хувьцаа Эзэмшүүлэх Хөтөлбөр” зэргийг амжилттай нэвтрүүллээ.




Сургалт, хөгжил

Тасралтгүй суралцагч байгууллагын хувьд банкны хамт олны эгнээнд шинээр орсон болон олон жил ажиллаж буй нийт ажиллагсадынхаа мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилготой тасралтгүй үргэлжлэх олон төрлийн сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг “бэлтгэх”, “хөгжүүлэх”, “мэргэшүүлэх” гэсэн гурван түвшинд хэрэгжүүллээ.


Сургалт хөгжлийн тоон үзүүлэлт

	2008	2009	2010
Сургалтын зардал /төгрөг/	101,689,712	144,940,942	190,555,054
Сургалтын тоон мэдээлэл	Сургалтад оролцогч	Сургалтын цаг	Сургалтад оролцогч
Хилийн чанад дахь сургалт	15	800	20
Дотоод сургалт	1,723	19,044	1518
Гадаад сургалт	256	4,949	581
Нийт	1,994	24,793	2,119
			21,858
			2,595
			46,123

Сургалтанд хамрагдсан ажилтны тоо



Сургалтын цаг



Тайлант онд нийт 2,595 сургалтын хөтөлбөр хэрэгжүүлснээр нэг ажилтанд дунджаар 43 цагийн сургалт ноогдож байна.

- Ажилд шинээр томилогдсон болон албан тушаал шилжсэн ажилтан бүрийг ажлын байранд дадлагажуулах хөтөлбөрт хамруулахын зэрэгцээ ажилтнуудын туршлага солилцох хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн;
- Харилцагчийн үйлчилгээний ажилтнуудад зориулан тэдний үүрэг, үйл ажиллагааны гүйцэтгэл, ажлын үр өгөөжийг сайжруулах зорилгоор 8 удаагийн сургалт зохион явуулав;
- Ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх чиглэлд хилийн чанад дахь сургалтуудыг онцгойлон авч үздэг ба өнгөрсөн онд нийт 24 ажилтан Европ, АНУ болон Азийн орнуудад сургалтын хөтөлбөрт хамрагдлаа;
- Уламжлалт танхимын сургалт болон дотоод сургалтуудаа зөвхөн банкныхаа сургалтын төвд бус гадны сургалтын төвүүдтэй хамтран зохион явуулсан;
- 11 ажилтан Санхүүгийн Мэдээллийн Агентлагаас ирсэн шинжээч гэх зэрэг хилийн чанадаас ирсэн сургагчтай нарийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрт хамрагдлаа;
- Ажилтнуудынхаа ур чадварыг нэмэгдүүлэх, хооронд нь туршлага солилцох орчныг бүрдүүлэх зорилгоор төрөл бүрийн мэргэжлийн уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулаа;
- Салбарын нэгжийн удирдлагуудыг хөгжүүлэх зорилгоор “Шилдэг менежер” уралдааныг банкны хэмжээнд зохион явууллаа;
- Ажилтнуудын албан тушаалын төлөвлөлтийн хүрээнд албан тушаал бүрийн онцлогт тохирсон Харилцааны менежер бэлтгэх хөтөлбөр, Хянач нягтлан бодогч бэлтгэх хөтөлбөр зэргийг Банкны бүх салбар нэгжийн хүрээнд амжилттай зохион байгуулав.

ДЭД БҮТЭЦ

Тайлант онд харилцагчдын мэдээллийн найдвартай байдлыг сайжруулах зорилгоор сүлжээний нууцлал хамгаалалтыг сайжруулах төслийг хэрэгжүүлсэн.

Картын онлайн төлбөр тооцооны програмыг 3D Secure нууцлал хамгаалалттай болгон шинэчилсэнээр, 3D нууцлал бүхий карт гаргагч банкны хэрэглэгч манай банкны картаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар онлайн гүйлгээ хийх үеийн найдвартай байдлыг нь баталгаажуулж өгсөн. Мөн түүнчлэн Банк нь интернэт худалдаанд хийгдэж буй онлайн төлбөр тооцоон дахь картын луйврын гүйлгээг бууруулах зорилгоор аюулгүй байдлын "Verified by Visa" болон "MasterCard Secure code" стандартуудыг үе шаттайгаар хэрэгжүүллээ.

Эдийн засгийн эрчимтэй өсөлт, банкны үйл ажиллагааны өргөжин тэлэлттэй холбоотой банкны үндсэн системээ сайжруулж, банкны бүртгэлийн програмд санхүүгийн зах зээл дээрх валют, үнэт металлын арилжаа, банк хоорондын зээл, үнэт цаасны арилжааны хэлцэл хийх, хянах, төлбөр хийх, баталгаажуулах, үр ашигтай удирдах ажлуудыг автоматжуулсан "Grats" цогц систем, гадаад худалдаа бүртгэл, хяналт мэдээллийн удирдлагыг автоматаан "Grafts" цогц системүүдийг амжилттай нэвтрүүлсэн.

Дотоодын банкны салбарт сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг анхлан нэвтрүүлэгч байр сууриа хадгалж, дэлхийн зах зээлд анх удаа China UnionPay юаний карт, гадаадад суугаа Монгол иргэдэд зориулсан онлайнаар данс нээх, удирдах үйлчилгээг нэвтрүүлсэний зэрэгцээ Монгол Улсад анх удаа хосолсон валюттай карт нэвтрүүлэх төслийг амжилттай нэвтрүүллээ.

Монголбанк нь "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэл"-д тусгасан "Төлбөрийн картын гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулах клирингийн үйлчилгээг нэвтрүүлэх" үүргийн хүрээнд "Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ"-г нэвтрүүлсэн ба уг сүлжээнд Голомт банк нэгдэн орлоо. Монгол Улсын төлбөрийн картын бэлэн бус гүйлгээний 60 орчим хувийг гүйцэтгэдэг Голомт банк, түүний дэд гишүүд болох Хас банк, Төрийн банк, Капитрон банкууд уг нэгдсэн сүлжээнд хамтдаа нэгдсэнээр "Нэг карт-Нэгдсэн сүлжээ" зарчим Монгол Улсын иргэн бүрт хүрч, үйлчлэх боломж бүрэн утгаараа хэрэгжиж эхэллээ.

Ингэснээр, иргэдэд учирдаг бэлэн мөнгөтэй холбоотой эрсдэл багасч, банк, санхүүгийн үйлчилгээ илүү хялбар, найдвартай, шуурхай хүрч, бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ өсч, иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдэнэ. Мөн картаар үйлчлэгч аж ахуйн нэгж байгууллагууд, жижиг дунд бизнес эрхлэгчид бизнесийн цар хүрээгээ нэмэгдүүлэх, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ соёлтой орчинд нийтийн хүртээл болгох, харилцагч татах, банкны үйлчилгээг хамгийн ойроос авч, улмаар бэлэн мөнгөний хэрэглээ багасч, эдийн засаг дахь мөнгөний эргэлт хурдасна.

Хамтын ажиллагааныхаа хүрээнд МИАТ (Монголын Иргэний Агаарын Тээвэр) компанийтай хамтран онгоцны тасалбарыг онлайнаар захиалах үйлчилгээг Монгол Улсад анх удаа нэвтрүүллээ.

Үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ажилтнуудын бүтээмжийг дээшлүүлж ажлын уялдаа холбоог сайжруулах үүднээс дотооддоо Sharepoint систем нэвтрүүлсэн ба үйл ажиллагааны дотоод програм хангамжууддаа шинэчлэн сайжруулалт хийв.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Банк нь хүн ам ихээр суурьшсан, тогтвортой хөгжлийн ирээдүй харагдаж буй буюу Монгол Улсын ирээдүйн хөгжил цэцэглэлтийн зүрх болсон газар нутагт салбар сүлжээгээ өргөжүүлж, иргэдэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагаагаа хөгжүүллээ. Тайлант онд 18 салбар нэгж шинээр нээсний 7 нь Улаанбаатар хотод, 11 нь Сэлэнгэ, Ховд, Баян-Өлгий, Дорнод болон Өмнөговь аймгуудад нээгдэж салбар сүлжээний тоо 70-д хүрсэн бөгөөд 39 салбар нэгж Улаанбаатар хотод, 31 салбар нэгж хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

Монголын эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн хөдөлгүүр болсон уул уурхайн салбарт ажиллаж буй нийт ажилтан албан хаагчид, бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжүүдэд банкны иж бүрэн үйлчилгээг хүргэх зорилгоор Өмнөговь аймгийн Гурван Тэс, Ханбогд сумд болон Ховд аймгийн Хөшөөтийн уурхай, Өмнөговь аймгийн Таван Толгойн орд газарт банкныхаа салбар нэгжийг шинээр нээсэн юм. Мөн Моннис цамхаг болон Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн Төв байранд салбар нэгжүүдийнхээ үйл ажиллагааг эхлүүллээ. Оюу Толгой төслийн хүрээнд бид өөрсдийн салбараа нээхээр барилгын ажил ид дундаа явж байна. Энэ мэтчилэн харилцагчид хүргэх үйлчилгээнийхээ чанар, үр өгөөжийг нэмэх, цаашлаад хийгдэж буй гүйлгээний хурдыг нэмэгдүүлэх, дэвшилтэт аргыг нэвтрүүлэх зэргээр үйлчилгээнийхээ чанарыг сайжруулахад анхааран ажиллаж байна.



Бэлэн мөнгөний машиныхаа тоог 2 дахин нэмэгдүүлж 100-д хүргэсэн ба банкны системийн хэмжээнд буй бэлэн мөнгөний машины тоонд эзлэх хувь 28 хувь боллоо. 2010 онд Голомт банкны картаар үйлчлэгч байгууллагын тоо 18 хувиар нэмэгдэж, Монгол Улс дахь хамгийн олон картаар үйлчлэгч байгууллагатай банк гэсэн байр сууриа хадгаллаа. Банк нь 760 мянган карт эзэмшигчдийнхээ өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж, Монголбанкны системийн картын гүйлгээний 60 гаруй хувийг дангаар гүйцэтгэж байна. Голомт банкны картаар үйлчлэгч байгууллагуудын картын гүйлгээ 145 хувиар, олон улсын банкуудын картаар үйлчлүүлсэн гүйлгээний тоо 53 хувиар тус тус нэмэгджээ. Тайлант онд картын гүйлгээнээс олох орлого 60 хувиар нэмэгдсэн байна.

Банк нь харилцагчийн хүссэн загварыг картын нүүрэнд хэвлэдэг "Нандин" картыг зах зээлд нэвтрүүлснээр Мастеркарт Ворлдвайд байгууллагын "Оны шилдэг бүтээгдэхүүн нэвтрүүлэгч" шагналыг хүртсэн юм.

БНСУ-д ажиллаж амьдарч буй Монголчуудад банкны иж бүрэн үйлчилгээг хүргэн ажилласны зэрэгцээ, Гадаадад Ажиллах Хүч Илгээх Төвтэй хамтран Сөүл, Ансан хотууд дахь монголчуудын дунд соёл урлагийн арга хэмжээ болон сурталчилгааны өдөрлөгийг зохион явууллаа. Мөн Банк нь хилийн чанадад амьдарч буй Монгол иргэдэд зориулан онлайннаар данс нээн удирдах боломжийг санал болгож, онлайннаар хадгаламж нээх үйлчилгээг нэвтрүүлсэн юм.

Дэвшилтэт техник технологи бүхий үйлчилгээг анхлан нэвтрүүлэгчийн хувьд Монголын банк санхүүгийн зах зээлд анх удаа дараах хэд хэдэн бүтээгдэхүүн үйлчилгээг шинээр нэвтрүүллээ.

- China UnionPay юаний карт (БНХАУ-ын газар нутгаас гадна анх удаа);
- Харилцагчийн хүссэн зургийг хэвлэх "Нандин" зурагт карт;
- Төгрөг-Еврогийн хосолсон валюттай карт;
- Банк даатгалын хамтарсан үйлчилгээ.

Банк нь 24 цаг x 7 хоног x 365 хоног зарчимд суурилсан интернэт банк, мобайл банк, мессэж банкны үйлчилгээнүүдийг нэгтгэсэн цахим банкны үйлчилгээгээ өргөжүүлэхэд онцгойлон анхаарал хандууллаа. Тайлант онд интернэт банк хэрэглэгчдийн тоо 72 хувиар өсч, интернэт гүйлгээний тоо 82 хувиар нэмэгдлээ. Банк нь интернэт банкны үйлчилгээг сайжруулан шинэчилж, үйлчилгээний хүртээмж, боломжуудыг дараах байдлаар дээшлүүллээ.

- Аюулгүй байдлын хяналт болон хэрэглэгчийн эрхийн шалгуураа сайжрууллаа;
- WAP -д суурилсан банкны үйлчилгээг өргөжүүллээ;
- Мессэжээр банкны ATM, салбар сүлжээний мэдээлэл болон харилцагчийн сэтгэл ханамж, харилцагчийн үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтийг авч эхэллээ;
- "Нандин" карт болон бэлгийн картуудын онлайн захиалгыг хэрэгжүүлэв;
- МИАТ болон Монголын Төмөр Замтай хамтран тасалбарын онлайн захиалгын үйлчилгээг нэвтрүүлэв.

Банк нь харилцагч бүрийнхээ онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хамгийн уян хатан нөхцөлтэйгээр банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээг санал болгон ажиллаж байна.

Жижиг дунд бизнесийн зээл

Монгол Улсын Засгийн Газар 2010 оныг "Бизнесийн орчны шинэтгэлийн жил" болгон зарласантай холбогдуулан жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин тэдний бизнесийн хэрэгцээ шаардлагад тохируулан банкны бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлийг илүү уян хатан болгох бодлогын хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдэд хамгийн боломжийн нөхцөлөөр бизнесийн зээлийг санал болгож, дэмжлэг үзүүллээ.

Мөн Банк хөдөө аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлж, ургац хураалт болон тариалалт, уринш бэлтгэх зэрэг онцгой хэрэгцээ шаардлагын үеүдэд нь бизнесийн зээл олгож хөдөө аж ахуйн салбарт олгох зээлийн хэмжээгээ багагүй нэмэгдүүлсэн ба газар тариалангийн эх нутаг болсон Сэлэнгэ аймагт салбараа шинээр нээсэн юм. Бус нутгийн эдийн засаг болон жижиг дунд бизнесийн салбарыг хөгжүүлэх, Монгол Улсын үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн Газар болон дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран дунд болон урт хугацаат зээлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлсэн дунд болон урт хугацааны төсөл хөтөлбөрүүд нь:

- Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкны санхүүжилт бүхий "Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төсөл";




- Олон Улсын Хөгжлийн Ассоциаци буюу Дэлхийн Банкнаас санхүүжилттэй “Хувийн хэвшлийг хөгжүүлэх төсөл”;
- ХХААХҮЯ болон Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сангаас санхүүжилттэй “Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх” болон “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”;
- ХХААХҮЯ болон Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сангаас “Улаанбаатар дахь Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”;
- Монгол улсын Засгийн Газрын Хөрөнгө Оруулалт, Хөгжлийн Сангийн санхүүжилттэй “Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг үйлдвэрлэл эрхлэгчдэд хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох төсөл”;
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимиын Ногоон Зээлийн Баталгааны Сантай хамтарсан Нидерландын Засгийн Газраас санхүүжилттэй “Эрчим хүчний хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” болон “Жижиг дунд бизнесийг дэмжих, зээлийн баталгаа гаргах хөтөлбөр”;
- Германы Техник Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Бус Нутгийн Эдийн Засгийг Дэмжих Хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Зээлийн баталгааны сангийн төсөл”;
- Мерси Кор Олон Улсын Байгууллагатай хамтарч “Орон нутаг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, зээлийн баталгаа гаргах” төсөл;
- Азийн Хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх” төсөл.

Банк нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт болон зах зээлийн өргөжилттэй уялдуулж төслийн санхүүжилтийн хэмжээ, хамрагдах төслийн цар хүрээг өргөтгэн, хамтран ажиллагч олон улсын байгууллагуудтай харилцаа холбоогоо өргөжүүлж байна.

Орон сууцны зээл

Банк Монгол Улсын Засгийн Газраас зарласан “4000 болон 100000 айлын орон сууц хөтөлбөр”-г идэвхтэй дэмжин, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж бага дунд орлоготой иргэдийг орон сууцтай болгох зорилт тавин ажилласны дүнд 2010 онд 3500 гаруй айл өрхийг орон сууцжуулж, орон сууцны зээлийн багцыг 106 хувиар өсгөж, 80.1 тэрбум төгрөгт хүргэж ажиллалаа.

Орон сууцны зээл (тэрбум төгрөг)



Банк нь Монгол орны хөгжилд томоохон хувь нэмэр оруулж буй үнэ цэнэтэй харилцагч байгууллагуудынхаа ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тэдэнд хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээл авах боломжийг олгосны зэрэгцээ барилгын компаниудтай хамтран ажиллаж иргэдэд чанартай орон сууцыг зээлээр худалдан авах боломжийг давхар бүрдүүллээ.


Мөн зөвхөн орон сууц худалдан авахад зориулан зээл олгохоос гадна хувийн сууц худалдан авах, барьж

дуусгах зээлийн бүтээгдэхүүнийг шинээр гарган харилцагчдад бүх орон нутгийн салбар нэгжүүдээрээ дамжуулан олгож байна.

Хэрэглээний зээл

Эдийн засаг эрчимтэй өргөжин тэлж, дунд орлоготой иргэдийн хүрээ нэмэгдэхийн хэрээр харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн автомашин болон гэр ахуйн тавилгын лизингийн зээл, түр зуурын санхүүгийн хэрэгцээгээ хангах цалингийн болон хадгаламж барьцаалсан зээлүүдийг илүү уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр олголоо.

Хэрэглээний зээл (тэрбум төгрөг)



2010 онд бөөний болон жижиглэн худалдааны салбарын борлуулалт өмнөх онтой харьцуулахад 62.4 хувир өссөн бөгөөд уг борлуулалтын өсөлтөнд Банк өөрийн хувь нэмрийг оруулж нийт 26,000 харилцагчдад богино хугацааны эргэлт бүхий 140.8 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийг олгосон байна.

Харилцагчдад банкны үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, тэдний хүсэл шаардлагад нийцэн бүтээгдэхүүн үйлчилгээг зөв сонгож хүргэх тал дээр анхааран ажиллаж, зээлийн бүтээгдэхүүний талаар сургалт, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж ажиллалаа.

Банк харилцагчдад найдвартай, сонголт өргөн гэр ахуйн бараа, автомашин худалдан авахад нь зориулж нийт 150 гаруй гэрээт аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж харилцагч, нийлүүлэгчдийг холбох гүүр болж байна.

2010 онд Банкны нийт актив 1573 тэрбум төгрөгт хүрч, Монгол Улсын хамгийн том банк болсон нь бидэнд итгэж үйлчлүүлдэг мянга мянган харилцагч үйлчлүүлэгчид, аж ахуйн нэгж байгууллагуудын итгэлийн ач тус юм.

БАЙГУУЛЛАГАД ХАНДСАН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2010 онд Монгол улсын хувьд эдийн засаг идэвхжиж бүхий л салбарын үйл ажиллагаа эрчимжин сэргэж, уул уурхайн томоохон гэрээ батлагдаж, гадаадын зах зээлд хөрөнгө босгох үйл ажиллагааны эхлэл тавигдлаа. Улс орны эдийн засгийн өсөлттэй уялдуулан банкны байгууллагад үзүүлэх үйлчилгээний цар хүрээ мөн өсөн нэмэгдлээ.

Голомт банкны Байгууллагын Банкны Газар нь дотоод, гадаадын томоохон бизнес эрхлэгчдэд харилцах, хадгаламж, зээл, зээлийн шугам, хамтарсан зээлжүүлэлт, аккредитив, тендерийн баталгаа, баталгааны шугам, төлбөрийн баталгаа, дахин санхүүжилт, төслийн санхүүжилт зэрэг өргөн цар хүрээтэй банкны үйлчилгээг төвлөрүүлэн хүргэж, банк-харилцагч байгууллагын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэн, санхүүгийн түншлэлийг амжилттай хэрэгжүүлж байна.

Банкны зүгээс байгууллагад үзүүлэх уламжлалт үйлчилгээнээс гадна тэдний бизнесийн үйл ажиллагаанд банкны үйлчилгээг ойртуулах зорилгоор салбар нэгж тухайн байршилд нээх, улмаар байгууллагын удирдлага, албан хаагчдад орон сууц, хэрэглээний хөнгөлөлттэй зээл, цалингийн болон кредит карт, интернэт банк, мобайл банк зэрэг багц үйлчилгээг үзүүлж байгаа нь харилцагч байгууллагын бизнесийн амжилтыг ихээхэн дэмжиж буйн илрэл юм.

2010 онд Голомт банк нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан үндэсний томоохон бизнес эрхлэгчид, төрийн яам тамгын газрууд, агентлагууд, түүний харьяа зохицуулах газрууд, Монгол Улсад суугаа элчин сайдын яамд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдэд хүрч үйлчлэх, тэдгэрийн үйл ажиллагааны онцлогт нь уялдуулсан банкны үйлчилгээг санал болгох, хамтран ажиллах тал дээр ихээхэн анхаарал хандуулж ажиллалаа.

Тухайлбал, банкны үйлчилгээг эдийн засгийн салбар бүрийн онцлогт нийцүүлэн хүргэж, мөн салбарын яам тамгын газартай хамтран ажиллаж, бизнес эрхлэгчдэд ойртон ажилласан нь мөн 2010 оны онцлог байлаа. Үүний заримыг дурьдвал, дэд бүтцийн салбарын бизнес эрхлэгчдэд идэвхтэй үйлчилгээ үзүүлж, салбарын удирдлага ЗТБХБЯ, АЗГ-тай хамтран замын салбарт үйл ажиллагаа эрхлэдэг компаниудтай уулзалт семинар зохион байгуулж, улсын төсвөөс санхүүжилттэй гэрээт ажил гүйцэтгэж буй компаниудад бүх төрлийн тендерийн баталгаа, банкны баталгаа, баталгааны шугам гаргах, төлбөрийн баталгаа, аккредитив, эргэлтийн хөрөнгийн зээлийн санхүүжилт зэрэг банкны үйлчилгээ үзүүлсэн.



Мөн түүнчлэн Байгууллагын Банкны Газар нь Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын компаниудтай өргөн хүрээнд хамтран ажиллаж харилцаагаа өргөжүүлж ирлээ. 2010 онд бид зөвхөн банкны үйлчилгээ үзүүлээд зогсохгүй Монгол Улсаа сурталчлан таниулах, улс хоорондын соёлын харилцааг хөгжүүлэхээр Гадаадад Ажиллах Хүч Илгээх Төв болон Боловсрол суваг төлөвлөхийн хамтран БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа иргэдийн дунд “Эргэх холбоо” ТВ караоке нэвтрүүлэг, ТЕГ-тай хамтран “Шилдэг татвар төлөгчдийн хоорондо нөхөрсөг шатрын тэмцээн”, Дипломат байгууллагуудын хооронд Гадаад Хэргийн Яамтай хамтран “Хөл бөмбөгийн нөхөрсөг тэмцээн”, БНЧУ-ын элчин сайдын яамтай хамтран “Гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээн” зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулж ирлээ.

Хувьсан хөгжиж буй бизнес эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй банкны бүтээгдэхүүний төрөл нэмэгдсээр байна. Банк нь төвлөрсөн төсвөөс болон дотоод гадаадын эх үүсвэрээс санхүүжилттэй, гэрээ хэлэлцээрийн дагуу тусгай санхүүжилттэй дэд бүтцийн төслүүдэд банкны үйлчилгээг амжилттай үзүүлж ирсэн ба цаашид ч олон улсын жишигт нийцэхүйц өргөн цар хүрээтэй бүтээгдэхүүн хөгжүүлэн ажиллах болно.

Уул уурхайн салбарт хандсан банкны үйлчилгээ

Голомт банкны Уул Уурхайн Хэлтэс нь үүсгэн байгуулагдсанаас хойш Монголын томоохон уул уурхайн компаниудад банкны цогц үйлчилгээг найдвартай хүргэсээр байгаа билээ. Голомт банк нь байгууллагын банкны үйлчилгээнд тэргүүлэгч банкны хувьд уул уурхайн салбарт өндөр ач холбогдол өгч, салбарын мэдлэг туршлага бүхий мэргэжилтнүүдээрээ дамжуулан компани тус бүрийн онцлогоос хамааран тэдний бизнест тохирсон үйлчилгээг хүргэдэг. Мөн түүнчлэн Голомт банк нь уул уурхайн хөрөнгө оруулагч байгууллага, банк, санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг ба уул уурхайн хөрөнгө оруулалт хүсч буй байгууллагуудад хөрөнгө босгох буюу хөрөнгө оруулах, хамтран ажиллах талуудын гүүр болж өгөх боломжтойгоороо давуу талтай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөрөнгө Оруулалтын Банкны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хувийн болон төрийн эзэмшилт компаниуд, төрийн агентлагууд, байгууллагуудад санхүүжилтийн эх үүсвэрээр хангахад зуучлах, тохиролцох, хөрөнгө босгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэх болно.

Хөрөнгө оруулалтын бизнесийн хэтийн зорилго нь хөрөнгө оруулалтын банкны хамгийн чанартай үйлчилгээгээр эрхэм харилцагчдынхаа бизнесийн хөгжлийг дэмжиж, улмаар урт хугацааны харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгоход оршино. Банкны өндөр туршлага, мэргэжлийн ур чадвар бүхий хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд, банкируудаас бүрдсэн баг нь харилцагч нэг бүрийнхээ эрэлт хүсэлтэнд тулгуурласан үйлчилгээг хүргэнсээр уг урт хугацааны харилцааг бүтээх юм.

Харилцагч нэг бүрийнхээ бизнесийн үйл ажиллагаа, стратегийн талаар нарийвчилсан ойлголтыг авч ажилласнаар бид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, үүний үндсэн дээр тэдгээрт тохирсон санхүүжилтийн стратегийг боловсруулан, түргэн шуурхай үйлчилгээ боломжтой болдог.

Голомт банкны Хөрөнгө Оруулалтын Банкны Газрын үйл ажиллагааны хүрээ:

- Санхүүжилт босгох, хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, зээлийн болон эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөн шинэ зах зээлд нэвтрэх болон үндсэн бизнесийн өсөлтийн санхүүжилт;
- Боломжит хөрөнгө оруулагчидтай харилцаа холбоог тогтоох;
- Монголын зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын танилцуулга, судалгааг хийх;
- Хамтын хөрөнгө оруулалтыг бий болгох;
- Хөрөнгө оруулагчидтай боломжит санхүүжилтийн тохиролцоог хийх;

- Зах зээлийн шинжилгээ судалгааг хийх;
- Бичиг баримт бүрдүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх.

Хөрөнгө Оруулалтын Банкны Газар нь харилцааг байгууллагуудынхаа дотоодын өргөжилт, шинээр компани худалдан авч өөртөө нэгтгэх төсөл, ногоон бизнестэй холбоотой төслүүд зэрэг өргөн цар хүрээ бүхий төслүүдийн хэрэгцээ шаардлагад нь нийцсэн зээлийн болон хөрөнгийн санхүүжилтийн үйлчилгээг үзүүлдэг.

Байгуулагдсан цагаасаа хойш Голомт банк нь санхүүгийн олон байгууллагуудтай үр ашиг бүхий харилцааг бий болгож чадсан бөгөөд Банкны уламжлалт санхүүгийн хамтрагч нараас гадна томоохон хувийн хөрөнгө оруулалтын институтууд, шинэ үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулагч сангүүд, бүсийн болон төвлөрсөн банкууд, даатгалын болон үндэсний хөгжлийн сангүүд зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.

Хувьцаа болон үнэт цаасны бүтээгдэхүүнээс эхлээд хоёрдогч өглөгийн зээлээр болон санхүүжилтээр хамтран ажиллах түүр хэлбэрээр хөрөнгө босгох боломжийг олгодог. Хамтрагч байгууллагуудын маань хөрөнгө оруулалтын салбарт хуримтлуулсан туршлага, ухаан болон Голомт банктай үүсгэсэн бат харилцаа нь харилцагчидад хөрөнгө оруулалтын олон боломжийг санал болгох, зах зээлээ мэдэрч чадсан санхүүгийн багц үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээний нөхцөл, чанар, хэмжээг сайжруулах замаар сэтгэл ханамжийг дээд зэрэгт хүргэх боломжийг бүрдүүлж байна.

ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ БА ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦОО

Гадаад Худалдааны Санхүүжилтийн хэлтэс нь харилцагчдынхаа онцлог хэрэгцээнд нь нийцүүлэн гадаад худалдаатай холбоотой эрсдэлийг бууруулах, мөнгөн урсгалыг хялбарчлах боломжтой худалдааны санхүүжилтийн иж бүрэн үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэж байна. Мэргэжлийн ур чадвар бүхий бичиг баримтын мэргэжилтнүүд болон гадаад худалдааны санхүүжилтийн хамгийн орчин үеийн систем нь банкны гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээний маань ялгараах давуу тал болж байна. Гадаад худалдааны санхүүжилтийн багц үйлчилгээнд импорт, экспортын аккредитив, баталгаа, бичиг баримт цуглуулах үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, дэлхийд тэргүүлэгч корреспондент банкуудынхаа өргөн сүлжээг ашиглан хийж буй гадаад төлбөр тооцооны гүйлгээ, гадаад арилжааны гүйлгээ зэрэг олон үйлчилгээнүүд багтаж байна.

Бид мөн гадаад худалдааны аливаа эрсдэлээс бүрэн хамгаалагдсан, байгууллагын мөнгөн урсгалд үр ашигтай нөлөө үзүүлэгч гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээний ач холбогдлыг харилцагчдад ойлгуулах, мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлж байна.

Тайлант онд импортын аккредитивийн мөнгөн дүн өмнөх оноос 55 хувиар өссөн бол, экспортын аккредитивийн мөнгөн дүн 800 гаруй хувиар өсчээ. Монгол улсын ашигт малтмалын экспортын хэмжээ дэлхийн түвшинд хэмжигдэхүйц болох учир энэхүү өсөлт нь худалдааны санхүүжилтийн үйлчилгээнд ч огцом өсөлтийг авчрах болно гэж манай мэргэжилтнүүд үзэж байна.

Тайлант онд олон улсын болон бус нутгийн тэргүүлэгч банкуудтай харилцах корреспондент банкны хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн ажилласан ба улмаар банкны тайлант онд гүйцэтгэсэн олон улсын төлбөр тооцооны хэмжээ 28 хувиар, ирж буй олон улсын төлбөр тооцооны хэмжээ 16 хувиар, гадагш чиглэсэн олон улсын төлбөр тооцооны хэмжээ 37 хувиар тус тус өсчээ.



НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нөөц болон төлбөрийн чадварын удирдлага

Хөрөнгийн удирдлагын газар нь банкны хөрөнгийн зах зээл дэх үйл ажиллагаа, гадаад валютын арилжаа, төлбөрийн чадварын удирдлагыг хариуцан ажилладаг бөгөөд 2010 онд банк тогтвортой өсөлтийг хангаж, улмаар төлбөрийн чадварын харьцаа 50 хувиас дээш гарч төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хувьд хамгийн хүчтэй банк байр сууриа хадгалсаар байна. Мөн түүнчлэн Банк нь дэлхийд тэргүүлэгч арилжааны байгууллага (донор биш) болох Кредит Свисс болон Абу Дабигийн Хөрөнгө Оруулалтын Зөвлөлөөс 2-р ээрэглэлийн өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн цорын ганц Монгол банк юм. Эдгээр ашигтай харилцаа холбоогоор манай үндсэн хөрөнгө илүү баталгаажихын зэрэгцээ Голомт банкны тогтвортой өсөлтийн үр дүнг мөн харуулж байна.

Үнэт цаасны арилжаа

Төв Банкны үнэт цаас нь банкуудын нөөцийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Монголбанкнаас дотоодын банкуудад арилжаалдаг мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл юм. Төв банкны үнэт цаасны хүү нь Монголбанкны бодлогын хүү (тайлант онд 11 хувь) болох бөгөөд банк хоорондын мөнгөний зах зээл дээр хөтөч хүүгийн үүрэг гүйцэтгэж байна. Голомт банк нь 2010 оны эцсийн байдлаар Монголбанкнаас гаргасан үнэт цаасны 35 хувийг эзэмшиж, системдээ тэргүүлэгч байр сууриа хадгалсан.

Банк нь Монгол Улсын Засгийн газрын “4000 айлын орон сууц” хөтөлбөрийн дагуу бонд гарган санхүүжилт авах арга хэмжээг дэмжиж ажиллалаа.

Валютын арилжаа

2010 он валютын дотоодын захын хувьд онцлог жил болж өнгөрлөө. Монгол Улсын экспортын орлого 53.8 хувиар нэмэгдсэн. Үүнд: Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний борлуулалт голлоо хувийг эзэлж байна. Түүнчлэн дотоодын томоохон аж ахуйн нэгжүүдийн бонд, хувьцаа борлуулсны орлого дотоодын зах дээр орж ирсэн зэрэг нь дотоодын валютын ханшинд нөлөөлж байв.

Голомт банк нь ханшийн уян хатан бодлого баримтлан харилцагчдын захиалга, хүсэлтийг биелүүлэн ажилласнаас гадна Монголбанкны валютын дуудлага худалдаанд идэвхтэй оролцож, нийт арилжааны хэмжээгээр системдээ тэргүүлэх байр суурийг эзэлж байна. Түүнчлэн харилцагчдыг валютын ханшийн эрсдлээс сэргийлэхийн тулд дотоодод гадаад валютын форвард, своп арилжааг анхлан бий болгох, хөгжүүлэх тал дээр зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалж идэвхтэй оролцлоо.

Алтны арилжаа

Дотоодын алт олборлогч байгууллага, иргэдээс тэдгээрийн захиалга, хүсэлтийн дагуу биет алт худалдан авах, тэдгээрт урьдчилгаа санхүүжилт өгөх зэргээр дэмжин ажиллаж байна.

Голомт банкны Хөрөнгийн Удирдлагын Газар нь KEXIM Банктай 10 сая ам.долларын Худалдааны Санхүүжилтийн гэрээ байгуулсан. Мөн Bloomberg-р дамжуулан гадаадын банктай анх удаа арилжаа хийсэн бөгөөд арилжааг идэвхжүүлж байна.


САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Санхүүгийн гол үзүүлэлтүүд


2010 онд Голомт банк стратеги, санхүүгийн төлөвлөгөө, зорилтуудаа амжилттай биелүүлсэний үр дүнд нийт активын хэмжээгээр Монголын хамгийн том банк болж чадсан амжилттай жил байв.

- Нийт активын хэмжээ 560.8 тэрбум төгрөгөөр буюу 55 хувиар өсч 1,573.9 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны системийн өсөлт болох 41.2 хувиас өндөр байсан;
- Харилцагчаас татсан харилцах хадгаламжийн хэмжээ 522.2 тэрбум төгрөгөөр буюу 66 хувиар (банкны системийн өсөлт 55.3 хувь) өсч 1,317.5 тэрбум төгрөгт хүрсэн;
- Харилцагчдад олгосон зээл 279.3 тэрбум төгрөгөөр буюу 55 хувиар (банкны системийн өсөлт 25.0 хувь) өсч 784.6 тэрбум төгрөг болсон;
- Мөн зээл, харилцах хадгаламжийн харьцаа 60 хувь болж тэргүүлэгч банкууд дотроо баланс болон зээлийн чанараар хамгийн сайн банк болж чадсан зэрэг амжилтуудад сэтгэл хангалаа байна.

Нийт актив (тэрбум төгрөг)




Нийт харилцах хадгаламж (тэрбум төгрөг)




2010 оны эцэст Голомт банкны системд эзлэх хувь нийт активын хувьд 22.9 хувиас 25.2 хувь болж, харилцагчийн харилцах хадгаламжийн хувьд 25.8 хувиас 28.5 хувь, цэвэр зээлийн хувьд 20.7 хувиас 25.8 хувь болж тус тус өссөн.

Зээлийн хэмжээ өсөхийн хэрээр зээлийн эрсдэлийн бодлого болон зээлийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулснаар чанаргүй зээлийн харьцааг 4.4 хувиас 2.1 хувь болгон бууруулж чадсан нь системийн түвшин 7.0 хувь, шилдэг 3 банкны 3.5 хувиас харьцангуй сайн гарсан үзүүлэлт юм.

Цэвэр зээл (тэрбум төгрөг)




Чанаргүй зээлийн харьцаа (%)




2010 онд банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хэмжээ 20.1 тэрбум төгрөгөөр өсч 84.1 тэрбум төгрөгт, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хэмжээ Арабын Нэгдсэн Эмарат Улсын "Абу Дабигийн Хөрөнгө Оруулалтын

Зөвлөл"-ийн "Стенхоп Инвестментс" компаниас татсан 25 сая ам.долларын хоёрдогч өглөгөөр, 29.5 тэрбум төгрөг буюу 200 гаруй хувиар өсч 44.0 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт өөрийн хөрөнгө 49.6 тэрбум төгрөг буюу 63 хувиар өсч 128.1 тэрбум төгрөгт хүрсэн.

Өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)




2010 оны эцсийн байдлаар өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 13.5 хувь гарсан нь Монголбанкны шалгуур (>12%)-ыг хангаж байгаа юм.

Ашигт ажиллагаа


2010 онд банкны бизнесийн өсөлт болон үр ашигтай үйл ажиллагааны үр дүнд активын өгөөж өмнөх оны 1.6 хувиас 1.7 хувь болж, өөрийн хөрөнгийн өгөөж 22.5 хувиас 26.6 хувь болж өслөө.

Дундаж ажилчдын тоо өнгөрсөн оноос 122-р өссөн хэдий ч нэг ажилтанд ногдох ашгийн хэмжээ 33 хувиар буюу 15.6 сая төгрөгөөс 20.7 сая төгрөгт хүрч өссөн байна.

Дундаж активын өгөөж (%)




Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)




Үйл ажиллагааны ашиг 9.3 тэрбум төгрөгөөр (25 хувь) өсч 46.5 тэрбум төгрөгт, эрсдэлийн сангийн өмнөх ашиг 4.7 тэрбум төгрөг (22.7 хувь)-өөр өсчээ.

Татварын дараах ашиг 6.9 тэрбум төгрөг буюу 52 хувиар өсч 20.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Монголын тэргүүлэх банкуудын дунд Голомт банк нь дэлхийн эдийн засгийн хямралын үед ч ашигт ажиллагааны үзүүлэлтээрээ дээд амжилт үзүүлж, жил бүр ашигт ажиллагаагаа нэмэгдүүлсээр ирснийг дурьдах нь зүйтэй.

Татварын дараах ашиг (сая төгрөг)



Зардал орлогын харилцаа (%)



Цэвэр хүүгийн орлого: Хүүгийн орлого 29.3 тэрбум төгрөг (36 хувь)-өөр өсч 111.2 тэрбум төгрөгт, хүүгийн зардал 23.5 тэрбум төгрөг (41 хувь)-өөр өсч 81.4 тэрбум төгрөгт хүрснээр цэвэр хүүгийн орлого 5.8 тэрбум төгрөг (24 хувь)-өөр өсч 29.7 тэрбум төгрөгт хүрсэн.

- Зээлийн багц нэмэгдснээр зээлийн хүүгийн орлого 16.6 тэрбум төгрөг (23 хувь)-өөр өсч 90.6 тэрбум төгрөгт хүрлээ;
- Үнэт цаасны арилжаанд идэвхитэй оролцсоноор үнэт цаасны хүүгийн орлого 11.6 тэрбум төгрөг (183 хувь)-өөр өсч 18.0 тэрбум төгрөгт хүрсэн;
- Харилцах хадгаламжийн хүүгийн зардал 26.5 тэрбум төгрөг (55 хувь)-өөр өсч 74.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 66 хувиар өссөнтэй холбоотой ч дотоодын зах зээл хадгаламжийн уян хатан бус хүүтэй байгааг харуулж байна.

Цэвэр хүүгийн бус орлого: Цэвэр хүүгийн бус орлого 3.4 тэрбум төгрөгөөр буюу 26 хувиар өссөн нь валютын арилжааны ашгийн өсөлт болон зээлийн шимтгэл хураамжийн орлого, бусад үйлчилгээний орлогоос хамаарсан байна.

- Валютын арилжааны оновчтой бодлогын үр дүнд валютын арилжааны ашиг 1.8 тэрбум төгрөгөөр;
- Зээлийн шимтгэл хураамжийн орлого 1.3 тэрбум төгрөгөөр;
- Дансны үйлчилгээний орлого 0.5 тэрбум төгрөг, картын шимтгэлийн орлого 0.6 тэрбум төгрөг, гүйвуулгын шимтгэлийн орлого 0.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Энэхүү цэвэр хүүгийн орлого болон цэвэр хүүгийн бус орлогын өсөлттэй уялдан үйл ажиллагааны орлого 9.3 тэрбум төгрөг (25 хувь)-өөр өсч 46.5 тэрбум төгрөгт хүрчээ.

Үйл ажиллагааны зардал: Банкны ажилтан, салбар нэгжийн тоо өсч, үйл ажиллагааны цар хүрээ томрохын хэрээр үйл ажиллагааны зардал 4.5 тэрбум төгрөг (27 хувь)-өөр өсч 21.2 тэрбум төгрөгт хүрсэн.

- Ажилчдын тооны өсөлт, цалингийн өсөлт, гүйцэтгэл сууринласан урамшууллын бодлого, мөн банкнаас ажилчиддаа чиглэсэн Тэтгэврийн Ууган Сангийн үйл ажиллагаа нэвтрүүлсэнтэй холбоотой боловсон хүчиний зардал 1.4 тэрбум төгрөгөөр буюу 24 хувиар;
- Эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааны үр дүнд даатгалын зардал 0.2 тэрбум төгрөгөөр буюу 231 хувиар;
- Зар сурталчилгаа, маркетингийн зардал 0.3 тэрбум төгрөгөөр буюу 40 хувиар;
- Түрэсийн зардал 1 тэрбум төгрөг (14 хувь)-өөр тус тус өсчээ.

Хэдийгээр үйл ажиллагааны зардал 27 хувиар өссөн ч зардал орлогын харьцаа өнгөрсөн оноос буурч 44 хувьд хүрсэн байна.

Татварын зардал:


2010 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварт нийт 6.1 тэрбум төгрөг төлсөн нь 2009 оны 4.1 тэрбум төгрөгийн татварын зардлаас 2 тэрбум төгрөгөөр илүү байна. Банк нь улсын тэргүүлэгч татвар төлөгч байр сууриа дахин хадгаллаа.

Төлбөрийн Чадвар


2010 оны эцэст Голомт банкны төлбөрийн чадварын харьцаа 51.2 хувь гарсан нь төлбөрийн чадвар сайн болохыг харуулж байна. Нөгөө талаас цэвэр зээл нийт харилцах хадгаламжийн харьцаа 59.6 хувь нь банкны системийн дундаж 66.1 хувиас бага байгаа нь мөн төлбөрийн чадварын хувьд сайн үзүүлэлт юм.



Цэвэр зээл/Харилцах, Хадгаламж (%)



Төлбөрийн чадварын харьцаа (%)



ТАВАН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

	2006	2007	2008	2009	2010
Балансын үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Нийт актив	353,161	652,051	697,179	1,013,109	1,573,936
Нийт харилцах, хадгаламж	283,707	512,485	505,171	795,251	1,317,499
Цэвэр зээл	174,700	323,026	447,787	505,299	784,605
Өөрийн хөрөнгө	35,794	54,871	63,548	78,471	128,072
Үр ашгийн үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Хүүгийн орлого	26,955	44,564	69,318	81,832	111,157
Хүүгийн зардал	(18,283)	(30,228)	(43,569)	(57,905)	(81,448)
Цэвэр хүүгийн орлого	8,672	14,336	25,749	23,927	29,708
Цэвэр хүүгийн бус орлого	3,698	7,231	8,912	13,333	16,749
Үйл ажиллагааны зардал	(6,179)	(10,078)	(15,178)	(16,712)	(21,242)
Эрсдэлийн сангийн зардал	(2,563)	(2,299)	(3,958)	(3,240)	983
Татварын зардал	(1,109)	(1,811)	(3,324)	(4,138)	(6,145)
Татварын дараах ашиг	2,520	7,378	12,201	13,170	20,053
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж/Нийт актив	80.3%	78.6%	72.5%	78.5%	83.7%
Өөрийн хөрөнгө (I зэрэглэл)/Нийт актив	8.9%	5.9%	7.3%	6.3%	5.3%
Цэвэр зээл/Нийт актив	49.5%	49.5%	64.2%	49.9%	49.8%
Цэвэр зээл/Нийт харилцах, хадгаламж	61.6%	63.0%	88.6%	63.5%	59.6%
Чанаргүй зээл/Нийт зээл	6.7%	4.2%	3.9%	4.4%	2.1%
Хөшүүргийн харьцаа (дахин)	8.9	10.9	10.0	11.9	11.4
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	0.8%	1.6%	1.8%	1.6%	1.7%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)	10.7%	17.3%	24.3%	22.5%	26.6%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	4.0%	4.1%	4.2%	4.1%	3.6%
Зардал орлогын харьцаа (%)	50.0%	46.7%	43.8%	44.9%	44.0%
Эрсдэлийн үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >12%	16.7%	14.4%	12.8%	13.4%	13.5%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валютын хувьд <+/-40%	39.7%	8.1%	11.9%	11.8%	17.1%
Нэг гадаад валютын хувьд <+/-15%	14.3%	5.8%	9.5%	10.0%	11.2%
Нэг зээлдэг болон түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь <20%	18.3%	17.5%	19.5%	19.9%	17.6%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь <5%	1.7%	2.7%	3.7%	3.5%	3.4%
Холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь <20%	2.0%	8.8%	10.5%	15.9%	10.3%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	53.2%	49.3%	37.0%	51.7%	51.2%
Үндсэн хөрөнгийн харьцаа <8%	1.1%	1.0%	1.0%	0.7%	1.6%

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ

Макро эдийн засгийн тойм хэсэгт тэмдэглэсэнчлэн, 2010 он өмнөх онтой харьцуулахад харьцангуй өсөлттэй, таатай жил байв. Ирж буй он жил бүр элдэв бэрхшээл, сорилтоор дүүрэн байдаг ч 2010 оныг бид өмнөх онтой харьцуулахад илүү өөдрөг төсөөлөл, төлөвлөгөөтэйгээр эхэлсэн. Гэсэн хэдий ч, Голомт банкны эрсдэлийн удирдлагын стратеги нь эрсдэлийн удирдлагын шалгуур үзүүлэлтүүдийг чанга хэвээр хадгалах, Байгуулагын Банкны Газар болон Иргэдийн Банкны Газартай нягт хамtran ажиллах замаар тасралтгүй өргөжин тэлж буй бизнесийн орчинтой уялдсан, оновчтой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэгдэв.

Өмнөх жилүүдийн нэгэн адилаар, Эрсдэлийн Удирдлагын Газар Банкны бусад нэгжүүдийн хамтаар зээлдэгчидтэйгээ нягт хамtran, тэднийг дэмжин ажиллахын зэрэгцээ санхүүгийн тодорхойгүй нөхцөл байдалд хэрхэн ажиллах, хэрхэн давуу тал олох болон санхүүгийн сахилга батыг хэрхэн хамгийн өндөр түвшинд сахих талаар сургалт, зөвлөгөөг хүргүүлж ажиллав. Эрсдэлийн Удирдлагын Газар нь банкыг эдийн засгийн болон санхүүгийн бүхий л төрлийн эрсдэлээс хамгаалах чиг үүрэг бүхий, Гүйцэтгэх захиралд шууд тайлгагнадаг Банкны бүтцийн нэгж юм.


Зээлийн Эрсдэл

Голомт банк нь Baselын хорооноос 2000 оны 9-р сард баталсан, 16 зарчим бүхий зээлийн эрсдэлийн удирдлагын шаардлагад бүрэн нийцсэн зээлийн бодлогыг боловсруулан, мөрдөж байна. Энэхүү бодлого нь банк, зээлдэгчийн аль алинд харилцан ашигтай нөхцөлийг бүрдүүлэх замаар зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг боломжит хамгийн бага түвшин хүртэл бууруулахад чиглэгддэг. Одоогийн хүчин төглөдөр мөрдөгдөж буй Зээлийн бодлогыг ойрын ирээдүйд эдийн засаг хурдацтай өснө гэсэн таамаглалд үндэслэсэн нь зээл олголт нэмэгдэх, улмаар зээлийн багц хурдацтай өсөх үндсэн нөхцөл болж байна.

Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл, Эрсдэлийн Удирдлагын Хороо, удирдлагын баг нь тухайн хугацаанд баримтлах зээлийн бодлого, стратегийг батлах, хэрэгжилтийг тогтмол хугацаанд хянах үүрэгтэй ба Банкны Зээлийн бодлого нь бизнесийн стратегийн хүрээнд эдийн засгийн өөрчлөлтийг даган тухай бүр шинэчлэгдэн хөгжиж ирсэн. Эрсдэлийн Удирдлагын Хороо нь эрсдэлийн удирдлагын үндсэн харьцаануудаас гадна нийт актив, хадгаламжийн харьцаа гэх мэт балансын зарим харьцаануудын зохистой түвшинг тодорхойлох үүрэгтэй.

Голомт банк нь зээлийн эрсдэлийг шийдвэр гаргах болон хариуцлага хүлээх эрх мэдлийг нарийвчлан тодорхойлсон, сайтар зохион байгуулсан, оновчтой бүтцээр удирддаг.





Голомт банк зээл хүсэгчдийн зээлээ төлөх чадварыг бодитоор үнэлэх зорилго бүхий зээлийн үнэлгээний дотоод системийг нэвтрүүлсэн ба энэ нь эдийн засгийн байдал, зээл хүсэгчийн үйл ажиллагаа явуулдаг бизнесийн салбар, бизнесийн байдлыг тус тус судлаад 1-9 оноогоор үнэлдэг. Энэхүү үнэлгээний утгууд нь олон улсад нийтлэг хэрэглэгддэг AAA, AA, A, BAA, BA, B, CAA, CA, C гэсэн утгуудтай дүйх юм. Зээлийн эрсдэлийн энэхүү систем нь шинээр зээл олгох болон олгосон зээлийг дахин үнэлэхэд хэрэглэгддэг.

2010 онд Банкны зээлийн үйл ажиллагааны гүйцэтгэл маш сайн байсан бөгөөд зээлийн багцын чанар Банкны түүхэн дэх хамгийн сайн үзүүлэлттэй гарсан нь эдийн засгийн нөхцөл байдал харилцагчдад эрөгээр нөлөөлсөн, Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын стратеги оновчтой, зохистой хэрэгжсэний үр дүн юм.

Зээл олгох үйл явц

Банкны зээлийн үйл ажиллагаа харилцааны менежерээс эхэлдэг. Харилцааны менежерүүд нь зорилтот харилцагчидтай харилцаж, тэдний бизнесийн байдал, үйл ажиллагаа явуулж буй салбарын талаар гүн гүнзгий мэдлэг олж авах, улмаар зээлдэгчдийн санхүүгийн чадавхи, бизнесийн дотоод мөн чанарыг зөв таньж мэдэх зорилго бүхий, нарийвчилсан санхүүгийн болон техникийн дүн шинжилгээ хийдэг.

Тэд санхүүгийн болон бизнесийн дүн шинжилгээнд үндэслэсэн, зээл олгох эсэх саналаа Байгууллагын Банкны Газрын удирдлагад болон Эрсдэлийн Удирдлагын Газарт явуулдаг. Нийтдээ 50 сая төгрөг болон түүнтэй тэнцэх валютаас дээш

дүн бүхий бүх зээлүүдийг Эрсдэлийн Удирдлагын Газраар хянацсаны дараа Зээлийн Хорооны хуралд хэлэлцүүлдэг.

Эрсдэлийн Удирдлагын Газар нь Байгууллагын Банкны Газраас ирсэн зээлийн саналуудыг хянааж үзээд дараах дүн шинжилгээг хийдэг.

1. Зээлийн хүснэгтийг зээлийн программын "Судлагдаж буй зээл" төлөвт бүртгэх;
2. Зээлийн хүснэгтэд хараат бус дүгнэлт өгөх зорилго бүхий бие даасан шинжилгээ хийх;
3. Банкны зээлийн үйл ажиллагаатой холбоотой дараах шинжилгээнүүдийг хийж дүгнэх:
 - Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний хязгаарлалт, бизнесийн салбарын хязгаарлалтад багтаж буй эсэх;
 - Нэг зээлдэгчид болон холбоотой этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг хангаж буй эсэх;
 - Банкны үнийн бодлогод нийцэж буй эсэх;
 - Зээлийн багцын хугацааны бүтцэд тохирох эсэх;
 - Зээлийн багцын бүтцийн бусад шаардлагыг хангаж буй эсэх.

Эрсдэлийн дүгнэлтийн хүрээнд зээлдэгчийн нөхцөл байдал, боломж бололцоо болон дээрх шаардлагуудыг хангаж буй эсэхийг судалсаны үндсэн дээр зээл, зээлийн хүүг эргүүлэн төлөх чадвар бүрэн дүүрэн байгаа эсэх, зээлийн барьцаа хөрөнгийн шаардлагыг хангаж буй эсэх, зээлийн хязгаарлалтуудыг хэтрүүлээгүй эсэх талаар болон аливаа болзошгүй хүндрэл зээл, хүүг эргүүлэн төлөх хөөрдогч эх үүсвэр байгаа эсэх талаар шинжилдэг.

Зээлийн саналыг туршлага бүхий зээлийн ажилтнууд тухайн зээлдэгчийн зээл төлөх чадвар, зээлийн бодит хэрэгцээ шаардлагатай уялдуулан гаргаж, хамгийн багадаа хоёр зээлийн ахлах ажилнаар хянуулан, Зээлийн Дэд Хороо болон Зээлийн Хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Банкны зээлийн шийдвэр гаргах эрхийн хэмжээ 2010 оны эцсээр дараах байдалтай байна. Үүнд:

- Салбарын зээлийн хороогоор шийдвэрлэх эрхийн хэмжээ 100 сая төгрөг буюу түүнтэй тэнцэх валют хүртэл;
- Дэд зээлийн хороогоор шийдвэрлэх эрхийн хэмжээ 200 сая төгрөг буюу түүнтэй тэнцэх валют хүртэл;
- Зээлийн хороогоор шийдвэрлэх эрхийн хэмжээ нь 200 сая төгрөгөөс дээш.

Эрсдэлийн үнэлгээ хийх үйл явц

Банкны эрсдэлийн үнэлгээ хийх процесс нь тоон болон чанарын хүчин зүйл дээр үндэслэн харилцагч бүрийн зээлийн эрсдэлийг тус бүрд нь тодорхойлоход чиглэгдсэн байдаг ба зээлийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий хараат бус, хөндлөнгийн үйл явц юм. Дээр дурьдсанчлан, 50 сая төгрөг, түүнтэй тэнцэх валютаас дээш дүнтэй бүх зээлүүдэд дараах үзүүлэлтүүдийг харгалзан эрсдэлийн үнэлгээ хийдэг. Үүнд:

- Зан төлөв: зээлийн түүх;
- Зах зээлд эзлэх байр суурь: зах зээлд эзлэх хувь, нэр хүнд;
- Удирдлага:
 - Үр ашигт байдал-Ашигт ажиллагаа, маржин, нийт активын өгөөж;
 - Маркетинг-Борлуулалтын өсөлт;
 - Бүтээгдэхүүний мөнежмент-нийт активын эргэц, дансны авлага, түүхий эд материал;
- Санхүүгийн байдал: Хөрвөх чадвар, өр төлбөр, нийт актив;
- Салбарын тогтвортой байдал: Боломж болон аюулууд;
- Харилцагчийн зан төлөв;
- Өрсөлдөөн;
- Бэрхшээл дарамт: Засгийн газраас тогтоосон хязгаарлалтууд, шинээр хөрөнгө оруулалт татах боломж, зах зээлийн багтаамж.

Зээлийн эрсдэлийн үнэлгээ нь 1-10 гэсэн тоогоор илэрхийлэгдэх ба 1 гэсэн үнэлгээ нь хамгийн бага, 10 гэсэн үнэлгээ нь



хамгийн өндөр эрсдэлтэй байна. Зээлийн эрсдэлийн үнэлгээ ямар байх нь зээл олголтын хязгаарыг тогтоох, тухайн зээлийн хүснэгтийг зөвшөөрөх, татгалзах эсэхд нөлөөлдөг.

Эрсдэлийн Удирдлагын Газар нь банкны зээлийн багцыг бүхэлд нь хянадаг ба “watch list-хянах жагсаалт”-ын аргаар байнгын хяналтыг хэрэгжүүлдэг. Энэхүү хяналтын хүрээнд эрсдэлийн үнэлгээ болон бизнесийн салбарын эрсдэлийг харгалzan үзэж, зээлийн ангиллыг хийдэг.

Харилцааны менежерүүд зээлийн үйл ажиллагааны өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй ба холбогдох хэлтэс, бүтээгдэхүүн үйлчилгээ хариуцсан менежерүүд нь зээлийн эрсдэлийн ахлах менежертэй нягт хамтран ажилладаг.

Эрсдэлийн Удирдлагын Газар нь Эрсдэлийн Удирдлагын Хороонд үйл ажиллагаагаа тайлagnадаг бөгөөд тайландаа зээлийн чанар, эрсдэлийн түвшин болон анхаарах шаардлагатай асуудлуудыг тусгадаг.

Зээл эргэн төлүүлэх үйл явц

Зээлийг эргэн төлүүлэх ажиллагааг харилцааны менежерүүд хариуцдаг. Бүх харилцагчдад зээлийг эргүүлэн төлөхтэй холбоотой аливаа мэдээллийг бичгээр болон аман хэлбэрээр өгдөг ба зээлийг эргэн төлүүлэх чиглэлээр гэрээний дагуу эрчимтэй ажилладаг.

Зээлийг эргүүлэн төлөх хугацаа хэтэрснээс хойш 5 хоногийн дотор зээлийн түүх болон, өмнө хугацаа хэтрүүлж байсан эсэх, зээлийн хэмжээ зэргээс хамаарч харилцагчидтай зээлийн эргүүлэн төлөх талаар холбоо тогтоодог. Зээлийн өрийн хэмжээ өндөр байгаа болон зээлийг эргүүлэн төлөх үйл явц удаашралтай байгаа харилцагчидыг тулхүү анхаарч, тогтмол эргэх холбоотойгоор ажилладаг. Байгууллагын Банк болон Иргэдийн Банкны Газрын удирдлага зээлийн хугацаа хэтрэлтэй харилцагчдад анхны удаад утсаар мэдэгддэг ба уг харилцааны үр дүн ямар байгаагаас хамаарч дараагийн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Бүх зээлдэгчидтэй харилцах аман болон бичгийн харилцаа нь мэргэжлийн өндөр түвшинд, ёс зүйн шаардлагыг хангасан байдлаар явагддаг.

Зээлийг эргүүлэн төлүүлэх үйл явцыг тоймловол:

- Бүх зээлдэг сар бүр зээлийн дансны хуулга, зээл төлөгдсөн байдал, зээл төлөх хэмжээ, хугацаа хэтрэлтийн мэдээллийг агуулсан тайлан мэдээг хүлээж авдаг. Харилцааны менежер хариуцсан зээлийн дансуудаа тогтмол хянах ба зарим нэг сонгогдсон дансуудыг Эрсдэлийн Удирдлагын Газрын зүгээс хамтран хянадаг. Явцын хяналтын үндсэн дээр хугацаа хэтэрсэн болон муудсан зээлтэй зээлдэгчээр зээл төлүүлэх хөтөлбөрийг боловсруулдаг.
- 30-аас дээш хоногоор хугацаа хэтэрсэн зээлдэгчдэд харилцааны менежерүүд бизнесийн үйл ажиллагаагаа хэрхэн зөв зохион байгуулах, мөнгөн урсгалаа хэрхэн зөв удирдах, маркетинг борлуулалтаа хэрхэн сайжруулах, үнийн ямар бодлого барих вэ гэх мэт зөвлөгөө өгч ажилладаг.
- Бүхий л шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч хугацаа хэтрэлт арилахгүй байсаар, 90-ээс дээш хоног болсон тохиолдолд уг зээлийн удирдлага, хяналт Эрсдэлийн Удирдлагын Газарт шилждэг.
- Зээлийг эргүүлэн төлүүлэх бүхий л боломжийг судалж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч зээл төлөгдөөгүй, зээлдэг зээл төлөх чадваргүй нь тогтоогдсон, эсвэл ямар нэг маргаан гарсан тохиолдолд Тусгай активын хэлтэст шилжүүлж, 30 хоногийн дотор хуулийн дагуу төлүүлэх арга хэмжээг авдаг.

Эрсдэлтэй зээлийг удирдах нь

Банк нь өндөр чадвар, туршлага бүхий мэргэжилтнүүдээр асуудалтай зээлийг удирдуулдаг. Тусгай активын менежерүүд зээлийн эргэн төлөлт удааширан, асуудалтай зээлүүд дээр шинжилгээ хийж, зээл тус бүр дээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулж ажилладаг.

Тусгай активын менежерүүд асуудалтай зээлүүдийг аль болох богино хугацаанд төлүүлэх, хөрөнгийг найдвартай

хамгаалах үүднээс бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ба зээлдэгчийн зан төлөв, зээлийг эргэн төлөх хүсэл сонирхол гэх мэт бүх нөхцөл байдлыг дүгнэсний үндсэн дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ сонгодог. Зээлийг шүүхийн байгууллагад шилжүүлж төлүүлэх ч тохиолдууд гардаг бөгөөд шүүхийн байгууллагаар асуудал шийдвэрлүүлэх хугацаа дунджаар 6-аас 12 сар байдаг. Шүүхийн байгууллагад асуудлыг шилжүүлэхээс өмнө банк нь мэргэжлийн экспертийн зөвлөгөөтэйгээр тусгай үнэлгээ хийж, барьцаа хөрөнгийн бодит үнэлгээ, шүүхээр эргэн төлүүлэх нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг тогтоодог.

Зээлийн эрсдэлийн загварчлал ба багцын чанар

Бид зээлийн хугацаа хэтрэлт (PD), алдагдлын магадлал (LGD) болон зээлийн эрсдэлийн бусад үзүүлэлтүүдийг тооцоолох загварчлалыг боловсруулан ашиглаж байна. Уг аргачлал нь IAS 39 болон Базелын хорооноос гаргасан Зээлийн эрсдэлийн загварчлалын шаардлагуудыг бүрэн хангаж, хөндлөнгийн хяналтын Ernst & Young компаниар баталгаажуулагдсан бөгөөд хүлээгдэж буй хугацаа хэтрэлт, алдагдлын хэмжээг тооцоолон, зээлийн эрсдэлийн хязгаарлалтууд, бусад зохист параметрүүдийг тогтоо замаар зээлийн эрсдэлийг хянах үр ашигтай хэрэгсэл болж чадсан юм.

Чанаргүй зээлд хугацаа нь хэтэрч үнэ цэнэ буурсан зээлүүд хамаарна. Зээлийн үнэ цэнийн бууралтыг IAS 32-ын дагуу тогтоодог бөгөөд уг стандартын дагуу зээлийн өнөөгийн үлдэгдэл нь ирээдүйн мөнгөн урсгалаас төлөгдөх зээл, хүүний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс их байх зээлүүдийг чанаргүй буюу үнэ цэнэ буурсан зээл гэж үзнэ. Энэхүү дүрэм зээлийн чанарын ангилалд зээлдэгчийн санхүүгийн чадавхиас гадна гадаад хүчин зүйлсийг авч үздэгээрээ давуу талтай юм.


Доорх графикаас харахад, 2010 онд зээлийн хугацаа хэтрэлт (PD) 1.9—өөс 1.5 болж буурсан бол алдагдлын магадлал (LGD) сүүлийн 2 жилийн турш 0 байна.

Салбарын шинжилгээ ба төвлөрөл

Зээлийн багцын чанарыг урьдчилан тодорхойлсон түвшинд барих үүднээс төвлөрлийн хязгаарлалтыг тогтоож, хэрэгжүүлдэг. Бизнесийн нэг салбарт, эсвэл эдийн засгийн аль нэг сегментэд зээлийн хэт төвлөрөл үүсэхээс зайлсхийн зорилгоор банкны зээлийн бодлогод эдийн засгийн нэг салбарт олгох зээлийн дээд хэмжээг нийт багцын 30 хувиас хэтрэхгүй байхаар заасан. Нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ, холбоотой буюу групп зээлдэгчдэд олгох зээлийн дээд хэмжээ болон рейтинг, улс орны хязгаарлалт зэрэг үзүүлэлтүүд ч зээлийн бодлогод тусгагдсан байдаг.

2010 оны эцэст банкны нийт зээлийн багцын 17 хувийг уул уурхайн сектор (134 тэрбум төгрөг), 15 хувийг (119 тэрбум төгрөг) худалдааны сектор тус тус эзэлж байгаа нь багцад хамгийн өндөр дүнг эзэлж байгаа бөгөөд банкны үлдсэн зээлийн багц эдийн засгийн бусад салбарт жигд тархсан байгааг доорх зургаас харж болно.

Зээлийн загварчлал



Банкны нийт актив, эдийн засгийн салбараар (тэрбум төгрөгөөр)



Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь банк өөрийн санхүүгийн үүргүүдээ цаг хугацаанд нь зах зээлийн үнээр гүйцэтгэж чадахгүйд хүрэх эрсдэл юм. Санхүүгийн үүргүүд гэдэгт хадгаламж эзэмшигчдэд өгөх өглөг, санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний дагуух төлбөрүүд, үнэт цаас, зээл, худалдан авалтын төлбөр тооцоонууд болон хөрөнгө оруулалт, зээлтэй холбоотой бүхий л үүргүүдийг ойлгоно.

Голомт банкны хөрвөх чадварын удирдлагын тогтолцоо нь зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөл дээр дурьдсан санхүүгийн үүргүүдээ бүрэн гүйцэтгэж чадахуйц хөрвөх чадварын баталгаат түвшингүүдийг тогтоох, хянах, удирдахад чиглэдэг. Актив Пассивын Хороо нь банкны хөрвөх чадварын эрсдэлд хандах хандлагыг тусгасан, холбогдох дүрэм, журам болон олон улсын шалгарсан практикт нийцсэн хөрвөх чадварын эрсдэлийн стандартуудыг тогтоодог ба энэ нь банкны хэмжээнд мөрдөгдхөн хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хэм хэмжээ болдог. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлого, журмуудын хэрэгжилтийг хангуулах үүргийг Актив Пассивын Хороо гүйцэтгэдэг.

Банкны хөрөнгийн удирдлагын нэгдсэн бодлогын дагуу Актив пассивын хороо хөрвөх цогц удирдлагын доорх элементүүдийг хэрэгжүүлэхийг шаарддаг. Үүнд:

- Урт, бодино хугацааны мөнгөн урсгалын удирдлага;
- Балансын зөв, сайн бүтцийг тогтоох, хадгалах;
- Гадаад валютын хөрвөх чадварын удирдлага;
- Эх үүсвэрийг хангалттай тархаах, төвлөрлийг багасгах;
- Хөрвөх чадварын стресс тестийг тогтмол хийх;
- Хөрвөх чадварын нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Өргөн хүрээтэй дотоод хяналтын системийн тусламжтайгаар дээрх элементүүдийн өөрчлөлт, тэдгээрийн нөлөөллийг сард 2 буюу түүнээс дээш удаа хянаж, дүгнэн үр дүнг Актив Пассивын Хорооны хуралд танилцуулдаг. Энэхүү дотоод хяналтын систем нь зорилтот технологиуд, батлагдсан дүрэм журмуудын хэрэглээ болон системийн үр ашигт байдлыг үнэлэх эрсдэлийн удирдлагын бие даасан, гэнэтийн болон тогтмол хяналтыг агуулдаг.


Доорх хүснэгтэд банкны хөрвөх чадварын харьцаа ба графикт хөрөнгийн эргэн төлөгдөх хугацааны шинжилгээний үр дүнг харуулав.

Мөнгөн урсгалын удирдлага

Үр ашиг бүхий идэвхтэй хөрөнгийн удирдлага нь хэд хэдэн бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааг хамардаг бөгөөд бүхэлд нь Хөрөнгийн Удирдлагын Газар удирддаг. Богино хугацааны мөнгөн урсгалын төсөөлөл нь банкны бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах шаардлагаар төлөвлөгддөг бөгөөд Актив

Хөрөх чадварын харьцаа	2010	2009
12 дугаар сарын 31	51.2%	51.7%
Жилийн дундаж	45.5%	44.8%
Хамгийн өндөр	51.2%	57.2%
Хамгийн бага	38.1%	35.4%

Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ



боловжуудыг тодорхойлдог. Энэхүү үйл явц нь балансын бүтэц алдагдсанаас үүсэх хөрөх чадварын эрсдэл, түүнийг нөхөхөд зарцуулагдах нэмэлт эх үүсвэрийн хэмжээг тодорхойлоход ашиглагддаг.

Хугацааны ялгаатай үеүд дэх хүлээгдэж буй орох, гарах хөрөнгийн урсгалын зөрүүг тодорхой хязгаарт барих, хөрөх чадварын харьцааг хангалттай өндөр түвшинд байлгах үүднээс зохих хязгаарлалт, шаардлагуудыг тогтоон мөрддөг. Энэхүү хязгаарлалт, шаардлагуудыг хангуулах үр ашиг бүхий механизмуудын нэг нь богино хугацааны хөрөнгө, эх үүсвэрийн харьцаа (shot-term funding ratio)-г тогтоож, үр ашигтайгаар удирдах юм.

Түгээмэл хэрэглэгддэг харьцаанууд:

- Цэвэр зээл / Харилцах, хадгаламж;
- Монголбанкинд байршуулсан хадгаламж + Мөнгөн хөрөнгө / Харилцах, хадгаламж;
- Нэг сар хүртэлх хугацааны актив / Нэг сар хүртэлх хугацааны пассив;
- Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө / Харилцах, хадгаламж;
- Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж / Харилцах, хадгаламж;
- Хөрөх актив / Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө;
- Хөрөх актив / Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө + Хүлээж болзошгүй үүргүүд;
- Хөрөх актив / Нийт актив;
- Цэвэр зээл / Нийт актив;
- Цэвэр зээл / Харилцах, хадгаламж;
- Цэвэр зээл / Харилцах хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө;

Пассивын Хорооноос тогтоосон шаардлагууд, зохистой харьцааны үзүүлэлтүүдэд нийцсэн байдаг. Харин урт хугацааны төлөвлөлтийн хэрэгцээ нь төсөөлсөн балансын бүтэц, санхүүгийн хэрэгслүүдийн байршлыг зохицуулах шаардлагаас урган гарч, тогтмол хугацаанд шалгагдан, сайжруулагдаж байдаг.

Бүтцийн шаардлагууд

Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ нь хөрөх чадварыг балансын бүтцээр удирдах үр ашигтай цогц удирдлагын тогтолцооны суурь болдог. Хүлээгдэж буй мөнгөн урсгал нь эргэн төлөгдөх хугацаа өөрчлөгдөх бүрт материалыг дүнгээр өөрчлөгдж байдаг. Иймд банкны хөрөнгө, эх үүсвэр болон тэнцлийн гадуурх үүргүүдийг эргэн төлөгдөх хугацааны хувьд шинжлэхдээ хугацаа нь тодорхойгүй, эсвэл хугацаанаас өмнө хэрэгжих магадлалтай үүргүүдийг чанараар нь ангилж, хугацааны



- Хугацаатай хадгаламж / Нийт пассив;
- Гадаад валютын актив / Нийт актив;
- Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл + Гадаад валютын хадгаламж / Гадаад валютын харилцах хадгаламж;
- Гадаад валютын цэвэр зээл / Нийт актив;
- Гадаад валютын хөрвөх актив / Гадаад валютын харилцах хадгаламж;
- Том харилцагчдын харилцах, хадгаламж / Харилцах хадгаламж;
- Засгийн Газрын харилцах, хадгаламж / Харилцах хадгаламж;
- Бусад харьцаа үзүүлэлтүүд.

Гадаад валютын хөрвөх чадварын удирдлага

Валютын ханш эсвэл тухайн валютын балансын бүтэц өөрчлөгдөх үед банкны гадаад валютын хөрвөх чадварт өөрчлөлт гардаг. Валютын хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх гол түлхүүр нь гадаад валютаар олгох зээлийн хэмжээг тухайн валютаар татсан эх үүсвэртэй нь уялдуулах явдал юм.

Төвлөрөл багатай багц буюу хөрөнгийн тараан байршуулалт

Банкны хөрөнгө, эх үүсвэрийг эдийн засгийн секторууд болон том, групп харилцагчдаас хэт хамаарлтай болохос урьдчилан сэргийлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор төвлөрлийн эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоодог. Эх үүсвэрийн дийлэнхийг урт хугацаат хадгаламж, харилцах болон харилцагчдын оновчтой түүврээс (том, жижиг харилцагчдын хувьд) бүрдүүлэх замаар төвлөрлийн эрсдэлийг бууруулдаг.

Хөрвөх чадварын стресс тест

Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас банкны хөрвөх чадварт үүсч болзошгүй нөлөөллийг үнэлэх зорилгоор тусгайлсан болон системчилсэн стресс сценаруудыг гарган, тэдгээрт нийцсэн мөнгөн ургалын төсөөллиүүдийг хийдэг. Сценарууд нь түүхэн эсвэл төсөөлсөн үйл явдал (жишээ нь нэг банк хүндэрсэн нь түүхэн үйл явдал бол үүнээс системд үзүүлэх нөлөөллийг тооцоолох нь төсөөлсөн үйл явдал юм)-ын аль алинд суурилж болох бөгөөд стресс тестийн үр дүнгүүд нь хөрвөх чадварын зорилтот түвшингүүдийг тодорхойлох, төлөвлөхөд хамгийн зөв, оновчтой өгөгдлүүд болдог.

Хөрвөх чадварын нөөц төлөвлөгөө

Эдийн засаг зогсонги байдалд орсонтой холбоотойгоор банк хөрвөх чадварын нөөц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ нь хөрвөх чадварын хүндрэлийг хохиролгүйгээр даван туулахуйц түвшний итгэлцлийг зах зээлд бий болгох, хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн цогц төлөвлөгөө бөгөөд хямралын үед баримтлах тодорхой стратегид суурилсан, хямралыг урьдчилан мэдээлэх өргөн хүрээтэй үзүүлэлтүүдийг агуулсан байдаг. Урьдчилан мэдээлэх үзүүлэлтүүд нь тодорхой давтамжтайгаар, нарийвчлалын өндөр түвшинд хянагдан шинэчлэгддэг бол хямралын эсрэг стратеги нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд зохион байгуулагдаж, дотоод гадаад харилцаа, хөрвөх чадвар болон нөхцөл байдлын шаардлагаар бий болох нэмэлт мэдээллийн шаардлагуудыг тусгасан байдаг.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш, өөрийн хөрөнгийн үнэ цэнэ гэх мэт зах зээлийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийн сөрөг өөрчлөлтийн нөлөөгөөр банкинд үүсч болзошгүй эрсдэл юм. Банк арилжааны болон арилжааны бус багцын аль алинаас нь зах зээлийн эрсдэлд өртөж болох бөгөөд энд банкны хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа ч хамаардаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс банкны эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зах зээлийн эрсдэлийн ерөнхий хязгаарлалт болон түүнд агуулагдах үзүүлэлт нэг бүрийн нарийвчилсан хязгаарлалтуудыг тогтоож, хэрэгжилтийг Актив

Пассивын Хороо хянадаг. Энэхүү хяналт нь банк одоо болон ирээдүйд хүү, ханшийн өөрчлөлтөөс хүлээж болох эрсдэлийн нийт багцыг тодорхойлох, тогтмол хянах зарчмаар хийгдэг.

Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Актив Пассивын Хорооноос тогтоосон бодлого, журмын хэрэгжилтийг хангулах, бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын төрлүүд, арилжааны хэлшлүүд болон санхүүгийн хэрэгслийдийн хувьд тавигдсан хязгаарлалтуудыг үйл ажиллагаанд даа мөрдлөг болгох замаар зах зээлийн эрсдэлийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгэж ирсэн. Эрсдэлийн Удирдлагын Газар нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд голлох үүрэгтэйгээр оролцож үйл ажилгаагаа Актив Пассивын Хороо болон Гүйцэтгэх захиралд шууд тайлагнадаг.

Хүүгийн эрсдэл

Банкны арилжааны бус багцаас урган гардаг зах зээлийн гол эрсдэл нь хүүгийн түвшний өөрчлөлтөөс банкны ашиг, эсвэл өөрийн хөрөнгөд үзүүлэх сөрөг нөлөөлөл буюу хүүгийн эрсдэл юм. Банк дараах шалтгаануудын улмаас хүүгийн түвшний эрсдэлд өртдөг:

- Хөрөнгө, эх үүсвэрийн дахин үнэлэгдэх эсвэл төлөгдөх хугацаа ялгаатай байх (жишээ нь, хөрөнгө нь эх үүсвэрээс хурдан хугацаанд дахин үнэлэгддэг тохиолдолд хүү буурвал ашиг буурна);
- Хөрөнгө, эх үүсвэр ижил хугацаанд ялгаатай дүнгээр дахин үнэлэгдэх (жишээ нь, зах зээл дэх хүүгийн түвшин буурахад Банк эх үүсвэрийн хүүгээ түүнээс бага түвшинээр бууруулах);
- Урт богино хугацаанд зах зээлийн хүүгийн түвшин ялгаатай дүнгээр өөрчлөгддэх (жишээ нь, өгөөжийн муруй шинээр олгогдож буй зээлийн өгөөж болон эх үүсвэрийн зардалд өөрөөр нөлөөлөх);
- Хүүгийн түвшний өөрчлөлтөөс хамаарч хөрөнгө, эх үүсвэрийн үлдсэн хугацаа уртсах эсвэл богиносох (жишээ нь, хэрэв урт хугацаат моргейжийн хүү огцом буурвал моргейж төлөвлөсөн хугацаанаас өмнө ихээр төлөгдэж, орлого буурна).

Хүүгийн түвшний эрсдэлийг хөрөнгө, эх үүсвэрийн дахин үнэлгээний зөрүүгээр үүссэн хүүгийн мэдрэмжийн зөрүү дүнг шинжлэх замаар тооцоолно. Доорх хүснэгтэд хүүгийн түвшний болзошгүй өөрчлөлтөөс орлогын тайланд үзүүлэх нөлөөллийг оны эцсийн өгөгдлүүдийг суурилан үзүүллээ.

	Хүүгийн өөрчлөлт	Ашигт үзүүлэх нөлөө
2010	+120	-4.08 %
2010	120	4.08 %
2009	-120	-4.06 %
2009	+120	4.06 %
2008	+120	-3.96 %
2008	-120	3.96 %

Гадаад валютын эрсдэл

Арилжааны багцын гол эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслийдийн хүү, зах зээл дэх хөрвөх чадвар, үнийн өөрчлөлтөөс үүсдэг. Арилжааны багцаас хүлээх эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслийдийн хэмжээ, зах зээл дэх хөрвөх чадвар болон үнийн өөрчлөлтөөс голлон хамаарах ба эрсдэлийн үндсэн хүчин зүйлс нь хүүгийн түвшин, ханш, хувьцааны үнэ юм.


Банкны арилжааны үйл ажиллагааны гол цөм нь харилцагчдад өрсөлдөхүйц үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлийлэх буюу харилцагчид чиглэсэн үйл ажиллагаа юм. Үүнээс гадна банк ашиг олох зорилгоор өөрөө язс бүрийн арилжаа хийдэг бөгөөд тухайлбал, зах зээлийн давуу байдлаа ашиглан авах, зарах үнийн зөрүүгээр ашиг олох зорилгоор валютын арилжаа хийх, хоорондоо холбоотой өөр өөр зах зээлийн төгс бус байдлаас ашиг олох зорилгоор позици үүсгэх, ирээдүйд давуу тал олох зорилгоор санхүүгийн хэрэгслийдийн эзэмших гэх мэт.



Бизнесийн үйл ажиллагааныхаа явцад зах зээлийн эрсдэлтэй холбогддог банкны бүтцийн бүхий л нэгжүүд банкны арилжааны бодлогыг дагаж мөрдөх ёстай. Зах зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь нарийвчлан тогтоосон, хатуу хязгаарлалтууд бөгөөд эдгээр нь дилерийн эрх хэмжээ гэх мэт эрсдэлийн удирдлагын үндсэн үзүүлэлтүүдийг бүхэлд нь тогтоосон байдаг. Хязгаарлалтууд зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээнүүдийг арилжааны бодлогод мөн тусгасан байдаг.

Бид зах зээлийн эрсдэлийг тооцоолоходоо гурван төрлийн VaR (Value at Risk) аргыг ашигладаг. VaR нь тодорхой хугацааны хязгаарт багцын зах зээлийн үнэлгээнд гарч болох боломжит сөрөг өөрчлөлтийг өгөгдсөн итгэх түвшинд тооцоолдог техник юм. Бид Төв банкны зохистой харьцааны шаардлагын дагуу VaR-г 10 хоногийн хугацаанд 90 хувийн итгэх засварт тооцоолохын зэрэгцээ 1 өдрийн дотор 99 хувийн итгэх засварт тооцоолон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандaa ашигладаг.

Түүнчлэн VaR аргаар тооцоологодох боломжгүй алдагдлыг тодорхойлох зорилгоор стресс тестийг хийдэг. Доорх зурагт 99 хувийн итгэх засварт, 1 өдрийн хугацааны хязгаартайгаар, өмнө дурьдсан 3 төрлийн VaR аргаар хийсэн тооцоолын үр дүнг нэгтгэн харуулав. EVT VaR нь стресс тестийн үр дүнг харуулав.



Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь дүрэм журам системийн нийцгүй байдал эсвэл үл хэрэгжилт, хүний санамсаргүй алдаа, санаатай үйлдлүүд болон гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр банкинд шууд ба шууд бусаар учирч болох эрсдэл юм.

Голомт банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын зорилго нь учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан илрүүлэх, түүнд нөлөөлдөг гадаад дотоод хүчин зүйлсийг судалж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах ажлыг системтэйгээр зохион байгуулах, үйл ажиллагааны алдагдлын зохистой түвшинг хангах, эрсдэлийг удирдахад шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Бид үйл ажиллагааны эрсдэлийг оновчтой тодорхойлох, хянаж удирдах зорилгоор холбогдох бодлого, стандарт, аргачлалуудыг боловсруулан хэрэгжүүлж байна. Өнгөрөгч онд банк үйл ажиллагааны эрсдэлийг удирдах хүрээнд дараах чиглэлүүдэд тулхүү анхаарч ажиллав. Үүнд нь:

- Салбар нэгжүүдийн үйл ажиллагаанд тавигдах хянах, шалгах механизмуудын сайжруулалт;
- Салбар нэгжийн үйл ажиллагааны гарын авлага боловсруулах;

- Салбар нэгжийн үйл ажиллагааны стандартыг бий болгох, хэрэгжилтийг хангуулах;
- Харилцагчийн данс нээх үйл ажиллагааны стандартчлалт, мэдээллийг бүрэн бүрдүүлэх, архивлах үйл ажиллагааны сайжруулалт;
- Харилцагчийн хувийн хэргийн мэдээллийг шинэчлэн сайжруулах;
- Банкны аюулгүй байдлыг бэхжүүлэх, газар дээрх хяналтыг нэмэгдүүлэх;
- Үйл ажиллагааны эрсдэлийн мэдээллийн санг бүрдүүлэх, эрсдэлийн үнэлгээнд ашиглах;
- Ажилчдын мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтын сайжруулалт;
- Мэдээллийн системийн сайжруулалт;
- Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол сайжруулах, турших;
- Бизнесийн үе шат бүр дэх хариуцлага, хяналтын систем;
- Хүчирхэг дотоод хяналтын орчин;
- Үйл ажиллагааны эрсдэлийг удирдах боломж бүхий үр ашигтай бүтэц, зохион байгуулалт;
- Эрсдэлийг тодорхойлох, хянах, удирдах үйл явцыг бүхэлд нь агуулсан оновчтой үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо.

Түүнчлэн банк зарим эрсдэлийг гуравдагч этгээд буюу даатгалын байгууллагад шилжүүлж ажилласан бөгөөд 2010 онд банкны бүх хөрөнгийг даатгуулж, мэргэжлийн хариуцлагын даатгалд шаардлагатай албан тушаалуудыг бүхэлд нь хамрууллаа.

Мэдээллийн эрсдэлийн менежмент

Мэдээллийн эрсдэл гэдэг нь санаатай болон санамсаргүй байдлаар мэдээллийн эх сурвалжуудыг ашиглах, өөрчлөх, задлах, устгах замаар мэдээллийн үнэн зөв, найдвартай, хэрэглэхүйц байдлыг алдагдуулах эрсдэл юм. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд хамаарах онцлог үйл ажиллагааг сайжруулах, бизнесийн тасралтгүй байдлыг хангах, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх болон төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд ч чухал үүргийг гүйцэтгэдэг. Бид мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэхдээ олон улсын туршлагууд болон холбогдох хууль, дүрэм, журмуудыг баримтлан ажиллаж байна.

Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хэрэглэгчийн эрхийн зохицуулалт, мэдээлэл татах журам, сүлжээний мониторинг, хэрэглэгчийн хандалт, хийсэн үйлдлийн бүртгэлийн хяналтын програмын тусламжтайгаар өдөр тутмын хяналтыг гүйцэтгэж байна. 2010 онд банкны сүлжээ, түүний хяналт, аюулгүй байдлын түвшинг сайжруулах зорилгоор сүлжээний шинэчлэлтийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж, сүлжээний төхөөрөмжүүдийг шинэчлэн хяналт, мониторингийн програм хангамжийг нэвтрүүлэв.

Бизнесийн тасралтгүй ажиллагааны менежмент

Бизнесийн тасралтгүй ажиллагааны менежмент нь урьдчилж хараагүй элдэв осол, saatlyн улмаас банкны бизнесийн хэвийн үйл ажиллагаа тасалдахад түүнийг богино хугацаанд хэвийн байдалд нь оруулах, системийн ажиллагааг бүрэн сэргээх, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэхэд чиглэдэг. Бид осол, saatlyн үед системийг хэвийн байдалд эргүүлэн оруулах хугацааг боломжит хамгийн богино түвшинд байлгахыг чухалчилж, үүнтэй холбоотой банкны чадавхийг улам бэхжүүлэхийг зорин ажиллав.

Бид осол saatlyн үеийн хүндэрлүүдийг удирдах үйл ажиллагааг зохион байгуулалттай, хянагдахуйц хэлбэрт оруулах зорилгоор бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол сайжруулсаар ирсэн.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь банкны бизнесийн тасралтгүй байдлыг хянаж удирдах, уг төлөвлөгөөний биелэлтийг хангуулах үүргийг гүйцэтгэхээс гадна уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий "Ослын



үед ажиллах баг” болон “Бизнесийн үйл ажиллагааг сэргээх баг”-уудтай нягт хамтран ажиллаж байна. 2010 оны 5 сард газар хөдлөлт болох үед банкны системийн тасралтгүй ажиллагааг хангах туршилт хийж, төлөвлөгөө болон ажил үүргийн хуваарьт шаардлагатай өөрчлөлт шинэчлэлт хийсний зэрэгцээ тухайн нөхцөлд шаардлагатай техникийн асуудлыг бүрэн шийдвэрлэхээр зорилт тавьж ажиллаж байна.

Луйврын шинжтэй эрсдэлийн менежмент

Гүйлгээний процесст гарсан алдаатай үйлдлүүд, банкны хэмжээний залилан, түүнтэй төсөөтэй үйлдлүүдийг хянах, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд луйврын шинжтэй эрсдэлийн менежмент ихээхэн чухал үүргийг гүйцэтгэдэг.

Банк нь данс бүртгэлийн алдаа, залилан гэх мэт луйврын шинжтэй бүхий л төрлийн үйл ажиллагаанаас сэргийлэхээр хичээнгүйлэн ажиллаж байгаа ба банкны үйл ажиллагааны бүхий л түвшинд бодлого журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хуйвалдан мэхлэх болон луйврын шинжтэй бусад үйлдлийн эсрэг тэмцэх бодлого, стратегийг иж бүрэн утгаар нь боловсруулан хэрэгжүүлсэн. Луйврын шинжтэй үйлдлүүдийн улмаас үүсэх алдагдлыг бууруулах, ийм төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнүүд болон гэмт хэрэг хийж болзошгүй этгээдийг илрүүлэх зорилгоор банкны өдөр тутмын үйл ажиллагааг тогтмол давтамжтайгаар хяналт байна.

Хянан нийцүүлэх үйл ажиллагаа

Хянан нийцүүлэх чиг үүрэг нь банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, журам, эрхзүйн баримт бичиг, гэрээ, стандартыг мөрдөөгүйгээс банкны үйл ажиллагаа, санхүүгийн болон нэр хүндийн эрсдэлд орохос сэргийлэх зорилготой юм. Голомт банкны үйл ажиллагаа нь Монгол улсын хууль тогтоомж эрх зүйн зохицуулалтаас гадна олон улсын холбогдох гэрээ, конвенц, нийтлэг зан заншил, ёс зүйн хэм хэмжээнд нийцэж буй байдалд хяналт тавьж, хуулийн хариуцлага хүлээх, санхүүгийн алдагдалд орох, нэр хүндээ алдах зэрэг эрсдэлээс хамгаалах зорилгоор Хянан нийцүүлэх алба ажиллан, банкны хэмжээний эрх зүйн бичиг баримтуудыг хяналж, үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомж нь санхүүгийн байгууллагуудаас харилцагчдынхаа мэдээллийг албан ёсоор тодорхойлж, тодорхой түүхүүдийг хадгалахын зэрэгцээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээллэхийг шаарддаг. Банк нь өөрчлөгдж буй хууль эрхзүйн орчин нөхцөлд тохируулан бодлого, түүнийг хянах механизмаа сайжруулах замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаагаа илүү хүчирхэгжүүлж ажиллалаа. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого журам, түүний хяналтын механизмд “Know your customer” хяналтын зарчим, ажилтнуудад мэдлэг олгох сургалт, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, түүнийг тайлагнах, эрсдэлийг тодорхойлох үйл ажиллагаанууд хамарагдаж байна. Дэлгэрүүлэн хэлбэл, банкны өдөр тутмын гүйлгээнд хяналт тавих ажлыг автоматжуулан, өндөр мөнгөн дүнтэй болон хэвийн бус гүйлгээний талаарх мэдээллийг банкны сэжигтэй гүйлгээг хянах систем болон дотоод журмаараа илрүүлэхэд анхаарал тавин ажиллав. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Албанц холбогдох тайлан мэдээг тогтмол гаргаж хамтран ажиллаж ирэв. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, үүнтэй холбоотой банкны бодлого, журмын талаар ажилтан бүр мэдлэгтэй байх, шинэчлэгдсэн мэдээллийг цаг тухайд нь авах, өөрчлөлт шинэчлэлтийг тухай бүр хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс холбогдох сургалтуудыг тогтмол зохион байгуулж хэвшээд байна. Мөн түүнчлэн банкны үйл ажиллагааны нэгжийн ажилтнууд, дотоод хяналтын үүрэг бүхий ажилтнууд болон Хувийн банкны албаны ажилтнууд энэ чиглэлээр мэргэжлийн сургалтанд хамрагдлаа.

Бид мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, олон улсын тэргүүн туршлагаас суралцах чиглэлээр гадаадын корреспондент банкууд болон бусад банкуудтай нягт хамтран ажилладаг.

Ажлын байрны эрүүл мэнд ба аюулгүй байдал

Ажилтнууд, харилцагчид болон бусад хамтран ажиллагсадын аюулгүй байдлыг хангах нь банкны анхаарал хандуулах асуудлуудын тэргүүн эгнээнд тавигдаж, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах чиглэлд холбогдох нэгжүүд идэвхтэй ажиллаж байна. Өнгөрөгч онд салбар, нэгжүүдийн байршиж буй объектууд дээр мэргэжлийн байгууллагуудаар галын дүгнэлт гаргуулан, нийт ажилтнуудыг гэнэтийн осол, галын аюулын үед хэрхэн ажиллаар талаар мэргэжлийн байгууллагын сургалтад бүрэн хамрууллаа.

Мөн түүнчлэн, бид ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн дүрэм журмуудын хэрэгжилтийг хангуулах чиглэлд голлон анхаарч ажиллав.



НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

Компанийн нийгмийн хариуцлагаар нийгэм цаг үедээ тэргүүлэгч байр суурь эзэлж ирсэн удаан хугацааны уламжлалынхаа дагуу банк нь 2010 оны турш эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спорт, нийгмийн хөгжил гэсэн дэмжлэг шаардагддаг голлох салбаруудад санхүүгийн болон материаллаг тусламж үзүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн санал санаачлагууд дараах бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваагдаж байна.

Засгийн Газрын санал санаачлагыг дэмжих чиглэлээр:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас Дэлхийн Эдийн Засгийн Форумтай хамтран зохион байгуулсан Авлигын эсрэг түншлэл сэдвийн дор болсон “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь” “Авлигын эсрэг түншлэл” дугуй ширээний уулзалтуудын цор ганц ивээн тэтгэгч;
- Хонг Конгийн хөрөнгийн биржид Монгол компани бүртгэгдсэнтэй холбогдон зохиогдсон Монгол Улсын Ерөнхий Сайдын уулзалтын цор ганц ивээн тэтгэгч;
- Монгол Улсын Засгийн Газраас зохион байгуулсан “Монголын эдийн засгийн чуулган”-ы ивээн тэтгэгчээр 2 дахь удаагаа;
- Гадаад Харилцааны Яам болон Гадаадын Хөрөнгө Оруулалт Гадаад Худалдааны агентлагийн зохион байгуулсан бус нутгийн болон хөрөнгө оруулалтын чуулга уулзалтуудын ивээн тэтгэгч;
- Уул уурхайн хөрөнгө оруулагчдын “Дисковер Монголия-2010” чуулга уулзалт болон хөрөнгө оруулалтын бусад чуулга уулзалтуудын ивээн тэтгэгч;
- Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан “Монголын Компанийн Засаглал Чуулган”-ы ивээн тэтгэгч. Монголын Компанийн Засаглалын Хөгжлийн Төв төрийн бус байгууллага нь компанийн засаглалын хэмжээг тогтоох чиглэлээр байгууллага аж ахуй нэгжүүдэд зөвлөгөө мэдээлэл өгч сургалт явуулдаг ба Голомт банкны Үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн дэд захирал Г.Ганболд тус төвийн ТУЗ-ийн гишүүн юм.

Боловсролыг дэмжих чиглэлээр:

- Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 8 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж, шилдэг 100 оюутанд тэтгэлэг олгосон бөгөөд тэтгэлэгийнхээ хэмжээг өнгөрөгч онд 50 хувиар нэмэгдүүллээ;
- Монголбанктай хамтран Монголын тэргүүлэгч их дээд сургуулиудын оюутнуудын дунд Оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг 9 дэх удаагаа амжилттай зохион явууллаа;
- Монголын Шинжлэх Ухааны Академийн хурлын танхимыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тохижуулж, шинжлэх ухаанд шамдан суралцаж буй оюутан залуусыг дэмжин хөгжүүлэх зорилгоор Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд шинэ номын сан байгуулж, шинжлэх ухааны чиглэлд олгох оюутны тэтгэлэгээ өргөжүүллээ;
- 11-р дунд сургуулийн сурагчдыг Казакстан улсад болсон Олон улсын математикийн олимпиадад оролцоход нь туслалаа;
- Бага насны хүүхдүүдэд зориулсан замын хөдөлгөөний дүрмийн зурагт номыг гаргахад дэмжлэг үзүүлэв.

Нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд:

- Хавдар Судлалын Үндэсний Төвийн Хүүхдийн тасагт Химийн тасгийг шинээр нээж өгөв;
- Монголын Хүүхдүүдийн Төлөө Төвийн барьж буй өнчин хүүхдүүдийн асрамжийн газарт тэтгэлэг үзүүлэв;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хандив өргөх Японы найрал дуучдын тогтолтыг ивээн тэтгэв;



- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Салхич шувуу” төрийн бус байгууллагын нэг гишүүдийг АНУ-д зорчиж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх болон Засгийн Газар, иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцооны талаарх туршлага солилцох хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэв.

Соёл урлагийг дэмжих чиглэлээр:

- Монголын болон олон улсын дуурь, бүжиг, сонгодог урлагийг хөгжүүлэхдэд хувь нэмрээ оруулж Дуурь Бүжгийн Эрдмийн Театрт үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлэв;
- Монголын уламжлалт хөгжмийн зэмсэг болох Морин хуур хөгжмийг сурталчлан таниулж буй Монгол Улсын Морин Хуурын Чуулгын “Хайрыг хөгжимдөхүй” цомгийг гаргахад ивээн тэтгэлэг үзүүлэв;
- Олимпийн наадамд оролцох тамирчдаа дэмжиж, Монголын Үндэсний Олимпийн Хорооны албан ёсны түвшнээс байгууллагаар үргэлжлүүлэн ажиллаж байна;
- 2010 оны Гуанжунийн Азийн наадамд оролцсон Монголынхоо баг тамирчдыг Азийн наадмын албан ёсны түвшнээс China UnionPay байгууллагатай хамтран дэмжив;
- Карт эзэмшигчдийнхээ дунд сугалаат аян зарлан явуулж, азтай 10 харилцагчаа Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад болсон Хөлбөмбөгийн ДАШТ үзүүлэв.

Хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр:

- Хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах асуудал нь Банкны бүхий л түвшинд авч хэлэлцдэг томоохон асуудал бөгөөд хүрээлэн буй орчинд үлдээж буй үр нөлөөг үйл ажиллагааныхаа үе шат бүхэнд анхаарч үздэг;
- Олон төрлийн санал санаачлагуудыг хэрэгжүүлж, нүүрстөрөгч болон диоксид ялгаруулахгүйн тулд Төв болон салбар нэгжүүдийнхээ хэмжээнд дахин боловсруулах бүтээгдэхүүн хэрэглэхийг эрхэмлэж, ус болон цахилгаан, цаасны хэрэглээг бууруулахыг эрмэлзэж байна;
- Ногоон дэлхий, ногоон эдийн засгийн талаарх хүмүүсийн ойлголт мэдлэгийг тэлэх үүднээс бүх ажилтнуудаа оролцуулсан “Ногоон дэлхий надаас эхтэй” өдөрлөгийг зохион явууллаа.

2010 онд Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас шалгаруулдаг “ТОП-5 банк” шагналыг 8 дахь жилдээ хүртсэн бөгөөд Мастеркарт Ворлдвайд байгууллагаас “Шилдэг бүтээгдэхүүн нэвтрүүлэгч”, Вестерн Юнион байгууллагаас “Бүс нутгийн бүтээмжийн аварга” шагналыг тус тус хүртсэн юм.



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД:

Хадгаламж, харилцах дансны үйлчилгээ

- Байгууллагын харилцах данс
- Байгууллагын хадгаламж
- Овердрафт
- Алтны хадгаламж

Эскроу дансны үйлчилгээ

Зээлийн үйлчилгээ

- Байгууллагын зээл
 - Эргэлтийн хөрөнгийн зээл
 - Зээлийн шугам
 - Хөрөнгө оруулалтын зээл
 - Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээл
 - Ашигт малтмалын зээл
 - Ногоон зээл
- Төслийн зээл
 - Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээл-ОУ-ын Хөгжлийн Ассоциаци
 - Ногоон зээлийн баталгааны сан-Мерси кор
 - Дэлхийн банк-Техникийн тусламж-2
 - Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Зээл-Азийн Хөгжлийн Банк
 - "Атарын 3-р аян"
 - Төслийн зээлүүд /MYXAYT/

Санхүүгийн түрээсийн үйлчилгээ

- Хүнд машин механизм
- Тоног төхөөрөмж
- Автомашин

Худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн

- Аккредитив
- Баримттай инкасс
- Төлбөрийн хөнгөлөлт

Баталгаа

- Тендерийн баталгаа
- Урьдчилгаа төлбөрийн баталгаа

Гадаад валютын арилжаа

Картын үйлчилгээ

- Байгууллагын МастерКарт карт
 - Платинум
 - Алтан

- Стандарт
- Хосолсон валюттай карт (төгрөг/доллар, төгрөг/евро)
- Байгууллагын Виза карт
 - Платинум
 - Алтан
 - Энгийн
 - Хосолсон валюттай карт (төгрөг/доллар, төгрөг/евро)
- Харилцагч байгууллагын ажилчдад зориулсан карт
 - МастерКарт
 - Виза карт
 - Цалингийн карт
 - Бэлгийн карт
 - Нандин карт
 - Юаний карт

Ко-брэнд карт

- МИАТ миллийж карт
- Air Network карт
- MYXAYT-ийн Виза алтан карт

E-банкны үйлчилгээ

- Интернэт банк
- Мобайл банк
- SMS банк
- Е-билинг
- SMS-ээр мэдээлэх үйлчилгээ
- Электрон худалдаа
- Автомат машины үйлчилгээ
- Дуудлага хүлээн авах төв

Төлбөр тооцооны үйлчилгээ

- Вестерн Юнион мөнгөн гүйвуулгын үйлчилгээ
- Олон улсын төлбөр тооцооны үйлчилгээ
- Дотоодын мөнгөн гүйвуулгын үйлчилгээ

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Хөрөнгө оруулалтын банк

Бусад үйлчилгээ

- Инкассын үйлчилгээ
- Хадгаламжийн хайрцаг үйлчилгээ
- Цүнхээр мөнгө хураах үйлчилгээ



ИРГЭДЭД:

Хадгаламж, харилцах дансны үйлчилгээ

- Харилцах данс
- Овердрафт
- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж
- Хөвөгч хүүтэй хадгаламж
- Урьдчилсан хүүт хадгаламж
- Хадгаламжийн сертификат
- Алтны хадгаламж
- Хуримтлалын хадгаламж
- "Алтан түлхүүр" хүүхдийн хадгаламж

Эскроу дансны үйлчилгээ

Зээлийн үйлчилгээ

- Жижиг дунд бизнесийн зээл
 - Зээлийн шугам
 - Эргэлтийн хөрөнгийн зээл
 - Хөрөнгө оруулалтын зээл
- Төслийн зээл
 - АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл
 - ЖАИКА-2 үе шаттай төслийн зээл
 - Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн жижиг дунд бизнесийг дэмжих зээл
 - Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг-Зээлийн баталгаа
 - Ногоон зээлийн баталгааны сан-Мерси кор
 - Хэрэглээний зээл
 - Өрхийн зээл
 - Цалингийн зээл
 - Автомашины зээл
 - Орон сууцны засварын зээл
 - Сургалтын зээл
 - Хадгаламж барьцаалсан зээл
 - Картын зээл
- Орон сууцны зээл

Картын үйлчилгээ

- Мастеркарт
 - Платинум
 - Алтан
 - Энгийн
 - Хосолсон валюттай карт (төгрөг/доллар,

төгрөг/евро)

- Маestro (оюутны)
- Бэлгийн карт
- Нандин карт
- Виза карт
 - Платинум
 - Алтан
 - Энгийн
 - Хосолсон валюттай карт (төгрөг/доллар, төгрөг/евро)
 - Виза электрон (оюутны)
 - Бэлгийн карт
 - Нандин карт
 - Юаний карт
 - Американ экспресс картаар үйлчилэх
- Ко-брэнд карт
 - МИАТ миллийж карт
 - Air Network карт
 - MYXAYT-ийн Виза алтан карт

Е-банкны үйлчилгээ

- Интернэт банк
- Мобайл банк
- Онлайн данс нээх үйлчилгээ
- Карт онлайнараар захиалах үйлчилгээ
- SMS банк
- Е-билинг
- SMS-ээр мэдээлэх үйлчилгээ
- Электрон худалдаа
- Автомат машины үйлчилгээ
- Дуудлага хүлээн авах төв

Төлбөр тооцооны үйлчилгээ

- Вестерн Юнион мөнгөн гүйвуулгын үйлчилгээ
- Олон улсын төлбөр тооцооны үйлчилгээ
- Дотоодын мөнгөн гүйвуулгын үйлчилгээ

Хувийн банкны үйлчилгээ

- Хөрөнгийн удирдлага

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Бусад үйлчилгээ

- Инкассын үйлчилгээ
- Хадгаламжийн хайрцаг үйлчилгээ
- Цүнхээр мөнгө хураах үйлчилгээ



БАНКНЫ САЛБАР НЭГЖҮҮДИЙН ХАЯГ

ГОЛОМТ БАНКНЫ ТӨВ АЛБА

Бодь цамхаг, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 210620A

Утас:+(976-11) 311971, 311530

Факс:+(976-11) 313155, 312307

И-шуудан: mail@golomtbank.com

Вэб: <http://www.golomtbank.com>

УЛААНБААТАР ХОТЫН САЛБАРУУД

Банкны нэгж	Хаяг	Утас, Факс
Төв салбар	Монголбанкны байрны Б корпус, Худалдааны гудамж 6/2, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-310759, 313155 Факс: +(976-11)-326231
Сансар салбар	Баянцээл ХХК худалдааны төвийн 1-р давхар, 7-р хороо, Их тойруу, 15-р хороолол, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-456980 Факс: +(976-11)-456829
Сансар зээлийн төв	Баянцээл худалдааны төв, 15-р хороолол, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-458898 Факс: +(976-11)-456829
Нисэх тооцооны төв	"Чингис хаан" олон улсын онгоцны буудал, Хан-уул дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-283205 Факс: +(976-11)-283205
100 айл тооцооны төв	"Анд интернэшнл" компанийн байр, 7-р хороо, 11-р хороолол, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-350542 Факс: +(976-11)-350544
Ард Салбар	41 тоот "Он энд Он" ХХК-н байр, Бага тойруу, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-320712 Факс: +(976-11)-330436
Солонго салбар	Тулга дөрвөн уул ХХК-н үйлчилгээний төвийн 1-р давхар /хуучнаар Солонго ресторан/, Д.Нацагдоржийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-320814 Факс: +(976-11)-318479
Саппоро салбар	Бармон ХХК байрны 1.2-р давхар, 1-р хороолол, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-681267 Факс: +(976-11)-680367
Москва салбар	Бодь интернэшнл ХХК-н байрны 1.2-р давхар, 14-р хороо, 4-р хороолол, Л.Энэбишийн өргөн чөлөө-9, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот.	Утас: +(976-11)-305419 Факс: +(976-11)-368602
Гааль Тооцооны төв	Хотын Гаалийн газрын байр, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-242943 Факс: +(976-11)-242943
Багануур Тооцооны төв	Хэрлэн худалдааны төвийн 1-р давхар, Д.Нацагдоржийн гудамж, Багануур дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-01-21)-22333 Факс: +(976-01-21)-20818
Зээлийн төв салбар	"Бурхан халдун групп" ХХК-н үйлчилгээний төвийн байр, Энхтайвны өргөн чөлөө, 2-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-330072 Факс: +(976-11)-330621
Голомт хотхон салбар	Бодь интернэшнл группын "Голомт хотхон" цогцолборын "I" блокны байр, Үндсэн хуулийн гудамж 4-2, 5-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-322943 Факс: +(976-11)-322943



Цамбагарав Тооцооны төв	Цамбагарав худалдааны төв, 1-р хороолол, Сонгино хайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-680762 Факс: +(976-11)-680763
Цэцээ гүн Тооцооны төв	"Цэцээ гүн" сургуулийн байр 1-р давхар, 4-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-316395 Факс: +(976-11)-316395
Тэди Тооцооны төв	Самбуугийн гудамж-46, 5-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-325970 Факс: +(976-11)-325970
120 мянгат Тооцооны төв	120 мянгат ўйлчилгээний төв, 1-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-70130080 Факс: +(976-11)-70120018
Тамир Тооцооны төв	Ард Аюушийн гудамж, 3-р хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-304959 Факс: +(976-11)-304959
Нарантуул Тооцооны төв	Нарантуул Олон Улсын Худалдааны Төв Захиргааны байр 2-р давхар, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-457018
Их дэлгүүр Тооцооны төв	"Зан интернэшнл"компанийн байр 1, 2-р давхар,4-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-311530, 311971 Факс: +(976-11)-70111352
Чандмань Тооцооны төв	Чандмань төв, Лениний музей, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-70120520 Факс: +(976-11)-70120520
Баянзүрх Тооцооны төв	Во-Во худалдааны төв 1-р давхар,15-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-458250 Факс: +(976-11)-462892
Номин Тооцооны төв	Улсын Их Дэлгүүр 5-р давхар, Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-313232 Факс: +(976-11)-314242
Цэнтрал Тауэр Тооцооны төв	Цэнтрал Тауэр 4-р давхар, Сүхбаатарын талбай, 4-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-326474 Факс: +(976-11)-326494
32-ын тойрот Тооцооны төв	Сансар-32 худалдааны төв 2-р давхар, 32-ын тойрог, 12-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-77443232 Факс: +(976-11)-77443131
Сонгино хайрхан Тооцооны төв	Жавхлант компанийн байр 1-р давхар, 19-р хороо, Сонгино-хайрхан дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-636205 Факс: +(976-11)-636217
Моннис Тооцооны төв	Моннис Тауэр 4-р давхар, 4-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Факс: +(976-11)-321273
ИБМУТ Тооцооны төв	ИБМУТ-ийн 2-р давхар, Цагдаагийн гудамж, 11-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-350267
ШУТИС Тооцооны төв	ШУТИС-ийн төв байр 1-р давхар, 8-р хороо, Бага тойруу, Залуучуудын өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-70111530



ОРОН НУТАГ ДАХ САЛБАРУУД

Банкны нэгж	Хаяг	Утас, Факс
Дорнод Тооцооны төв	Хишиг Агро компанийн байр, 7-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг	Утас: +(976-01-582)-22703 Факс: +(976-01-582)-22702
Дорнод Хэрлэн Тооцооны төв	24-р байр 1-р давхар, 6-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг	Утас: +(976-01-582)-22704 Факс: +(976-01-582)-22704
Замын-Үүд Тооцооны төв	Замын-Үүд вокзал, 2-р давхар, 1-р баг, Замын -Үүд сум, Дорноговь аймаг	Утас: +(976-025-245)-43773 Факс: +(976-025-245)-43773
Орхон Салбар	Си то төв 1-р давхар, Амарын гудамж, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976-01-352)-25100 Факс: +(976-01-352)-22510
Орхон-Пирамид Тооцооны төв	Согоот баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976-01-352)-23300 Факс: +(976-01-352)-23300
Орхон-Зээлийн Тооцооны төв	Орхон-чандмань компанийн байр, 2-р давхар, Уурхайчин баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976-01-352)-32100 Факс: +(976-01-352)-32100
Дархан Салбар	Нийгмийн даатгалын хэлтсийн байр, 13-р баг, Дархан сум, Дархан-Уул аймаг	Утас: +(976-01-372)-27136 Факс: +(976-01-372)-27136
Дархан Зээлийн төв	Мандах Баясах компанийн байр, 8-р баг, Дархан сум, Дархан-Уул аймаг	Утас: +(976-01-372)-27136 Факс: +(976-01-372)-27136
Хөвсгөл Тооцооны төв	Нэмэн компанийн байр, 3-р хороо, Мөрөн сум, Хөвсгөл аймаг	Утас: +(976-01-382)-21474 Факс: +(976-01-382)-21474
Өмнөговь Тооцооны төв	3-р баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг	Утас: +(976-01-532)-23991 Факс: +(976-01-532)-23990
Ховд Салбар	Монголбанкны байр, 1-р давхар, Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг	Утас: +(976-01-432)-22195 Факс: +(976-01-432)-22195
Ховд Баянбүрд Тооцооны төв	Баянбүрд төв, 1-р давхар, Жаргалант баг, Жаргалант сум, Ховд аймаг	Утас: +(976-01-432)-22175 Факс: +(976-01-432)-22175
Баян-Өлгий Салбар	Соёлын төвийн байр, 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг	Утас: +(976-01-422)-22008 Факс: +(976-01-422)-22008
Баян-Өлгий Тооцооны төв	"Армон" дэлгүүр 1-р давхар, 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг	Утас: +(976-01-422)-22008 Факс: +(976-01-422)-22001
Дорноговь Тооцооны төв	Ванжилдоржийн байр, 1-р баг, Сайншанд сум, Дорноговь аймаг	Утас: +(976-01-522)-42792 Факс: +(976-01-522)-42792
Цогцэций Тооцооны төв	№1-7, Ямаан хүрэн баг, Цогцэций сум, Өмнөговь аймаг	Утас: +(976-01-532)-26520
Ханбогд Тооцооны төв	Гоёот 1-7 байр, Ханбогд сум, Өмнөговь аймаг	Утас: +(976-01-522)-42792 Факс: +(976-01-522)-42792
Гурван тэс Тооцооны төв	Хурд супермаркет, 1-р давхар, 4-р баг, Гурван Тэс сум, Өмнөговь аймаг	Утас: +(976-01-534)-42266 Факс: +(976-01-534)-42244
Сэлэнгэ Тооцооны төв	Монгол даатгалын байр, 1-р давхар, Сүхбаатар сум, Сүхбаатар аймаг	Утас: +(976-01)-013 6222318 Факс: +(976-01)-013 6222318
Сүхбаатар Тооцооны төв	Монос төв, 7-р баг, Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг	Утас: +(976-01-512)-22006 Факс: +(976-01-512)-22005

ГАДААДАД БҮЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Банкны нэгж	Хаяг	Утас, Факс
Бээжин дэх төлөөлөгчийн газар	10E,CITIC building Tower A19, Jianguomen Dajie, Beijing, China 100004	Утас: +(86-10)-65033876 Факс: +(86-10) -65923727 Гар утас: +(86-139) -11737254 И-мэйл: golomt@public2.bta.net.cn
Лондон дахь Төлөөлөгчийн газар	27 Throgmorton Street, London EC2N 2AQ, United Kingdom	Утас: +(44-0)-20 7382 9900 Факс: +(44-0) -20 7382 9988 И-мэйл: jeremy.denton-clark@gbrw.com И-мэйл: mail@gbrw.com





ГОЛОМТ БАНК



ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН ТАЙЛАН

Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032
+976 11 312005
Fax: +976 11 312042
www.ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН Голомт Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчид

Бид Голомт Банк ХХК-ийн 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн дараах санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор Банкны захирлуудын хүлээх үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь Банкны захирлуудын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залilan, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илрхийлэгдсэнээс үүсэх эрдслийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлээмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.

Бусад асуудлууд

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 91 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Банкны хувьцаа эзэмшигчид зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Чунг Синг Петр Ёнг
Гүйцэтгэх Захирал

ГОЛОМТ БАНК ХХК
**2010 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

	Тодруулга	2010 Мян.Төг	2009 Мян.Төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	3	111,156,503	81,831,663
Хүү болон түүнтэй адилтгах зардал	4	(81,448,479)	(57,904,932)
Хүүгийн цэвэр орлого		29,708,024	23,926,731
Шимтгэл хураамжийн орлого	5	12,655,448	9,433,139
Шимтгэл хураамжийн зардал	5	(2,742,830)	(2,165,341)
Шимтгэл хураамжийн цэвэр орлого		9,912,618	7,267,798
Арилжааны цэвэр орлого	6	83,843	188,892
Бусад үйл ажиллагааны орлого	7	6,752,622	5,819,115
Үйл ажиллагааны орлого		46,457,107	37,202,536
Үйл ажиллагааны зардал	8	(21,241,842)	(16,654,834)
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардлын өмнөх ашиг		25,215,265	20,547,702
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	9	982,594	(3,239,995)
Татварын өмнөх ашиг		26,197,859	17,307,707
Орлогын албан татварын зардал	10	(6,145,111)	(4,138,119)
Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох тайлант жилийн ашиг		20,052,748	13,169,588
Бусад дэлгэрэнгүй орлогууд			
<i>Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгүүд</i>			
Тайлант жилийн гарс		(272,027)	(24,071)
Орлогын тайланд тусгасан, үнэ цэнийн бууралтын гарзын дахин ангилал		-	51,029
		(272,027)	26,958
Бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдэхүүн хэсэгт ногдох орлогын албан татвар		-	-
Тайлант жилийн, татварын дараах бусад дэлгэрэнгүй орлого		(272,027)	26,958
Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох, тайлант жилийн, татварын дараах бусад дэлгэрэнгүй орлого		19,780,721	13,196,546

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК
2010 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2010 Мян.Төг	2009 Мян.Төг
АКТИВ			
Бэлэн мөнгө ба Төв банк дахь харилцах	11	138,054,713	157,871,951
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	12	249,898,638	216,511,438
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	13	4,486	-
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Борлуулахад бэлэн	14	7,457,330	1,026,696
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Дуусгавар хугацаа хүртэл эзэмших	14	355,658,482	118,518,578
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Арилжаалах зорилгоор эзэмшиж буй	14	345,472	-
Урвуу репо хэлцэл	15	3,997,668	-
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	784,604,947	505,298,994
Үндсэн хөрөнгө	17	24,508,983	5,347,809
Биет бус хөрөнгө	18	1,104,864	1,395,331
Бусад актив	19	8,300,854	7,138,078
НИЙТ АКТИВ		1,573,936,437	1,013,108,875
ПАССИВ			
Бусад банк, санхүүгийн байгуулагуудын харилцах, хадгаламж	20	80,833,669	52,931,634
Харилцагчдын харилцах, хадгаламж	21	1,317,499,322	795,251,008
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	13	1,506,132	381,425
Зээлээр авсан эх үүсвэр	22	28,386,592	62,594,970
Хоёрдогч өглөг	23	42,964,281	14,219,900
Бусад өр төлбөр	24	18,157,483	15,153,476
Репо хэлцэл	25	-	7,732,840
Татварын өглөг		791,405	826,790
НИЙТ ПАССИВ		1,490,138,884	949,092,043
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Дүрмийн сан	26	21,934,142	21,934,142
Борлуулахад бэлэн сан		(297,935)	(25,908)
Хуримтлагдсан ашиг		62,161,346	42,108,598
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		83,797,553	64,016,832
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		1,573,936,437	1,013,108,875

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК

2010 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Энгийн хувьцаа мян.төг	Борлуулахад бэлэн сан мян.төг	Хуваарилагдах Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт мян.төг
2009 оны 1-р сарын 1-нээр	21,934,142	(52,866)	28,939,010	50,900,110
Нийт бусад дэлгэрэнгүй орлого	-	26,958	13,169,588	13,196,546
2009 оны 12-р сарын 31-нээр ба 2010 оны 1-р сарын 1-нээр	21,934,142	(25,908)	42,108,598	64,016,832
Нийт бусад дэлгэрэнгүй орлого	-	(272,027)	20,052,748	19,780,721
2010 оны 12-р сарын 31-нээр	21,934,142	(297,935)	62,161,346	83,797,553

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК
2010 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2010 MNT '000	2009 MNT '000
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	26,197,859	17,307,707
Тохируулга :-		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,873,137	1,770,395
Биет бус хөрөнгийн хорогдуулга	976,622	826,428
Үнэ цэнийн бууралтын тооцоллоос үүссэн хүүгийн зардал	129,165	84,681
Данснаас хассан үндсэн хөрөнгө	12,505	5,598
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнэ бууралтын алдагдал	(984,302)	2,634,548
Бусад хөрөнгийн үнэ цэнэ бууралтын алдагдал	1,708	605,447
Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(45,769)	57,244
Арилжаалах зорилгоор зээмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(78,084)	-
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	(7,861)	(7,996)
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын борлуулалтын гарз	8,156	-
Валютын форвард хэлцлийн бодит бус олз	(4,486)	-
Хураан авсан барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	666,837	305,173
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарз	-	51,029
Ханшны өөрчлөлтийн бодит бус алдагдал	1,273,765	1,526,228
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	30,019,252	25,166,482
Үйл ажиллагааны активын өөрчлөлтууд:-		
Монголбанк дахь зайлшгүй байлагах нөөцийн харилцах данс	(7,961,000)	(19,286,800)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(284,263,616)	(54,086,274)
Бусад актив	(1,831,321)	(3,308,102)
Үйл ажиллагааны пассивын өөрчлөлтууд:-		
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	27,902,035	44,907,747
Харилцагчдын харилцах, хадгаламж	522,248,314	290,080,103
Бусад өр төлбөр	6,046,149	7,705,560
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	-	675,861
Үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ	292,159,813	291,854,577
Орлогын албан татварын төлөлт	(6,180,496)	(3,240,912)
Үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ	285,979,317	288,613,665
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө оруулалт	(5,633,937,197)	(813,915,781)
Борлуулсан болон хугацаа дуусгавар болсон санхүүгийн хөрөнгө оруулалтын орлого	5,389,819,088	720,935,416
Худалдан авсан урвуу репо хэлцлүүд	(3,997,668)	-
Үндсэн хөрөнгө борлуулалтын орлого	33,552	182,032
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(21,072,507)	(2,165,019)
Худалдан авсан репо хэлцлүүд	740,203,868	389,278,029
Хугацаа дуусгавар болсон репо хэлцлийн орлого	(747,936,708)	(397,209,440)
Худалдан авсан биет бус хөрөнгө	(686,155)	(652,907)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(277,573,727)	(103,547,670)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээлийн санхүүжилтийн татан авалт	9,303,161	41,716,804
Зээлийн санхүүжилтийн эргэн төлөлт	(43,511,539)	(82,248,300)
Хоёрдогч өглөгийн эргэн төлөлт	31,411,750	-
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	(2,796,628)	(40,531,496)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	5,608,962	144,534,499
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	355,096,589	210,562,090
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл (Тодруулга 27)	360,705,551	355,096,589

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА – 2010 ОНЫ 12 САРЫН 31

1 БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус банкны үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкнаас олгосон 8 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ байна. Тайлант хугацаанд банкны үйл ажиллагааны мөн чанарт томоохон өөрчлөлт гараагүй болно.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг албан хаяг нь Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот 210620А Монгол Улс.

Банкны толгой компани Монгол улсад бүртгэлтэй Бодь Интернэшнл ХХК юм.

ТУЗ-ЫН 2011 ОНЫ 3 САРЫН 17-НЫ ӨДРИЙН ШИЙДВЭРЭЭР БАНКНЫ 2010 ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БАТАЛЖ, НИЙТЭД МЭДЭЭЛЭХИЙГ ЗӨВШӨӨРСӨН.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангууд нь бодит үнээр хэмжигдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүр болон борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээг эс тооцвол түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол төгрөгөөр, мянганы орноор тайлгасан.

Нийцлийн мэдэгдэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь Нягтан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

(а) Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

"Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа" эсвэл "Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх" гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдээс бусад бүх хүйтэй санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүгийн хувийг хэрэглэн орлогын тайландаа "Хүү болон түүнтэй адилтгах орлого" ба "Хүү болон түүнтэй адилтгах зардал" гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогос бусад хүүгийн орлогыг аккруэл сууриар орлого, үр дүнгийн тайландаа хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(б) Хураамж ба шимтгэлийн орлого

Банкны шимтгэл, хураамжийн орлого ихэвчлэн мөнгөн гүйвуулгын хураамж, зээл олголтын хураамж, дебит болон кредит картын хураамж болон харилцах дансны зарлагын шимтгэлээс бүрддэг. Хураамж ба шимтгэлийн орлогыг үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь голдуу аккруэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

Зээл олгогдох магадлалтай зээлийн үүргийн хураамж болон зээлтэй холбоотой бусад хураамжуудыг (өсөн нэмэгдэх зардлуудын хамт) хойшлуулж, зээлийн үр ашгийн хүүгийн залруулга гэж хүлээн зөвшөөрдөг.

(в) Гадаад валютын хөрвүүлэлт

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжүүрүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Ханшийн бүх зөрүүг орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ. Түүхэн өртэг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

(г) Орлогын албан татвар

Банк нь Монгол Улсын татварын хууль, тогтоомжид заасан татвар ногдох орлогыг нэмэгдүүлэхгүй орлого болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулсан, санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон өөрийн орлогоос тайлан тэнцилийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр бодож өөрийн орлогын албан татварын хэмжээг тодорхойлдог.

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн дүнгийн хооронд гарах түр зөрүүнд, өр төлбөрийн аргыг ашиглан хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрнө. Үндсэндээ татвар ногдох бүх түр зөрүүнд хойшлогдсон татварын өрийг татвараас хасагдах бүх түр зөрүү, ашиглагдаагүй татварын хөнгөлөлт ба чөлөөлөлтөнд дараа тооцох татварын авлагыг тэдгээрт харгалзах татвар ногдох ашиг орж ирэх нь тодорхой болсон үед хүлээн зөвшөөрнө. Хэрэв түр зөрүү нь гүүдвил, сөрөг гүүдвил, эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс бий болсон ба нягтлан бодох бүртгэлийн ашиг, татвар ногдох ашгийн аль алиинд нөлөө үзүүлэхгүй бол хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөхгүй.

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй эсвэл үйлчилж хараахан эхлээгүй байгаа татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр телбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно. Өөрийн хөрөнгөд шууд бүртгэх гүйлгээнээс үссэн (энэ тохиолдолд хойшлогдсон татварыг мөн өөрийн хөрөнгөд шууд бүртгэнэ), эсвэл бизнесийн нэгдэлээс үссэн (энэ тохиолдолд хойшлогдсон татвар нь үссэн гүүдвил эсвэл сөрөг гүүдвилийн дунд орно) хойшлогдсон татвараас бусад бүх хойшлогдсон татварыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

(д) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө ба Монголбанк болон бусад банкинд байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэнэ.

(е) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг нь зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг эдгээр худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр нь хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл банк хөрөнгийг худалдах, худалдан авахыг амласан өдөр хүлээн зөвшөөрнө. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны өдрөөр хүлээн зөвшөөрнө.

(ii) Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт

Анх хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нь тэдгээрийн зориулалт, шинж чанараас шалтгаална. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнээр нь хэмжих ба харин бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэхгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ дээр тэдгээртэй шууд холбоотой худалдан авалтын эсвэл гаргалтын ахиуц зардлуудыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

(iii) Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгддэг

үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа

үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнийн өөрчлөлтийг ""Арилжааны цэвэр орлого"" -д тусгадаг. Хөрвөх чадвартай, хоёрдогч өглөт агуулагдсан өөрийн хөрөнгө болон валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэх мэт өөр санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг салгаж авч үзэх ёстой ба агуулагдсан болон агуулагч гэрээнүүдийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүд нь нягт хамааралгүй, мөн агуулагч гэрээг нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй ба анхны хүлээн зөвшөөрөлтөөр бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгддэг ангилалд оруулагүй байвал тэдгэрийй бодит үнээр нь бүртгэнэ.

Үндсэн гэрээнээс нь салгасан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнээр нь бүртгэдэг ба өөрчлөлтийг нь орлого, зарлагын дансанд тайлагнадаг.

(iv) Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад, арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрүүдийг багтаасан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь бүртгэнэ. "Арилжааны цэвэр орлого"-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Хүүгийн болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл гэрээний төлбөрийн эрх үүссэн үед "Цэвэр арилжааны орлого"-д бүртгэнэ.

Энэ ангилалд өрийн үнэт цаас, өөрийн хөрөнгө болон голдуу ойрын хугацаанд буцаан худалдан авах эсвэл худалдах зорилгоор эзэмшиж байгаа үнэт цааснууд багтана.

(v) Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Дараах нөхцлүүд хангагдсан үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө энэ ангилалд оруулахаар шийдвэрлэж болно. Үүнд:

- энэхүү шийдвэр нь активыг хэмжих эсвэл активаас үүсэх олз, гарзыг ялгаатай сууриар орлого, зардалт хүлээн зөвшөөрсөнөөс бий болох тухштай бус байдлыг арилгах эсвэл дорвitoойгоор бууруулах бол эсвэл,
- санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бүлгийн нэг хэсэг эсвэл тэдгээрийг эрсдлийн удирдлагын бодлого эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу бодит үнэ дээр нь сууринлан удирдаж, гүйцэтгэлийг нь хэмждэг бол эсвэл,
- санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрт багтаж байгаа бол (гэхдээ агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь мөнгөн урсгалыг нь ихээхэн хэмжээгээр өөрчлөхгүй нь эсвэл бага хэмжээний судалгааны үндсэн дээр эсвэл огт судалгаагүйгээр уг хэрэглүүр тусдаа бүртгэгдэхгүй нь тодорхой байгаагас бусад тохиолдолд).

Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь тусгана. Бодит үнийн өөрчлөлтийг "Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн цэвэр олз эсвэл гарз" дансанд бүртгэнэ. Орж ирэх эсвэл төлөх хүүг гэрээний нөхцлийн дагуу хүүний орлого, зардалт хуримтлуулж, ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь "Үйл ажиллагааны бусад орлого"-д бүртгэнэ.

(vi) 'Анхны өдөр'-ийн ашиг

Идэвхигүй зах зээл дээрх арилжааны үнэ нь ижил хэрэглүүрийн хувьд зах зээл дээр ажиглаж болохуйц одоогийн зах зээлийн бодит үнээс зөрүүтэй эсвэл зөвхөн зах зээл дээр ажиглаж болохуйц өгөгдлийг багтаасан хувьсагчтай үнэлгээний загварт үндэслэн тогтоосон бодит үнээс зөрүүтэй байвал уг зөрүүг (энэ нь бодит үнэ ба арилжааны үнийн зөрүү буюу анхны өдрийн ашиг юм) Банк орлого, үр дүнгийн тайланийн "Арилжааны цэвэр орлого"-д шууд хүлээн зөвшөөрнө. Ажиглах боломжгүй өгөгдлийг ашигласан тохиолдолд арилжааны үнийн зөрүү ба загварын үнийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд өгөгдлүүд нь ажиглаж болохуйц болох үед эсвэл тухайн хэрэгслийг уг хүлээн зөвшөөрөх үед нь хүлээн зөвшөөрнө.

(vii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших эерэг хандлага, чадвартай, тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй ба тогтоосон хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүдийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтгыг үр ашигт хүүгийн арга ажиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайланийн "Хүү болон түүнтэй адилтгах орлого"-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланийн "Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал" хэсэгт хүлээн зөвшөөрнө.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(e) Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараа тайлангийн хэмжилт (Үргэлжлэл)

(viii) **Банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа**
Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж болон харилцагчад олгосон зээл ба урьдчилгаа нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй санхүүгийн хэрэгслүүд юм. Эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь бодино хугацаанд шууд эсвэл дахин борлуулах зорилгогүй ба "Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө", "Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт" эсвэл "Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх" гэсэн ангилалд багтахгүй. Анх хэмжэсний дараа бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж болон харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өргтгээс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өргтгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оруулан тооцно. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Хүү болон түүнтэй адилтгах орлого"-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Зээлийн алдагдлын зардал" хэсэгт хүлээн зөвшөөрнө.

(ix) **Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт**

Анх хүлээн зөвшөөрхөдөө "Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт" гэж ангилсан эсвэл "Бодит үнийн өөрчлөлт нь орлого зарлагын дансанд бүртгэгдэх", "Дуусгавар хугацаа хүртэл эзэмших", "Зээл ба урьдчилгаа" гэсэн ангилалд багтаагүй санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэглүүр, хөрөнгө оруулалтын байгууллагад хийсэн хөрөнгө оруулалтууд ба мөнгөний зах зээл ба бусад өрийн хэрэгслүүд багтдаг.

Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Бодит бус ашиг алдагдлыг шууд өөрийн хөрөнгөд "Борлуулахад бэлэн сан"-д хүлээн зөвшөөрдөг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өмнө хүлээн зөвшөөрсэн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Үйл ажиллагааны орлого" эсвэл "Бусад үйл ажиллагааны зардал"-д хүлээн зөвшөөрнө. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү хөрөнгө оруулалттай байвал тэдгээрийг борлуулахдаа "эхэлж авснаа эхэлж зарлагада" зарчмыг хэрэгжүүлсэн гэсэн ойлголттай байгаа. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг өөрт байх хугацаанд олсон хүүг үр ашигт хүүгийн аргаар олсон хүүгийн орлого гэх тайлагнадаг. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг өөрт байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед дэлгэрэнгүй орлогын тайланд "Үйл ажиллагааны бусад орлого"-д хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал"-д хүлээн зөвшөөрөөд борлуулахад бэлэн сангаас хасч өгнө.

(x) **Гаргасан өрийн хэрэгсэл ба зээлээр авсан бусад эх үүсвэр**

Гэрээт зохицуулалтын агуулга нь өөрийн тодорхой тооны хувьцааны оронд бэлэн мөнгө эсвэл өөр ямар нэг санхүүгийн хөрөнгийг өгөх үүргийг эсвэл үнээс өөр аргаар өөрийн өр төлбөрийг барагдуулах үүргийг Банкинд үүсгэж байгаа үед, Банкаас гаргасан бөгөөд "Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх" гэж ангиллагаагүй санхүүгийн хэрэглүүрүүдийг "Гаргасан өрийн хэрэгсэл ба зээлээр авсан бусад эх үүсвэр" гэсэн нэрээр өр төлбөрийн хэсэгт ангилна. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэгслүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг салгаж тус тусд нь бүртгэх бөгөөд өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийн дүн нь нийт дүнгээс өр төлбөрийн хэсгийн бодит үнийг (уг өр төлбөр үүсэн өдрийн бодит үнэ) хассан дүн байна.

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээллэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өргтгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өргтгийг тооцоходо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

(ë) **Үнэт цаасжуулалт**

Банк нь өөрийн үндсэн үйл ажиллагааны нэг хэсэг болгон, тусгай зорилго бүхий байгууллагад санхүүгийн хөрөнгөө худалдах замаар санхүүгийн хөрөнгөө үнэт цаасжуулах үйл ажиллагааг явуулдаг. Шилжүүлсэн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн үл хүлээн зөвшөөрч болно. Энэ талаар нягтлан бodoх бүртглийн бодлогын "Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөх" хэсгээс тодруулж болно. Үнэт цаасжуулсан санхүүгийн хөрөнгө дэх хувь оролцоогоо Банк хадгалж үлдэж болох ба үүнийг "Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө" гэж ангилах ба холбогдох олз ба гарзыг "Хүү ба түүнтэй адилтгах орлого" дансанд бүртгэнэ. Үнэт цаасжуулалтын олз, гарз нь үл хүлээн зөвшөөрсэн санхүүгийн хөрөнгийн бүртгэлийн дүн ба авч үлдсэн хувь оролцооны бодит үнэ цэнэ (шилжүүлэг хийсэн өдрийн) дээр үндэслэнэ.

(ж) **Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт**

(i) **Санхүүгийн хөрөнгө**

Дараах тохиолддолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг

эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн ургал хүлээн авах эрх нь дууссан; эсвэл
- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн ургал авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн.
- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн эсвэл Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлэгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн, эсвэл

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, шагнал болон хяналтыг шилжүүлэгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой үргэлжилсэн оролцоо нь борлуулсан ба/эсвэл худалдан авсан опцион (үүнд бэлэн мөнгөөр төлбөр хийгдэг опцион эсвэл ижил төрлийн хэлэлцэр багтсан) хэлбэртэй байвал тус оролцооны дүн нь Банкны буцаан худалдан авч болзошгүй шилжүүлсэн хөрөнгийн дүн юм. Гэсэн хэдий ч, бодит үнэ цэнээр хэмжигдэг хөрөнгийг худалдаа опционтоой үед Банкны үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээ нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон опцион хэрэгжих үнийн аль багаар нь хязгаарлагдана.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо оршин байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр орлуулсан эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба тусынх нь дансны үнийн зөрүүг орлого эсвэл зардлаар хүлээн зөвшөөрнө.

(3) Бодит үнэ цэнийн тодорхойлолт

"Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслүүдийн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн бодит үнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон диллерийн үнэ (урт позицийн хувьд нийлүүлэлтийн үнэ, богино позицийн хувьд эрэлтийн үнэ) -н дээр үндэслэнэ.

Идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэгслүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад цвэр өнөөгийн үнэ цэнийн аргачлал, зах зээлийн үнийн мэдээ нь байдаг ойролцоо төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэгслүүдтэй харьцуулсан арга, опционы үнэлгээний загвар болон бусад тохиромжтой аргууд багтана."

(и) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн бодитоогоор тооцоолох боломжтой ирээдүйн мөнгөн ургалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хундрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн ургалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит егөгдөл бий болох зэрэг орно.

(i) Бусад банкуудад олгосон зээл, тэдгээрт байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа

Хорогдуулсан өргөөр бүртгэгддэг, бусад банкуудад олгосон зээл, тэдгээрт байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны дүнгүүдийн хувьд Банк нь эхлээд чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ. Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой эсвэл ач холбогдолгүй үл харгалzan) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(и) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (Үргэлжлэл)

(i) Бусад банкуудад олгосон зээл, тэдгээрт байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (биеилээ олоогүй буй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хүүгийн орлогыг хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар бууруулсан хөрөнгийн бүртгэлийн дүнгээс үргэлжлүүлэн тооцно. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй ба барьцаа хөрөнгө нь бүрэн ашиглагдсан эсвэл банк уруу бүрэн шилжсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдлийн сангийн хамт данснаас хасна.

Хэрэв дараагийн тайлант жилд үнэ цэнийн бууралтын алдагдлын хэмжээ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдлын улмаас өссөн эсвэл буурсан байвал өмнө хүлээн зөвшөөрсөн эрсдлийн сангийн дансыг бууруулж эсвэл нэмэгдүүлж зарлуулга хийнэ.

Хэрэв өмнө данснаас хассан байсан зээл эргэн төлөгдвөл тус төлөлтийг "Зээлийн алдагдлын зардал" дансны кредит талд бичнэ.

Орж ирнэ гэж тооцолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг олохдоо санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар дискаунтладаг. Зээлийн хүүгийн хувь нь хөвөгч байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжил хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг нь хураан авах нь магадлалтай эсхээс үл хамааран тус барьцааг хураан авч албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтын нэгдсэн байдлаар үнэлэхийн тулд санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад холхүчин зүйлс зэрэг зээлийн эрсдлийн шинж чанарыг агуулсан банкны дотоод зээллэгийн ангиллын системд үндэслэн тэдгээрийг бүлэглэнэ.

Эрсдэлийн бүлэг тус бүр дээр түүхэн дундаж алдагдлыг харгалзах зээлийн үлдэгдэл нь хувааж үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцох энгийн аргачлалыг сонгосон. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын сууринж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ.

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил бүрийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, бүлгийн алдагдал ба тэдгээрийн нөлөөллийг илэрхийлэх бусад хүчин зүйлс орно. Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг барагсах зорилгоор тогтмол хянана.

(ii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нэг бүр дээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсхийг үнэлж үзнэ. Үнэ цэнэ бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба тооцолсон ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг бууруулж, алдагдалын дүнг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнэ.

Хэрэв дараагийн тайлант жилд тооцоолж байсан үнэ цэнийн бууралтын алдагдлын хэмжээ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдлын улмаас буурувал өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдалыг "Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал" дансны кредиттэд бүртгэнэ.

(iii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

"Борлуулахад бэлэн" гэж ангилагдсан өөрийн хөрөнгө оруулалтын хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд бодит үнэ цэнэ нь тус хэрэгслийн өргтөөс их хэмжээгээр эсвэл тогтмол буурч байх явдал ордог. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хөёрын зөрүүнээс дэлгэрэнгүй орлогын тайландаа өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдалыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч дэлгэрэнгүй орлогын тайландаа хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнэ цэнийн өсөлтийг өөрийн хөрөнгөд шууд хүлээн зөвшөөрдөг.

"Борлуулахад бэлэн" гэж ангилагдсан өрийн хэрэгслийн хувьд түүний үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өргтөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгур үзүүлэлтүүд дээр суурилан үнэлнэ. Зээлийн бууруулсан бүртглийн дүнгээс анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцон, хүүг үргэлжлүүлэн хуримтлуулах ба "Хүү ба түнтэй адилтгах орлого"-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант жилд өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь өссөн ба уг өсөлт нь үнэ цэнэ бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайландаа хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдалтай улдадаатай болох нь тогтоогдсон бол, үнэ цэнэ бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулан буцаана.

(iv) Зээлийн шинэчилсэн гэрээ

Банк нь барьцаа хөрөнгийг хурааж өөрийн болгохос илүүтэйгээр аль болох гэрээг шинэчлэн байгуулах боломжийг хайж байдаг. Үндээлийн эргэн төлөлтийн хуваарийг сунгах, зээлийн шинэ нөхцөлийн санал болгох зэрэг ойлголтыг хамруулж болох юм.

Зээлийн гэрээг нэгзт шинэчлэн байгуулсан бол зээлийг хугацаа хэтэрсэн гэж үзэхгүй. Гэрээнд заасан зээлийн шалгур нөхцөлүүд биелж буй эсэх, ирээдүйн зээл төлөлт хийгдэх баталгаа байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн шинэчилсэн гэрээнд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажилладаг. Эдгээр зээл нь зээлийн анхны үр ашигт хүүгийн хувиар тооцоологддог нэг бүрчилсэн болон ниймлэл үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамрагдсаар байж юм.

(й) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайландаа толилуулах эрхтэй. Мастер цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэгтүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь санхүүгийн байдлын тайландаа тус тусад нь толилуулдаг.

(к) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг өргтөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өргтгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүнд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хөёрын аль таарамжтай гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа солисон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх ургсал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацааны дэлгэрэнгүй орлогын тайландаа хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өргтөөр илэрхийлдэг.

Дуусаагүй барилгад элэгдэл байгуулдаггүй. Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн төрөл бүрээр, дараах ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Үүнд:

Барилга, байшин	10 - 40 жил
Түрээсийн хөрөнгийн сайжруулалт	10 жил
Тавилга, тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер	3 жил

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянах үздэг.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(к) Үндсэн хөрөнгө (Үргэлжлэл)

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл тэдгээрийн ашиглалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

(л) Биет бус хөрөнгө

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдалыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Биет хөрөнгийн ашиглалтын хугацаа нь хязгаарлагдмал эсвэл хязгаардагдмал бус байдаг. Хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд эдийн засгийн үр ашигтай ашиглалтын хугацааны турш хорогдуулж, үнэ цэнийн бууралтанд орсон байх магадлалын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг үнэлнэ. Удирдлага хязгаарлагдмал бус хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргачлалыг хамгийн багадаа тайлант жил бурийн эцэст хянаж үздэг. Тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загвар нь өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргыг аль тохиромжтой байдлаар өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гэж авч үзнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Банкны биет бус хөрөнгөд компютерийн програм хангамж болон лицензүүд багтдаг бөгөөд тэдгээр нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай байна. Эдгээр биет бус хөрөнгийг тэдгээрийн ойролцоолон тооцоолсон ашиглалтын хугацаа болох З жилийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна.

(м) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк санхүүгийн байдлын тайланийн өдөр бүр шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүнгээр нь бууруулан бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн ургалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр дискаунтчилан өнөөгийн үнэ цэнийг олно.

Санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нээн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл нөхөн төлөгдэх дүнг ойролцоолон тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг цуглуулан авах дүн хүртэл нь өсгөж бүртгэнэ. Энэ өссөн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөд үнэ цэнийн алдагдалыг хүлээн зөвшөөрөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүн (элэгдлийг хассан цэвэр дүн)-гээс хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Ийм буцаалтыг хийсний дараа, хөрөнгийн шинэ бүртгэлийн дүн (үлдэгдэл өртгийг хассан дүн)-г түүний ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилах үүднээс элэгдлийн зардалд зарруулга хийнэ.

(н) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('repo')-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Хүлээн авсан холбогдох бэлэн мөнгөө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд 'Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлдэг байна. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүгийн зардал гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан өртэйн хугацааны турш хуримтлуулна. Харин хөрөнгө хүлээн авагч нь тус хөрөнгийг борлуулах эсвэл барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг 'Барьцаанд тавьсан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө' гэж тайлан тэнцэлд бүртгэнэ.

Харин буцаан худалдах хэлцэл ('урвуу repo')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд 'Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдана. Худалдан

авсан ба буцаан худалдах үнийн зэрүүг хүүгийн орлого гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

(o) Санхүүгийн баталгаа

Банк бизнесийн хэвийн нөхцөлд голдуу тендерийн баталгаанаас бүрдэх санхүүгийн баталгаануудыг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайланда анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дунгэр "Бусад өр төлбөр"-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа, баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулалт ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дун хоёрын аль ихээр нь хэмжинэ.

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланда "Үнэ цэнийн бууралтын алдагдал" гэж тайлагнана. Хүлээн авсан урамшууллыг санхүүгийн баталгааны хүчинтэй байх хугацааны туршид нь шулуун шугамын аргаар тооцож дэлгэрэнгүй орлогын тайланда "Үйл ажиллагааны бусад орлого" гэж хүлээн зөвшөөрнө.

(ө) Ажиллагсдын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардлал тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог, бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог байна.

(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацааны нь орлого, үр дүнгийн тайландаа зардлаар хүлээн зөвшөөрнө. Банк мөн тусгай тэтгэврийн хуримтлалын санд шимтгэл төлдөг. Энэхүү санд төлсөн шимтгэлийг "Тэтгэврийн сангийн зардал" гэж бүртгэдэг ба тухайн ажилтны Банкинд ажилласан хугацаатай нь хувь тэнцүүлэн шимтгэлийг энэ санд хуримтлуулдаг.

(р) Үйл ажиллагааны түрээс

Түрээслэгч тал бүх эрсдлийг хүлээж, ашгийг хүртэх үйл ажиллагааны түрээсд төлж байгаа түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож дэлгэрэнгүй орлогын тайландаа зардлаар бүртгэнэ.

(c) Энгийн хувьцааны ногдол ашиг

Энгийн хувьцааны ногдол ашигийг өр төлбөрт хүлээн зөвшөөрдөг бөгөөд Банкны хувь нийлүүлэгчдийн шийдвэрээр зөвшөөрөгдсөний дараа өөрийн хөрөнгөөс хасна. Банкны удирдлага ногдол ашигийг хугацааны дундуурх тайлант хугацааны үеэр зарласан ба эдгээр нь Банкны эрх мэдэлээс гарсан тохиолдолд өдгөөрийг өөрийн хөрөнгөөс хасч тусгана.

Тухайн жилийн ногдол ашигийг санхүүгийн байдлын тайлангийн өдрөөс хойш олгохоор шийдвэрлэсэн бол "Тайлангийн өдрийн дараа болсон үйл явдал" тодруулгад тусгана.

2.3 НЯГЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Банк нь дараах шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн СТОУС-ууд ба Санхүүгийн тайлагналын олон улсын тайлбарын хороо ("СТОУТХ")-ноос гаргасан тайлбаруудыг тайлант хугацаанд дагаж мөрдсөн.

- * СТОУС 1: СТОУС-ийг анхлан нэвтрүүлэх - Анхлан хэрэгжүүлэгчдэд үзүүлэх нэмэлт чөлөөлөлтүүд (Нэмэлт өөрчлөлт).
- * СТОУС 2: Хувьцаанд суурилсан төлбөр - Группийн мөнгөөр барагдуулах, хувьцаанд суурилсан төлбөрийн зохицуулалтууд.

Сайжруулсан СТОУС-ууд:

- * НББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга
- * НББОУС 7 - Мөнгөн гүйлгээний тайлан
- * НББОУС 17 - Түрээс
- * НББОУС 36 - Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- * НББОУС 39 - Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- * СТОУС 8 - Үйл ажиллагааны сегментүүд

Дээр дурьдсан шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн стандарт, тайлбарууд нь дор дурьдсанаас бусад талаар НББ-ийн бодлого, санхүүгийн үр дүн болон банкны байдалд нөлөө үзүүлээгүй болно.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эдгээр санхүүгийн тайлангуудыг батлах өдрийн байдлаар дараах стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарууд нь батлагдах шатандaa байсан ба хэрэгжиж эхлээгүй байсан болно. Үүнд:

- * НББОУС 24 - (Шинэчилсэн) - Холбоотой талуудын тодруулга
- * НББОУС 32 - (Нэмэлт өөрчлөлт) - Санхүүгийн хэрэглүүрүүд: Толилуулга - Хувьцаа гаргах эрх
- * СТОУС 1 - (Нэмэлт өөрчлөлт) - СТОУС-ийг анхлан нэвтрүүлэх - СТОУС 7-ын дагуу харьцуулсан үзүүлэлтүүд дээр хийх тодруулгуудаас СТОУС 7-г анхлан нэвтрүүлэгчдийг тодорхой хэмжээнд чөлөөлөх
- * СТОУС 9 - Санхүүгийн хэрэглүүрүүд
- * СТОУТХ 14 - (Нэмэлт өөрчлөлт) Зайлшгүй хийх санхүүжилтийн хамгийн бага дүнгийн урьдчилгаа төлбөрүүд
- * СТОУТХ 19 - Санхүүгийн өр төлбөрийг өөрийн хөрөнгийн хэрэглүүрээр барагдуулах Сайжруулсан СТОУС-үүд:
- * НББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга
- * НББОУС 27 - Санхүүгийн нэгтгэсэн ба бие даасан тайлангууд
- * НББОУС 34 - Завсрыйн үеийн санхүүгийн тайлагнал
- * СТОУС 1 - СТОУС-ыг анхлан нэвтрүүлэх
- * СТОУС 3 - Бизнесийн нэгдэл
- * СТОУС 7 - Санхүүгийн хэрэглүүрийн тодруулга
- * СТОУТХ 13 - Харилцагчдад чиглэсэн хөтөлбөр

Банкны захирлууд нь эдгээр стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбаруудыг ирээдүйд дагаж мөрдөхөд банкны санхүүгийн тайланд материалыг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн хүлэлттэй байна.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД

Банк нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг мөрдөх явцад санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдийг тодорхойлоход өөрийн үнэлэлт болон тооцооллуудыг ашигласан. Ашигласан томоохон үнэлэлт болон тооцооллуудыг дор харуулав. Үүнд:

(i) Санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэлгээ

Санхүүгийн байдлын тайланд үзүүлсэн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнийг идэвхтэй зах зээлийн үнээр тодорхойлох боломжгүй үед математик загварчлалуудыг багтаасан үнэлгээний төрөл бүрийн аргыг ашигладаг. Бодит үнэ цэнийг тогтоохын тулд эдгээр загваруудад оруулах өгөгдлийг боломжтой бол ажиглаж болохуйц зах зээлээс авдаг. Хэрэв боломжгүй бол тодорхой хэмжээний үнэлэмжийг удирдлагаас шаарддаг. Энэхүү үнэлэмж нь хүлээн авах орлого, деривативүүдийн хоорондын хамаарал (корреляц) болон хэлбэлзэл зэрэг загварт хэрэглэгдэх өгөгдлүүдийг авч үздэг

(ii) Зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралт

Банк нь үнэ цэнийн бууралтын санг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс тайлагналын өдөр бүр асуудалтай зээл, урьдчилгаануудыг хянаж үздэг. Тухайлбал, шаардлагатай сангийн түвшинг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ийм тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн талаарх таамаглалууд дээр үндэслэдэг ба бодит үр дүнгээс өөр байж болох бөгөөд энэ нь ирээдүйд сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

Дангаараа том дүнтэй зээл ба урьдчилгаанд байгуулсан тусгай сангаас гадна, Банк тусгай сан байгуулах шаардлагатай гэж онцгойлон авч үзээгүй боловч анх олгож байх үеийнхээс зөрчилд өртөх магадлал нь өссөн зээлүүдэд бүлгийн үнэ цэнийн бууралтын санг байгуулдаг. Ингэхдээ тухайн салбарын эрсдэл өссөн эсэх, технологийн хоцрогдолд орсон эсэх, мөн түүнчлэн мөнгөн урсгалд бүтцийн доройтол эсвэл саатал байгаа эсэх зэрэг олон тооны хүчин зүйлүүдийг харгалzan үздэг.

(iii) Бүртгэлтэй өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт

Бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд доогуур байгаа эсвэл өөр бусад бодит нотолгоо байгаа үед Банк нь борлуулахад бэлэн өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг үнэ цэнийн бууралтанд орсон гэж үзнэ. "Их хэмжээ" ба "Үрт хугацаа" гэдгийг тодорхойлоход үнэлэмж шаардагдана. Банк нь 20 болон түүнээс дээш хувийг "Их хэмжээ", худалдан авалтын өдрөөс хойш б 6 сараас дээш хугацааг "Үрт хугацаа" гэж үзнэ. Үүнээс гадна, Банк хувьцааны үнийн өөрчлөлт гэх мэт бусад хүчин зүйлүүдийг үнэлж үздэг.

3. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ОРЛОГО

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	90,557,465	73,915,148
Бусад банк дахь харилцах, хадгаламж	2,587,310	1,467,808
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	8,482	234
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Дуусгавар хугацаа хүртэл эзэмших	17,971,144	6,351,916
Урвуу репо хэлцэл	32,102	96,557
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэггүй санхүүгийн хөрөнгийн хүүний нийт орлого	111,156,503	81,831,663

4. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ЗАРДАЛ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Харилцагчдын харилцах, хадгаламж	74,742,974	48,193,352
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	1,255,566	902,039
Зээлээр авсан эх үүсвэр болон хөёрдогч өглөг	5,054,921	8,468,216
Репо хэлцэл	265,853	256,644
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэггүй санхүүгийн өр төлбөрийн хүүний нийт зардал	81,319,314	57,820,251
Бусад	129,165	84,681
	81,448,479	57,904,932

5. ШИМТГЭЛ ХУРААМЖИЙН ЦЭВЭР ОРЛОГО

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Шимтгэл хураамжийн орлого		
Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж	2,586,205	2,122,298
Карттай холбоотой шимтгэл, хураамж	2,943,140	2,378,026
Зээлтэй холбоотой шимтгэл, хураамж	3,365,603	2,018,257
Гүйвуулгын ба бусад үйлчилгээний шимтгэл	3,760,500	2,914,558
	12,655,448	9,433,139
Шимтгэл хураамжийн зардал		
Банкаар үйлчлүүлсний зардал	(1,158,763)	(969,694)
Гадаад валютын шимтгэл	(11,594)	-
Картын гүйлгээний зардал	(1,564,692)	(1,195,647)
Онлайн гүйлгээний зардал	(7,781)	-
	(2,742,830)	(2,165,341)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэггүй санхүүгийн хөрөнгийн хүү, шимтгэлийн цэвэр орлого	9,912,618	7,267,798

6. АРИЛЖААНЫ ЦЭВЭР ОРЛОГО

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Өөрийн хөрөнгө	78,084	-
Валютын форвард хэлцлийн бодит бус олз	4,486	-
Үнэт металл	1,273	12,577
Валютын форвард хэлцлийн бодит олз	-	176,315
	83,843	188,892

"Өөрийн хөрөнгө" гэсэн орлогод өөрийн хөрөнгийн үнэт цаасны худалдан авалт, борлуулалтын үр дүн ба бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд багтана.

7. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт (Тодруулга 23)	45,769	(57,244)
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	7,861	7,996
Валютын ханшийн бодит олз	7,943,483	6,115,985
Валютын ханшийн бодит бус гарз	(1,273,765)	(1,526,228)
Үйл ажиллагааны бусад орлого	29,274	1,278,606
	6,752,622	5,819,115

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Зар сурталчилгаа	982,118	702,439
Биет бус хөрөнгийн хорогдуулалт (Тодруулга 18)	976,622	826,428
Харилцаа холбоо	568,789	543,052
Засал чимэглэл	645,203	208,646
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 17)	1,873,137	1,770,395
Хандив	88,850	18,677
Зочин төлөөлөгчийн зардал	635,580	253,658
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарз	-	51,029
Хураан авсан барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз (Тодруулга 19)	666,837	305,173
Даатгал	298,669	90,163
Зээлийн авлага барагдуулах зардал	190,332	173,006
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын борлуулалтын гарз	8,156	-
Үйл ажиллагааны бусад зардал	466,719	266,995
Торгууль	69,668	2,809
Мэргэжлийн үйлчилгээний зардал	610,663	730,740
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 17)	12,505	5,598
Байрны түрээс	2,852,061	2,549,325
Засвар үйлчилгээний зардал	707,817	615,181
Харуул хамгаалалтын зардал	578,854	487,595

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Цалин, холбогдох зардлууд*	7,116,468	5,735,277
Бичиг хэргийн зардал	595,569	517,085
Тээврийн зардал	376,989	286,316
Томилолтын зардал	601,046	315,719
Ашиглалтын зардал	209,499	199,480
Суутган тооцох татвар	109,691	48
	21,241,842	16,654,834

* Цалин, холбогдох зардлууд

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Цалин, шагнал, урамшуулал	6,159,386	4,992,501
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	643,445	543,415
Тэтгэврийн сан	50,150	-
Ажилчдын сургалт	190,555	144,941
Ажилчдын тэтгэмж	72,932	54,420
	7,116,468	5,735,277

9. ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНЭ БУУРАЛТЫН ЗАРДАЛ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Харилцагчад олгосон зээл ба урьдчилгаа		
Бизнесийн зээл	794,015	178,862
Бизнесийн жижиг зээл	(1,264,022)	547,598
Хэрэглээний зээл	(384,152)	1,372,973
Орон сууцны зээл	(130,143)	543,464
Бусад зээл	-	(8,349)
	(984,302)	2,634,548
Бусад авлага (Тодруулга 19)	1,708	605,447
	(982,594)	3,239,995

10. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Орлогын татвар		
Тайлант жилийн үр дунд ногдох:	6,145,111	4,138,119

Банк нь санхүүгийн байдлын тайлант орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Банк 3 тэрбум (2009 онд 3 тэрбум) төгрөг хүртэл ашгаас 10% (2009 онд 10%)-ийн, 3 тэрбумаас (2009 онд 3 тэрбум) дээш төгрөгийн ашгаас 25% (2009 онд 25%)-ийн орлогын албан татвар төлдөг. Засгийн газрын бондын хүүгийн орлогод татвар тооцохгүй. Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлаас хамгаалах сан нь татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцогдоно.

10. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд хэрхэн тохируулсныг дараах хуудсанд үзүүлэв.

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Татварын өмнөх ашиг	26,197,859	17,307,707
25%-ийн орлогын албан татвар (2009 онд 25%)	6,549,465	4,326,927
Бага хувийн татвар ногдох орлогын нөлөө	(450,000)	(450,000)
Татвараас чөлөөлөгддөг орлого	(289,431)	(55,536)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	335,077	316,728
Тайлант жилийн татварын зардал	6,145,111	4,138,119

Түр зөрүү гараагүй тул өмнөх болон тайлант санхүүгийн жилүүдэд хойшлогдсон татварыг тусгаагүй болно.

11. БЭЛЭН МӨНГӨ, ТӨВ БАНК ДАХЬ ХАРИЛЦАХ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Бэлэн мөнгө	60,555,802	44,786,624
Монголбанк дахь харилцах	77,498,911	113,085,327
	138,054,713	157,871,951

Монголбанкаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцах данс байршуулдаг. Монголбанкинд заавал байршуулах бэлэн мөнгөний үлдэгдлийн хэмжээ нь 14 хоногийн хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийн 5% (2009 онд 5%)-аас бага байж болохгүй. 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны байлагах нөөцийн хэмжээ тегрэгийн хувьд 30,651 сая төгрөг (2009 онд 18,298 сая төгрөг), гадаад валютын хувьд 23,845 сая төгрөг (2009 онд 20,275 сая төгрөг) байсан. Зайлшгүй байлагх нөөцийн хэмжээг тооцох, хянах тухай журамд 2009 оны 3 дугаар сарын 27-ны өдөр орсон өөрчлөлтийн дагуу Банк нь зайлшгүй байлагх нөөцийн 50%-ийг өөрийн өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглаж болохгүй болсон.

12. БУСАД БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	240,349,466	216,511,438
Зээл ба урьдчилгаа	9,549,172	-
	249,898,638	216,511,438

Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжид дотоод болон гадаад валютаар илэрхийлэгдсэн харилцах данс, гадаад, дотоодын санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж орно.

Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 42.50 сая төгрөгийн (2009 онд 52.95 сая төгрөг) хөрөнгийг Тодруулга 22-т тусгасанчлан авсан зээлийн барьцаанд тавьсан болно.

13. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Доорх мэдээллийг үүсмэл санхүүгийн хэрэслүүдийн бодит үнийг нэрлэсэн дүнгийн хамт толилуулсан байна. Нэрлэсэн дүн нь (энэ нь нийт дүнгээр бүртгэгдсэн) үүсмэл санхүүгийн хэрэгслийн салшгүй хамаарлтай хөрөнгийн дүн байдаг бөгөөд үүсмэл санхүүгийн хэрэгслийнх нь бодит үнийг энэхүү хөрөнгөд үндэслэн хэмждэг. Нэрлэсэн дүн нь ажил гүйлгээний жилийн эцсийн үлдэгдлийг харуулдаг ба зах зээлийн болон зээлийн эрсдэлийн алийг нь ч илэрхийлэгүй болно.

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Актив		
- Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэглүүр-валютын форвард хэлцэл	4,486	-
Өр төлбөр		
- Өөрийн хөрөнгө ба валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүр (Тодруулга 23)	1,506,132	381,425
Нэрлэсэн дүн		
Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэгслүүд		
- Гадаад валютын форвард хэлцэл	4,032,000	-

14. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Борлуулахад бэлэн:		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хувьцаа (өртөг)	3,712,922	837,370
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаа (бодит үнэ)	3,744,408	189,326
	7,457,330	1,026,696
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших:		
Монголбанкны үнэт цаас (бодит үнэ)	353,616,082	110,496,687
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй, Засгийн газрын бонд (бодит үнэ)	2,042,400	7,273,519
Вексель	-	748,372
	355,658,482	118,518,578
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй:		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаа (бодит үнэ)	345,472	-

Монголбанкны эдгээр үнэт цаас нь гурван сар болон түүнээс доош хугацаатай богино хугацааны, хүү тооцдог, хямдруулсан үнээр гаргадаг үнэт цаас юм. Монголбанкны 4.6 тэрбум төгрөг (2009 онд тэг төгрөг)-ийн дүнтэй үнэт цаасыг Тодруулга 22-т тодруулсан өрийн барьцаа болгон Монголбанкинд өгсөн. Сангийн яамны гаргасан, Засгийн газрын хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өрийн бичиг нь гурван сараас доош хугацаатай, хямдруулсан үнээр гаргасан үнэт цаас юм.

"Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй эдгээр хувьцаа нь хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй аж ахуйн нэгжүүдэд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Бодит үнэ цэнийг нь тооцох боломжгүй тул эдгээр хөрөнгө оруулалтуудыг өртөөр нь бүртгэсэн болно. Үнэлгээний аргуудыг ашиглан гаргах, бодит үнэ цэнийн дүнгүүдийн хоорондхи зөрүү их хэмжээтэй байна гэсэн хүлээлтэй байна. Эдгээр хөрөнгө оруулалтанд зах зээл байхгүй ба Банкинд эдгээр үнэт цаасыг ойрын ирээдүйд худалдан борлуулах төлөвлөгөө байхгүй.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаа нь Монголын болон Хонг Конгийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хэд хэдэн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

Вексел нь Эрдэнэт үйлдвэр ХХК-аас гурван сараас бага хугацаатайгаар, хямдруулсан үнээр гаргасан үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

15. УРВУУ РЕПО ХЭЛЦЭЛ

Энэ санхүүгийн хөрөнгийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт гэж ангилсан. Энэхүү урвуу репо хэлцлийн нэг хэсэг болгон, Банк нь худалдаж болох нэхцэлтэй, Монголбанкны үнэт цаасыг хүлээн авсан. Энэ үнэт цаас нь 3 хоногийн хугацаатай, 2011 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр дуусах хугацаатай. Уг үнэт цаасны бодит үнэ цэнэ нь 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бүртгэлийн дүнтэйгээ ойролцоо байсан.

16. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Бизнесийн зээл	520,767,630	296,758,632
Бизнесийн жижиг зээл	115,686,204	132,286,714
Хэрэглээний зээл	66,215,273	11,466,561
Орон сууцны зээл	80,108,644	37,592,629
Бусад	-	36,184,351
	782,777,751	514,288,887
Хууримтлагдсан хүүний авлага	12,044,815	9,051,510
Нийт зээл ба урьдчилгаа	794,822,566	523,340,397
Үнэ цэнэ бууралтын сан	(10,217,619)	(18,041,403)
Зээл ба урьдчилгааны цэвэр дүн	784,604,947	505,298,994

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сангийн тохируулгыг зээлийн ангилал тус бүрээр нь салган үзүүлбэл:

2010 оны 12 сарын 31	Бизнесийн зээл мян.төг	Бизнесийн жижиг зээл мян.төг	Хэрэглээний зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Бусад зээл мян.төг	Нийт зээл мян.төг
2010 оны 1-р сарын 1-нээр	9,950,883	5,535,479	1,993,320	561,648	73	18,041,403
Нэмэгдсэн	2,665,991	287,442	281,862	177,810	-	3,413,105
Төлөгдсөн	(1,871,976)	(1,551,464)	(666,014)	(307,953)	-	(4,397,407)
Дахин ангилсан	-	-	-	73	(73)	-
Данснаас хассан	(3,373,570)	(1,690,960)	(844,263)	(3,482)	-	(5,912,275)
Ханшны зөрүү	(674,487)	(227,420)	(8,696)	(16,604)	-	(927,207)
2010 оны 12-р сарын 31-нээр	6,696,841	2,353,077	756,209	411,492	-	10,217,619
Тусгай үнэ цэнийн бууралт	802,115	737,038	28,441	86,851	-	1,654,445
Бүлгийн үнэ цэнийн бууралт	5,894,726	1,616,039	727,768	324,641	-	8,563,174
	6,696,841	2,353,077	756,209	411,492	-	10,217,619
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай, тусгай үнэ цэнийн бууралтын санг хасахаас						
өмнөх зээлийн нийт дүн	9,758,334	4,094,121	148,263	581,756	-	14,582,474

16. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (Үргэлжлэл)

2009 оны 12 сарын 31	Бизнесийн зээл мян.төг	Бизнесийн жижиг зээл мян.төг	Хэрэглээний зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Бусад зээл мян.төг	Нийт зээл мян.төг
2009 оны 1-р сарын 1-нээр	9,649,322	4,982,875	589,255	17,277	8,421	15,247,150
Нэмэгдсэн	2,472,246	1,083,916	1,453,795	673,600	-	5,683,557
Төлөгдсөн	(2,293,384)	(536,318)	(80,822)	(130,136)	(8,349)	(3,049,009)
Данснаас хассан	-	(2,000)	(2,364)	-	-	(4,364)
Ханшны зөрүү	122,699	7,006	33,456	907	1	164,069
2009 оны 12-р сарын 31-нээр	9,950,883	5,535,479	1,993,320	561,648	73	18,041,403
Тусгай үнэ цэнийн бууралт	718,832	4,122,425	480,791	434,347	-	5,756,395
Бүлгийн үнэ цэнийн бууралт	9,232,051	1,413,054	1,512,529	127,301	73	12,285,008
	9,950,883	5,535,479	1,993,320	561,648	73	18,041,403
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай, тусгай үнэ цэнийн бууралтын санг хасахаас өмнөх зээлийн нийт дүн	3,373,570	8,401,568	777,692	792,064	-	13,344,894

Банкнаас харилцагчдад олгосон ба тусгай үнэлгээнд хамрагдсан гэж үзэж буй зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 2010 оны 12 сарын 31-ний байдлаар 37.12 тэрбум төгрөг (2009 онд 47.04 тэрбум төгрөг) байна. Эдгэр үнэлгээг Банкны удирдлага хамгийн суулийн үеийн боломжит мэдээлэл дээр үндэслэн гаргасан болно. Дэлгэрэнгүй танилцуулгыг Тодруулга 31-ийн "Барьцаа хөрөнгө ба зээлийн бусад сайжруулалтууд" хэсгээс үзнэ үү.

Хураан авсан барьцаа хөрөнгө

Тайлант жилд Банк нь 2010.12.31-ний өдрийн байдлаар ойролцоогоор 728,992,000 (2009 онд 108,464,000) төгрөгийн бүртгэлийн дүнтэй барилгуудын өмчлөх эрхийг өөртөө шилжүүлэн авсан ба борлуулахаар ажиллаж байна.

17. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

2010 оны 12 сарын 31	Барилга байшин мян.төг	Түрээсийн байрны засвар мян.төг	Тавилга, эд хогшил тээврийн хэрэгсэл мян.төг	Дуусаагүй барилга мян.төг	Нийт мян.төг
Өртгөөр					
2010 оны 1-р сарын 1-нээр	1,554,232	30,538	10,145,579	-	11,730,349
Нэмэгдсэн	5,657,049	-	3,051,134	12,369,310	21,077,493
Худалдан борлуулсан	-	-	(113,250)	-	(113,250)
Шилжүүлсэн	-	-	(4,986)	-	(4,986)
Данснаас хассан (Тодруулга 8)	-	(30,538)	(1,139,194)	-	(1,169,732)
2010 оны 12-р сарын 31-нээр	7,211,281	-	11,939,283	12,369,310	31,519,874
Хуримтлагдсан элэгдэл					
2010 оны 1-р сарын 1-нээр	433,918	30,538	5,918,084	-	6,382,540
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 8)	110,810	-	1,762,327	-	1,873,137
Борлуулсан	-	-	(87,559)	-	(87,559)
Данснаас хассан (Тодруулга 8)	-	(30,538)	(1,126,689)	-	(1,157,227)
2010 оны 12-р сарын 31	544,728	-	6,466,163	-	7,010,891
Дансны үнэ (цэвэр)	6,666,553	-	5,473,120	12,369,310	24,508,983

17. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Барилга байшин мян.төг	Түрээсийн байрны засвар мян.төг	Тавилга, эд хогшил тээврийн хэрэгсэл мян.төг	Дуусаагүй барилга мян.төг	Нийт мян.төг
2009 оны 12 сарын 31					
Өртгөөр					
2009 оны 1-р сарын 1-нээр	1,748,034	30,538	8,174,964		9,953,536
Нэмэгдсэн	-	-	2,164,529		2,164,529
Худалдан борлуулсан	(193,802)	-	(60,311)		(254,113)
Шилжүүлсэн	-	-	485		485
Данснаас хассан (Тодруулга 8)	-	-	(134,088)		(134,088)
2009 оны 12-р сарын 31-нээр	1,554,232	30,538	10,145,579	-	11,730,349
Хуримтлагдсан элэгдэл					
2009 оны 1-р сарын 1-нээр	378,808	28,162	4,413,747		4,820,717
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 8)	81,960	2,376	1,686,059		1,770,395
Худалдан борлуулсан	(26,850)	-	(53,227)		(80,077)
Шилжүүлсэн	-	-	(5)		(5)
Данснаас хассан (Тодруулга 8)	-	-	(128,490)		(128,490)
2009 оны 12-р сарын 31-нээр	433,918	30,538	5,918,084	-	6,382,540
Дансны үнэ (цэвэр)	1,120,314	-	4,227,495	-	5,347,809

18. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Програм хангамж, лиценз

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Өртгөөр		
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	3,490,343	2,837,436
Нэмэгдсэн	686,155	652,907
12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар	4,176,498	3,490,343
Хуримтлагдсан хорогдуулга		
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	2,095,012	1,268,584
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 8)	976,622	826,428
12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар	3,071,634	2,095,012
Дансны цэвэр дүн	1,104,864	1,395,331

19. БУСАД АКТИВ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Бусад авлага		
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	2,006,533 (628,913) 1,377,620	1,694,396 (628,801) 1,065,595
Хураан авсан хөрөнгө		
Хасах нь: Үнэ цэнэ бууралтын сан	728,992 (669,510) 59,482	108,464 (2,673) 105,791
Урьдчилж төлсөн зардал		
Хангамжийн ба бусад бараа материал	4,790,543 2,073,209 6,863,752	5,251,678 715,014 5,966,692
	8,300,854	7,138,078
Бусад авлагын үнэ цэнийн бууралтын сан		
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	628,801	65,685
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	1,708	605,447
Данснаас хассан	(3,006)	(53,171)
Ханшны зөрүү	1,410	10,840
12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар	628,913	628,801
Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан		
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	2,673	300,000
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 8)	666,837	305,173
Данснаас хассан	-	(602,500)
12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар	669,510	2,673

20. БУСАД БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	80,833,669	52,931,634

Банк санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжид дотоодын болон гадаадын банкнуудаас байршуулсан гадаад валют болон төгрөгийн харилцах болон хугацаатай хадгаламжууд орно.

21. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Төсвийн байгууллагын харилцах, хадгаламж		
- Харилцах данс	24,915,848	30,008,303
- Хугацаагүй хадгаламж	10,136,613	15,065,316
- Хугацаатай хадгаламж	4,756,924	28,994,561
Хувийн секторын харилцах, хадгаламж		
- Харилцах данс	393,842,596	128,736,786
- Хугацаагүй хадгаламж	14,962,745	22,948,742
- Хугацаатай хадгаламж	44,159,811	44,210,031
Иргэдийн харилцах, хадгаламж		
- Харилцах данс	46,073,147	26,629,333
- Хугацаагүй хадгаламж	268,326,454	194,523,794
- Хугацаатай хадгаламж	488,900,858	280,213,639
Бусад харилцах, хадгаламж		
- Харилцах данс	12,617,987	10,279,949
- Хугацаагүй хадгаламж	1,772,252	9,353,145
- Хугацаатай хадгаламж	7,034,087	4,287,409
	1,317,499,322	795,251,008

Харилцагчдын харилцах, хадгаламжийн нийт дүнд буцаах эрхгүй, санхүүгийн баталгаануудын барьцаа болгон авсан 6.10 тэрбум төгрөг (2009 онд 4.78 тэрбум төгрөг)-ийн хадгаламж орсон болно.

22. ЗЭЭЛЭЭР АВСАН ЭХ ҮҮСВЭР

	Үр ашигт хүүний хувь 2010 (%)	2010 Мян. төг	2009 Мян. төг
Шууд авсан зээл:			
2011 онд дуусах, хөвөгч хүүтэй 316,000 евро**	6.87	461,299	589,986
2010 онд дуусах, тогтмол хүүтэй 27.5 тэрбум төг*	12.00	-	40,515,886
2014 онд дуусах, тогтмол хүүтэй 4.6 тэрбум төг**	4,666,500	-	-
	5,127,799	41,105,872	

22. ЗЭЭЛЭЭР АВСАН ЭХ ҮҮСВЭР (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Үр ашигт хүүний хувь 2010 (%)	2010 Мян. төг	2009 Мян. төг
Дамжуулан авсан зээл:			
2010 онд дуусах, хөвөгч хүүтэй 3.3 сая ам.дол*	4.09	-	23,085
2014 онд дуусах, тогтмол хүүтэй 910 сая төг*	7.40	903,000	910,000
2014 онд дуусах, хөвөгч хүүтэй, 0.6 сая ам.дол*	1.60-2.10	753,882	865,704
2019 онд дуусах, тогтмол хүүтэй, 42.6 мян ам.дол*	2.00	53,572	-
2019 онд дуусах, тогтмол хүүтэй, 0.2 сая ам.дол*	2.00	229,771	308,208
2013 онд дуусах, хөвөгч хүүтэй, 1.9 тэрбум төг*	1.75-2.11	2,056,888	2,712,454
2019 онд дуусах, хөвөгч хүүтэй, 2.8 тэрбум төг*	4.80-5.90	5,802,623	5,577,955
2011 онд дуусах, тогтмол хүүтэй 1.2 тэрбум төг*	10.00	239,400	519,600
2019 онд дуусах, тогтмол хүүтэй, 3.9 тэрбум төг*	7.00	3,798,568	3,574,340
Азийн Хөгжлийн банкны, хөвөгч хүүтэй*	7.69-8.80	3,519,160	4,034,097
2011 онд дуусах, тогтмол хүүтэй 0.84 сая ам.дол*	5.85	536,029	1,227,655
2014 онд дуусах, тогтмол хүүтэй 4.4 тэрбум төг*	1.20	4,365,900	1,736,000
2014 онд дуусах, тогтмол хүүтэй 1 тэрбум төг*	3.60	1,000,000	-
		23,258,793	21,489,098
Нийт		28,386,592	62,594,970

* Барьцаагүй

** Барьцаатай

316 мянган евро-гийн зээл нь хөвөгч хүүтэй, 2011 он хүртэл хугацаатай, Тодруулга 12-т заасан "Банк болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө"-ийн барьцаалсан зээл юм.

4.6 тэрбум төгрөгийн зээл нь тогтмол хүүтэй, 2014 он хүртэл хугацаатай, Тодруулга 14-т тайлбарласан Монголбанкны үнэт цаасаар баталгаажсан.

Азийн Хөгжлийн Банк

Зээлийг орон сууцны зээл хүснэгчдэд олгосон. Жилийн 7.69% - 8.80% (2009 онд 7.64% - 8.04%)-ийн хүүтэй. Эргэн төлөлтийн нөхцөл ба дуусгавар хугацаа харилцан адилгүй эргэн төлөх төлбөрийн хуваариас хамааран өөр өөр байна.

Тайлант жилд Банк нь өөрийн зээлээр авсан эх үүсвэрүүдийн хувьд хүүний болон үндсэн төлбөрийн график зөрчсөн болон өөр ямар нэгэн зөрчил гаргаагүй болно.

23. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Кредит Свисс-ээс авсан хоёрдогч өглөг	12,593,842	14,219,900
Стэнхөп Инвестментс-ээс авсан хоёрдогч өглөг	30,370,439	-
	42,964,281	14,219,900

Кредит Свисс-ээс авсан хоёрдогч өглөг

2007 онд Голомт Банк Кредит Свисс-ийн Сингапур улс дахь салбараас 5 жилийн хугацаатай, 10 сая ам. долларын хоёрдогч өглөгийг авсан бөгөөд анхны гэрээнд 2008 оны 12-р сарын 19-ны өдөр дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсан болно. Үүнд:

23. ХОЁРДОГЧ ӨГЛӨГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

- (а) Хөрвүүлэх хувилбар - Кредит Свисс нь зээлийн гэрээний хугацаанд хүссэн үедээ зээлийг нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй, шинэ энгийн хувьцаанд нэг ам долларыг 1,170.79 төгрөгтэй тэнцэх тогтмол ханшаар тооцон хөрвүүлэх эрхтэй ба "Худалдах, худалдан авах үнэ" нь 4,848.49 төгрөг ба шаардлага хангасан зах зээл дээр гаргах хувьцааны анхны үнэ хоёрын аль багаас, хөрвүүлэг хийх өдрийн байдлаарх аливаа нэг ногдол ашгийг хассан дүн байна.
- (б) Энэ зээлийн хү нь 3 сарын ЛИБОР дээр 2.5 хувийг нэмсэнтэй тэнцэх хү байх ба улирал бүр төлөгднө.

Стэнхөп Инвестментс-ээс авсан хоёрдогч өглөг

2010.06.08-ны өдөр Банк нь Стэнхөп Инвестментс-ийн Абу Даби хот дахь төвтэй нь 5 жилийн хугацаатай, 25 сая ам.долларын хөрвөх зээлийн гэрээг дараахаа нөхцөлтэйгээр байгуулсан. Үүнд:

- (а) Хөрвүүлэх хувилбар - Стэнхөп Инвестментс нь зээлийн гэрээний хугацаанд хүссэн үедээ зээлийг Банкны 1,000 төгрөгийн нээрлэсэн үнэтэй, шинэ энгийн хувьцаанд (нэг ам долларыг 1,170.79 төгрөгөөр тооцон) хөрвүүлэх эрхтэй ба "Худалдах, худалдан авах үнэ" нь 6,838.44 төгрөг ба шаардлага хангасан зах зээл дээр гаргах хувьцааны анхны үнэ хоёрын аль багаас, хөрвүүлэг хийх өдрийн байдлаарх аливаа нэг ногдол ашгийг хассан дүн байна. Стэнхөп Инвестментс нь хувьцаа анхдагч зах зээл дээр хэр амжилттай зарагднаас үл хамааран, хөрвүүлэг хийхгүйгээр мөнгөө буцаан авах хувилбарыг сонгосон тохиолдолд, Банк нь эргэн төлөлтийн өдөр (зээлийг татан авсны дараах 5 жил дууссанас хойш 7 хоногийн дотор) зээлийн бүтэн дүнгээр нь эргүүлэн төлөх ба Банкны цорын ганц хувьцаа эзэмшигч болох Бодь Интернэйшнль ХХК нь татан авсан зээлийн үндсэн дүнгээс, төлсөн хуундийн дүнг хасаж тооцсон дунд, татан авалтын өдрөөс тооцон, жилийн 15%-тэй тэнцэх "Анхдагч зах зээлийн үр дүнгийн урамшуулал"-ыг Стэнхөп Инвестментс-д төлнө.
- (б) Энэ зээл нь ЛИБОР дээр 4.5 хувийг нэмсэнтэй тэнцэх хүйтэй байх ба улирал бүр төлөгднө.

Хүлээн авсан хоёрдогч өглөгийн нийт дүнг (гүйлгээний зардлыг хассан цэвэр дүн) өр төлбөр, агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсгээр нь салгасан. Агуулагдсан өөрийн хөрөнгө болон валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг Банкны таамаглал болон зах зээлийн үнэ дээр сууринласан стандарт опционы үнэлгээний загварыг ашиглаж үнэлсэн. Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийг үнэлж үзний дараа, үлдэх үнийг үндсэн өр төлбөрт нь харгалзуулсан болно.

	Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн (Тодруулга 13) мян.төг	Нийт мян.төг
Өр төлбөрийн бүрэлдэхүүн мян.төг		
2009 оны 12-р сарын 31-ний өдрөөрх	14,219,900	381,425
2010 оны 12-р сарын 31-ний өдрөөрх	42,964,281	1,506,132
		44,470,413

2009 ба 2010 онуудын 12 дугаар сарын 31-ний өдрөөрх өөрийн хөрөнгө болон валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнийг стандарт опционы үнэлгээний загвараар тодорхойлсон ба зөрүүг олз эсвэл гарзаар хүлээн зөвшөөрсөн. Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг голдуу валютын обшионы үнээр тодорхойлдог. Учир нь Монгол Улсад хувьцааны үнэ, хувьцааны үнийн хэлбэлзэл, обшионуудын өгөөжийн зөрүү гэх мэттэй холбоотой, ажиглаж болохуйц зах зээлийн мэдээллүүд байдаггүй. Үнэлгээний арга техникт хэрэглэж буй орцуудын нилээд нь зөвхөн тухайн банкинд хамаарах орцууд байдаг ба тэдгээр нь тухайн хэрэгслийн эрсдэл ба өгөөжийн уламжлалт хүчин зүйлүүдийн талаарх хүлээлт, үнэлгээг тусган харуулж чадахгүй байж болно. Иймээс үнэлгээний арга техникийг ашиглан гаргаж ирсэн бодит үнэ цэнийн дүнгүүд нь хоорондоо ихээхэн зөрүүтэй байх ба тиймээс Банкны удирдлага бодит үнэ цэнийг найдвартайгаар хэмжих боломжгүй гэж дүгнэсэн.

24. БУСАД ӨР ТӨЛБӨР

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Өглөг	5,065,653	7,452,283
Дотоод ба гадаад гүйвуулгын саатал	749,436	1,320,317
Клирингийн саатал	10,819,970	3,918,567
Хойшлогдсон орлого	1,522,424	2,462,309
	18,157,483	15,153,476

Хойшлогдсон орлого нь Хүнс, хөдөө аж ахуйн яамны, Голомт банкаар дамжин шаардлага хангасан тодорхой зээлдэгчдэд олгогдсон Хөдөө аж ахуйг дэмжих сангийн зээлийн хүүгийн урьдчилж орсон орлого болно.

25. РЕПО ХЭЛЦЭЛ

Репо хэлцлийн хүрээнд Банк нь ирээдүйд эргүүлэн худалдан авах нөхцөлтэйгээр Монголбанкны үнэт цаасыг худалдсан. Эдгээр үнэт цаас нь 4 хоногийн хугацаатай. Эдгээр үнэт цаасын бодит үнэ цэнэ нь 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бүртгэлийн дүнтэйгээр ойролцоо байна.

26. ДҮРМИЙН САН

	Хувьцааны тоо		Дүн	
	2010	2009	2010 Мян. төг	2009 Мян. төг
1дүгээр сарын 1-нээр буюу 12 дугаар сарын 31-нээр	21,934,142	21,934,142	21,934,142	21,934,142

27. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ

	Note	2010 Мян. төг	2009 Мян. төг
Бэлэн мөнгө, Монголбанк дахь хөрөнгө	11	138,054,713	157,871,951
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	12	249,898,638	216,511,438
		387,953,351	374,383,389
Хасах нь: Банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулагдахгүй, Монголбанкинд байршуулсан зайлшгүй байлгах нөөц (Тодруулга 11)		(27,247,800)	(19,286,800)
Нийт мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө		360,705,551	355,096,589

28. САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн түвшинг тодорхойлох

Банк нь үнэлгээний техникийдийг ашиглан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

Түвшин 1: хөрөнгө, өр төлбөрийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ

Түвшин 2: бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх бүх өгөгдлүүдийг нь шууд болон шууд бусаар ажиглах боломжтой бусад техникийд

Түвшин 3: бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх, ажиглаж болохуйц зах зээлийн өгөгдөл дээр сууринласан өгөгдлүүдийг ашигладаг техникийд

Дараах хүснэгтэд бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэ цэнийн түвшнээр нь ангилан үзүүлэв. Үүнд:

28. САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2010.12.31-ний өдрөөр	Тувшин 1 мян.төг	Тувшин 2 мян.төг	Тувшин 3 мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр				
- Валютын форвард хэлцэл	-	4,486	-	4,486
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй				
- Бирж дээр бүртгэлтэй хувьцаа	345,472	-	-	345,472
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт				
- Бирж дээр бүртгэлтэй хувьцаа	3,744,408	-	-	3,744,408
Нийт	4,089,880	4,486	-	4,094,366
Санхүүгийн өр төлбөр				
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр				
- Хувьцаа, валютын үүсмэл хэрэглүүр	-	-	1,506,132	1,506,132

2009.12.31-ний өдрөөр	Тувшин 1 мян.төг	Тувшин 2 мян.төг	Тувшин 3 мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт.				
Биржид бүртгэлтэй хувьцаа	189,326	-	-	189,326
Нийт	189,326	-	-	189,326
Санхүүгийн өр төлбөр				
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр				
Хувьцаа, валютын дериватив	-	-	381,425	381,425

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хэрэглүүр

Бодит үнэ цэнээр нь бүртгэсэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг үнэлгээний техникиудийг ашиглан хэрхэн тодорхойлдог талаар дараах хэсэгт танилцуулсан болно. Зах зээлд оролцогч талууд тухайн хэрэглүүрийг үнэлэхдээ хийж болох таамаглалуудын талаарх Банкны тооцооллыг энд багтаасан болно.

Хувьцаа, валютын дериватив

Хувьцаа, валютын үүсмэл бүтээгдэхүүнүүдийг зах зээл дээр ажиглах боломжгүй өгөгдлүүдтэй үнэлгээний техникиудийг ашиглан үнэлдэг. Эдгээр үүсмэл хэрэглүүрүүдийг обционы үнэлгээний загвар (өнөөгийн эрсдэлгүй хүү, валютын ханшийн хөдөлгөөн, ойролцоолон тооцоолсон спот ханш, дуусгавар хугацаа зэргийг харгалzan үздэг загвар)-ыг ашиглан үнэлдэг.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх, 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн хөдөлгөөн

Дараах хүснэгтэд бодит үнэ цэнээрээ бүртгэгдэх, 3 дугаар түвшний санхүүгийн өр төлбөрийн эхний болон эцсийн үлдэгдлийн тулган баталгаажуулалтыг харуулав. Үүнд:

2010.01.01- -нээр мян.төг	Орлогын тайланда бүртгэгдсэн нийт олз/(гарз) мян.төг	Худалдан авалт мян.төг	2010.12.31- -нээр мян.төг
Санхүүгийн өр төлбөр			
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр			
Хувьцаа ба валютын дериватив	(381,425)	45,769	(1,170,476) (1,506,132)
Нийт 3 дугаар түвшний санхүүгийн өр төлбөр	(381,425)	45,769	(1,170,476) (1,506,132)

28. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ.)

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх, 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн хөдөлгөөн (үргэлжлэл)

	2009.01.01- -нээр мян.төг	Орлогын тайланда бүртгэгдсэн нийт олз/(гарз) мян.төг	Худалдан авалт мян.төг	2009.12.31- -нээр мян.төг
--	---------------------------------	--	------------------------------	---------------------------------

Санхүүгийн өр төлбөр

Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	(324,181)	(57,244)	-	(381,425)
Нийт 3 дугаар түвшний санхүүгийн өр төлбөр	(324,181)	(57,244)	-	(381,425)

Тайлант жилийн орлогын тайланда бүртгэгдсэн, 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн олз/(гарз).

	2010 Бодит бус олз мян.төг	2009 Бодит бус (гарз) мян.төг
Тайлант жилийн орлогын тайланда бүртгэсэн нийт олз/(гарз)	45,769	(57,244)

1 ба 2 дугаар түвшний хоорондхи шилжих хөдөлгөөн

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн 1 ба 2 дугаар түвшний хооронд ямар нэгэн шилжих хөдөлгөөн гарцаагүй.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх, 3 дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд, гол төсөөллүүдийн өөрчлөлтийн үзүүлэх нөлөөлөл.

Доорх хүснэгтэд 3 дугаар түвшний хэрэглүүрийн бодит үнэ цэнэд үзүүлэх нөлөөллийг зохистой, боломжит сонголтод төсөөллүүдийг ашиглан, хэрэглүүрийн ангилал тус бүрээр үзүүллээ.

	2010.12.31	2009.12.31
	Зохистой, боломжит сонголтод	Зохистой, боломжит сонголтод
Бүртгэлийн дүн мян.төг	төсөөллүүдийн нөлөө мян.төг	Бүртгэлийн дүн мян.төг
Санхүүгийн өр төлбөр		төсөөллүүдийн нөлөө мян.төг
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		
Хувьцаа, валютын дериватив	(2,059,699)	(553,567)
		(332,469)
		48,956

Зохистой, боломжит сонголтод төсөөллүүдийг тодорхойлохын тулд Банк нь валютын обционы (Монгол Улсын эрсдэлгүй хүүний түвшин) гол, ажиглах боломжгүй, загваруудын орцуудыг залруулсан. Үнэлгээний загварт ашигласан эрсдэлгүй хүүний түвшинг 2.5% хүртэлх хэмжээгээр өсгөж эсвэл бууруулж залруулсан.

28. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ (ҮРГЭЛЖЛЭЛ.)

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдээгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнэ

Дараахь аргачлал, таамаглалыг ашиглан санхүүгийн тайландаа бодит үнэ цэнээрээ бүртгэгдээгүй санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлсон. Үүнд:

Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо хөрөнгө

Хөрвөх чадвартай болон богино хугацааны (1 жилээс доош) санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд тэдгээрийн бодит үнэ нь дансны үнэтэй ойролцоо байдаг гэж таамагладаг. Энэ таамаглалыг мөн хугацаагүй хадгаламж, хугацаатай хадгаламж болон хувьсах хүүтэй санхүүгийн хэрэглүүр, хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй, борлуулахад бэлэн үнэт цаас болон Засгийн газрын үнэт цаасанд ашиглана. Банкны удирдлагын хийсэн бодит үнэ цэнийн үнэлгээнээс харахад харилцагчдаас татан төвлөрүүлсэн, 1 жилээс дээш хугацаатай хөрөнгийн (Тодруулга 30) бодит үнэ цэнэ нь тэдгээрийн бүртгэлийн дүнтэй ойролцоо байна. Энэ нь ижил төстэй хадгаламжийн бүтээгдэхүүнд санал болгож буй өнөөгийн зах зээлийн хүүний түвшин нь анхны өдрийн зах зээлийн хүүний түвшинээс их зөрүүтэй биш байгаатай холбоотой.

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгсэл

Хорогдуулсан өртгөөр илрхийлэгдсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг Монгол Улсад байгаа ижил төстэй санхүүгийн хэрэгслүүдийн өнөөгийн зах зээлийн хүүг тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн үеийн зах зээлийн хүүтэй харьцуулах замаар тооцоолно. Хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг өрийн хувьд бодит үнэ цэнэ нь зах зээлийн үнэ дээр үндэслэн тооцогдоно. Хөрөнгийн бирж дээр зах зээлийн үнэ нь байхгүй өрийн бодит үнийн тодорхойлоходоо одоо зах зээл дээр байгаа хүүнүүдийн хугацааны бүтцийн муруйд үндэслэн харгалзах эргэн төлөгдөх хугацаагаар нь дискаунтчилсан мөнгөн урстгалын загварчлалыг ашигласан.

Санхүүгийн тайландаа тусгагдсан санхүүгийн хэрэгслүүдийн дансны үнэ болон бодит үнүүдийг анги тус бүрээр нь доор харуулав. Энэхүү хүснэгт нь санхүүгийн бус хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнийг багтаагаагүй болно.

	Тодруулга	Дансны үнэ 2010 мян.төг	Бодит үнэ 2010 мян.төг	Дансны үнэ 2009 мян.төг	Бодит үнэ 2009 мян.төг
Санхүүгийн хөрөнгө					
Бэлэн мөнгө, төв банк дахь харилцах	11	138,054,713	138,054,713	157,871,951	157,871,951
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	12	249,898,638	249,898,638	216,511,438	216,511,438
Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт					
Монголбанкны үнэт цаас	14	353,616,082	353,616,082	110,496,687	110,496,687
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй, засгийн газрын бонд	14	2,042,400	2,042,400	7,273,519	7,273,519
Вексель	14	-	-	748,372	748,372
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	784,604,947	788,723,379	505,298,994	506,437,576
Бусад авлагы	19	1,377,620	1,377,620	1,065,595	1,065,595
		1,529,594,400	1,533,712,832	999,266,556	1,000,405,138
Санхүүгийн өр төлбөр					
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	20	80,833,669	80,833,669	52,931,634	52,931,634
Харилцагчдын харилцах, хадгаламж	21	1,317,499,322	1,317,499,322	795,251,008	795,251,008
Зээлээр авсан санхүүжилт	22	28,386,592	28,386,592	62,594,970	62,594,970
Хоёрдогч өглөг	23	42,964,281	42,964,281	14,219,900	14,219,900
Бусад өглөг, урьдчилж орсон орлого	24	16,635,059	16,635,059	12,691,167	12,691,167
Репо хэлцэл	25	-	-	7,732,840	7,732,840
		1,486,318,923	1,486,318,923	945,421,519	945,421,519

29. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ

Харилцагчийн санхүүгийн хэрэгцээг хангахын тулд банк олон төрлийн цуцлашгүй үүргийг хүлээнээс болзошгүй өр төлбөр үүсдэг байна. Хэдийгээр эдгээр үүргүүд нь тайлан тэнцэлд хүлээн зөвшөөрөгдөөгүй ч зээлийн эрсдлийг агуулсан байдаг учраас Банкны нийт эрсдлийн нэг хэсэг байдаг.

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Болзошгүй өр төлбөр		
Санхүүгийн баталгаа	8,977,329	10,751,333
Аккредитив	26,818,480	23,941,432
Гүйцэтгэлийн баталгаа	47,908,177	28,885,510
	83,703,986	63,578,275
Үүрэг		
Олгогдоогүй зээл	27,142,064	11,748,372
Нийт	110,846,050	75,326,647

Болзошгүй өр төлбөр

Аккредитив, баталгаа (нээлттэй аккредитив хамарагдана) нь тусгай үйл явдал тохиолдоход харилцагчийн өмнөөс голдуу бараа бүтээгдэхүүний импорт болон экспорттой холбоотойгоор төлбөр хийх үүргийг Банкинд ногдуулдаг байна. Баталгаа, нээлттэй аккредитив нь зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг. Эдгээр гүйлгээний улмаас материаллаг алдагдал гарахгүй гэсэн хүлээлттэй байна.

Зээл олгох үүрэг хүлээсэн ч тус эрх нь хэрэгжээгүй

Зээлийн хэмжээг нэмэхээр шийдвэрлэсэн нь Банкны зүгээс зээл олгох, зээлийн шугам нээх гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байтал тус үүргийнх нь хугацаа нь дууссан байж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйн мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн ойлголт биш юм.

Зээлийн хэмжээг нэмэх боломжит алдагдал нь нийт хэрэгжээгүй үлдсэн зээл олгох үүргүүдийн дүнгээс бага байна. Богино хугацаат зээлийн үүргээс голдуу урт хугацаат зээлийн үүрэг нь илүүтэйгээр зээлийн эрсдэлтэй байдаг тул банк нь зээлийн үүргүүдийнхээ дуусах хугацааг хянаж байдаг.

Бусад болзошгүй үүргүүд

	2010 MNT '000	2009 MNT '000
Батлагдсан, гэрээ байгуулсан:		
Үндсэн хөрөнгө	733,897	37,027
Биет бус хөрөнгө	33,253	121,156
	767,150	158,183

Үйл ажиллагааны түрээсийн үүрэг- Түрээслэгч нь Банк

Банк нь цуцлах боломжтой, үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу түрээслэгч болж төрөл бүрийн барилгыг үйл ажиллагаа явуулах зорилгоор түрээслэдэг. Банк эдгээр гэрээнүүдийн хугацааг дуусгавар болгох тохиолдолд мэдэгдлээ нэг сарын өмнө өгөх үүрэгтэй. Түрээсийн гэрээнд аливаа шинэчлэх, худалдан авах, сайжруулах боломжуудыг тусгаагүй ба Банкинд эдгээр түрээсийн гэрээнд тал болсноор аливаа хязгаарлалтууд тавигдаагүй болно.

29. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ (ҮРГЭЛЖЛЭЛ.)

Шүүхийн нэхэмжлэл

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт шүүхээр асуудлыг шийдэх явдал энгийн үзэгдэл байдаг. Банк нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журамтай. Нэгэнт мэргэжлийн зөвлөгөө авсан, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолсон бол Банк нь тухайн нэхэмжлэлийн банкны санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс хамгаалан дансандaa залруулах бичилт хийнэ. Тайлант жилийн эцэст Банкинд шийдэгдээгүй шүүхийн нэхэмжлэл байхгүй байсан.

30. ХӨРӨНГӨ БОЛОН ӨР ТӨЛБӨРИЙН ХУГАЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

Дараахь хүснэгтэнд Банкны актив, пассивын Эргэн төлөгдхө, барагдах хугацаагаар нь харуулсан шинжилгээг харуулсан байна. Тодруулга 31.3 "Төлбөрийн чадварын эрсдэл ба эх үүсвэрийн удирдлага"-аас Банкны зүгээс барагдуулах үүргүйдийн дискаунтчилгаагүй хувилбарыг харна уу

	12 сар хүртэлх мян. төг	12 сараас дээш мян. төг	Нийт мян. төг
2010 оны 12 сарын 31			
Санхүүгийн хөрөнгүүд			
Бэлэн мөнгө, Монголбанк дахь хөрөнгө	138,054,713	-	138,054,713
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	249,856,142	42,496	249,898,638
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	4,486	-	4,486
Санхүүгийн хөрөнгө оруулалт -			
- борлуулахад бэлэн	7,457,330	-	7,457,330
- дуусгавар хугацаа хүртэл эзэмших	355,658,482	-	355,658,482
- арилжаалах зорилгоор эзэмшиж буй	345,472	-	345,472
Урвуу репо хэлцэл	3,997,668	-	3,997,668
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	324,872,400	459,732,547	784,604,947
Бусад авлагыа	1,377,620	-	1,377,620
	1,081,624,313	459,775,043	1,541,399,356
Санхүүгийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	-	24,508,983	24,508,983
Биет бус хөрөнгө	-	1,104,864	1,104,864
Бусад актив	-	6,923,234	6,923,234
		32,537,081	32,537,081
Нийт	1,081,624,313	492,312,124	1,573,936,437
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	80,833,669	-	80,833,669
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,314,660,351	2,838,971	1,317,499,322
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	1,506,132	-	1,506,132
Зээлээр авсан санхүүжилт	3,930,557	24,456,035	28,386,592
Хоёрдогч өглөг	98,330	42,865,951	42,964,281
Бусад пассив	16,635,059	-	16,635,059
	1,417,664,098	70,160,957	1,487,825,055
Санхүүгийн бус өр төлбөр			
Хойшлогдсон орлого	1,522,424	-	1,522,424
Татварын өр	791,405	-	791,405
	2,313,829	-	2,313,829
Нийт	1,419,977,927	70,160,957	1,490,138,884
Цэвэр	(338,353,614)	422,151,167	83,797,553

	12 сар хүртэлх мян. төг	12 сараас дээш мян. төг	Нийт мян. төг
2009 оны 12 сарын 31			
Санхүүгийн хөрөнгүүд			
Бэлэн мөнгө, Монголбанк дахь хөрөнгө	157,871,951	-	157,871,951
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	216,458,485	52,953	216,511,438
Санхүүгийн хөрөнгө оруулалт -			
-борлуулахад бэлэн	1,026,696	-	1,026,696
-дуусгавар хугацаа хүртэл эээмших	118,518,578	-	118,518,578
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	333,931,549	171,367,445	505,298,994
Бусад авлага	1,065,595	-	1,065,595
	828,872,854	171,420,398	1,000,293,252
Санхүүгийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	-	5,347,809	5,347,809
Биет бус хөрөнгө	-	1,395,331	1,395,331
Бусад актив	-	6,072,483	6,072,483
	-	12,815,623	12,815,623
Нийт	828,872,854	184,236,021	1,013,108,875
Санхүүгийн өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	52,931,634	-	52,931,634
Харилцагчдын харилцах, хадгаламж	795,251,008	-	795,251,008
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	381,425	-	381,425
Зээлээр авсан санхүүжилт	45,389,478	17,205,492	62,594,970
Хоёрдогч өглөг	188,372	14,031,528	14,219,900
Бусад пассив	12,691,167	-	12,691,167
Репо хэлцэл	7,732,840	-	7,732,840
	914,565,924	31,237,020	945,802,944
Санхүүгийн бус өр төлбөр			
Хойшлогдсон орлого	2,462,309	-	2,462,309
Татварын өр	826,790	-	826,790
	3,289,099	-	3,289,099
Нийт	917,855,023	31,237,020	949,092,043
Цэвэр	(88,982,169)	152,999,001	64,016,832

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

31.1 Оршил

Голомт банкны Эрсдэлийн Удирдлагын Газар нь Гүйцэтгэх Захиралд шууд тайлагнадаг бие даасан нэгж бөгөөд банкны үйл ажиллагааны үндсэн уламжлалт эрсдэл болох зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, хүүний ханшийн эрсдэл, гадаад валютын арилжааны эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлийг хянан зохицуулдаг. Эрсдэлийн удирдлагын гол зорилго нь бизнесийн сегментүүдээд тэдгээрийн уламжлалт эрсдэл/шагналын дүрслэлд зохицсон капиталыг хуваарилах ба эрсдэлийн лимит болон бусад хяналтанд байдаг эрсдэлээр тохируулагдсан капиталын өгөөжийг байнгын илрүүлэлт, хэмжилт ба хянан зохицуулалтын процессоор хамгийн их байлгахад оршдог. Тус эрсдэлийн удирдлагын процесс нь Банкны урт хугацааны ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой бөгөөд ажилтан, хувь хүн бүр өөрийн ажил үүрэгтэй холбоотой эрсдэлийн өртөлтийг мөн хариуцдаг.

Эрсдэлийн хяналтын бие даасан процесс нь байгаль орчин, технологи, салбарын өөрчлөлт зэрэг бизнесийн эрсдэлийг хамардаггүй. Эдгээр нь Банкны стратеги төлөвлөлтөөр хянан зохицуулагддаг.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

31.1 Оршил (Үргэлжлэл)

Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

ТУЗ нь эрсдэлийг тодорхойлж, хяналтыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй. Гэсэн хэдий ч, эрсдэлийг удирдаж хянах зохицуулах чиг үүргээ бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)

ТУЗ нь эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, банкны бүх үйл ажиллагааг зорилгод чиглүүлсэн эрсдэлийн стратеги, зарчмуудыг батлах мөн шаардлагатай гэж узсэн шинэ бодлого журмыг нэвтрүүлдэг. Эрсдэлийн стратеги болон ач холбогдол бүхий бодлогуудыг ТУЗ-аас батлаж, тодорхой давтамжтайгаар (хамгийн багадаа жилд 1 удаа) хянан хэлэлцдэг.

Аудитын хороо

Аудитын хороо нь Дотоод аудитын газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, хянах чиг үүрэгтэй ба ТУЗ-д шууд тайлagnана.

Актив, пассивын хороо

Тус хороо нь эрсдэлийн стратеги боловсруулж, хүүний ханшны хөрвөх чадварын болон зах зээлийн эрсдэлүүдэд хязгаарлалтууд, зарчмыг, бүтэц, бодлогыг тодорхойлж хэрэгжүүлнэ. Үүнд :

- (i) зээлийн бодлого, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, батлах.
- (ii) зээлийн ангилал болон сан байгуулах түвшин хэмжээг батлах.
- (iii) зээлийн багц дах чанар, эрсдэлтэй багцыг тогтмол хянах.
- (iv) үйлдвэрлэлийн салбар болон газарзүйн бүсийн байршлын хувьд олгогдох зээлийн хэмжээг тогтоон батлах.

Эрсдэлийн Удирдлагын Газар

Эрсдэлийн удирдлагын газар нь бие даасан хяналтын системийг хэрэгжүүлэх зорилгоор эрсдэлд хамаарал бүхий бодлого журмуудыг мөрдэж, хэрэгжүүлнэ.

Тус газар нь Банкны эрсдэлийн бодлого, журмуудын хэрэгжилтийг хангана. Бизнесийн бүхий л нэгжүүд эрсдэлийг хянан зохицуулах бие даасан албатай байх болсон бөгөөд тогтоосон лимитийн эрсдэл, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл болон зохион байгууллалт бүхий гүйлгээний эрсдэл ээргийг багтааж хянана. Тус алба нь мөн эрсдэлийн тооцоололт, тайлагналын систем дэх бүхий л эрсдэлийг тодорхойлж, тайлagnах чиг үүрэгтэй байна.

Дотоод Аудитын Газар

Банк дахь эрсдэлийн удирдлагыг Дотоод аудитын газар банкны зохижтой үйл ажиллагаа болон мөрдлөг болгож буй дүрэм, журмын хэрэгжилтийг шалгах замаар хамгийн багадаа жилд нэг удаа аудит хийнэ. Дотоод аудитын газар нь шалгалтын дүнгийн талаар удирдлагатай ярилцаж, илэрсэн зүйлийг санал зөвлөмжийн хамт удирдлагын хороо болон аудитын хороонд тайлagnана.

Эрсдэлийн хэмжих болон тайлagnах систем

Банк тооцоолж болохуйц болон ердийн тохиолдолд тооцож болохооргүй эрсдэл буюу статистик загварт сууриссан эцсийн эрсдэлийг аль алийг нь хэмжих аргыг ашигладаг. Загвар нь өмнөх туршлага, түүхэнд сууриссан боломжийг эдийн засгийн орчинд тохируулна. Мөн Банк тохиолдох магадалал тун багатай боловч тохиолдож болох хамгийн муу төлөвүүдийг гаргадаг.

Эрсдэлийг Банкнаас тогтоосон хэмжээ хязгаарын хүрээнд хянаж, удирдана. Тус тодорхойлсон хэмжээ хязгаар нь Банкны бизнес стратеги, зах зээлийн орчинтой болон банкны зүгээс хүлээн зөвшөөрөхүйц эрсдэлийн хэмжээтэй

уялдсан байх ба зарим салбарт онцгойлон анхаардаг. Банк нь бүх үйл ажиллагаанд бий эрсдэлүүдийн нийлбэр өртөлттэй холбоотойгоор эрсдэл даах чадварыг хэмжих хянана.

Бүх бизнесийн нэгжүүдээсээ цуглувулсан мэдээлийг эрсдэлийг эртхэн тодорхойлж, хянах зорилгоор нягтлан шалгах боловсруулалт хийдэг. Мөн энэ мэдээлэлийг ТУЗ, Актив пассивын хороо, газар бүрийн захирлуудад танилцуулдаг. Тайланд зээлийн нийт өртөлт, зээлийн хэмжээний төлөв, тогтоосон лимитийг давах онцгой тохиолдол, VaR, хөрөөн чадварын харьцаа, ба эрсдэлийн багцын өөрчлөлт зэргийг тусгана. Сар бүр үйлдвэрэлийн салбар, харилцагчийн эрсдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлагнана. Улирал бүр газар нэгжийн захирлууд зээлийн эрсдэлийн сангийн зохистой байдалд үнэлгээ өгнө. Хяналтын зөвлөл Банкны нийт эрсдэлийн өртөлтийг тооцож, үнэлж, хянах болохуйц бүрэн хэмжээний тайлантай улирал бүр танилцаж үнэлгээ хийдэг.

Тусгайлан боловсруулагдсан эрсдэлийн тайланг Банкны бүх нэгжүүдэд хүргэдэг бөгөөд энэ нь бизнесийн нэгжүүдийг шинэ тутам мэдээллэтий байлгах зорилготой юм.

Удирдлага болон Актив пассивын хороонд VaR, хөвөрөх чадварын дүн шинжилгээ, зах зээлийн лимитын ашиглалт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулна.

Эрсдэлийг бууруулах

Хүүний ханш, гадаад валютын ханшны өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болох өртөлтийг мэдрэмжийн шинжилгээ болон VaR-ийг эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд ашигладаг. Банк зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө барьцаалж авдаг.

Эрсдэлийн хэт төвлөрөл

Хэд хэдэн харилцагчид ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг эсвэл улс төр эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал төвлөрөл бий болдог. Төвлөрөл нь тухайн нэг салбарт нөлөөлж буй нөхцөл байдалд банк хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ.

Эрсдэлийн хэт төвлөрөлөөс зайлсхийхийн тулд Банк нь өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Зээлийн эрсдэлийн тодорхойлогдсон төвлөрөлийг хянах удирдана. Монголбанк /Төв банк/ дараах стандарт хязгаарлалтуудыг биелүүлэхийг шаарддаг. Үүнд :

- (i) Нэг зээлдэгч болон түүнд холбогдох хувь хүнд олгох зээлийн нийт зээлтэй дүн болон зээлтэй адилтгах бусад активын хамгийн дээд хэмжээг банкны өөрийн хөрөнгийн 20%-аас хэтрүүлж болохгүй.
- (ii) Банктай ямар нэгэн байдлаар холбогдсон этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад активын дүн нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дун нь өөрийн хөрөнгийн 20%-аас хэтэрч болохгүй.

31.2 Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь банкны харилцагч, болон хамтрагч тал гэрээний үүргээ биелүүлэгүйгээс үүдэж банк хүлээж болзошгүй эрсдэлийг хэнлн. Банк нь тухайн нэг зээлдэгч болон газарзүй, эдийн засгийн салбарын төвлөрлийн хувьд өөрийн дааж болохуйц эрсдэлийн дунд тохирсон хязгаар тогтоо, тийм хязгаартай холбоотой эрсдэлийн нийт хэмжээнд мониторинг хийх замаар зээлийн эрсдэлийг хянах удирддаг.

Голомт банк нь барьцаа хөрөнгийн үнэлгээ хяналтыг хийх зэргийг багтаасан зээлдэгч талын зээл даах чадавхид гарч буй өөрчлөлтийг нэн даруй тодорхойлж байхын тулд зээлийн чанарыг хянах процессыг бий болгосон. Зээлийн эрсдэлийн зэрэглэл зээлдэгч бүрээр тогтоо зээлийн эрсдэлийн ангилалын системийг ашиглан тухайн нэг зээлдэгчийн зээл авах дээд хэмжээг тогтоодог. Эрсдэлийн зэрэглэлийг байнга хянан шинэчилж байдаг. Зээлийн зэрэглэлийг эргэн хянах процесс нь үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлсоны үр дунд хүлээж болзошгүй алдагдалыг тогтоо, мөн түүнээс сэргийлэх зохистой арга хэмжээг авах боломжийг Банкинд олгодог юм.

Банкны зээлийн үйл ажиллагааг удирдах, хяналт зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор чанарын стандартчилагдсан формат ба тайлагналыг хэвшүүлэх, хөгжүүлж, сайжруулах нь энххүү хяналтын нэгжийн үүрэг юм.

Зээлийн Эрсдэлийн Удирдлагын Хэлтэс нь банкин дахь зээлийн соёлын хөгжлийн нэг хэсэг гэдэг утгаараа банк доторх мэдлэг, туршлага, мэргэжлийн нөөцийг бий болгох болон Хүний нөөцийн хэлтэстэй хамтран Зээлийн Сургалтын хетөлбөрүүдийн төлөвлөгөөг боловсруулах үргийг хүлээнэ. Энэ нь банкны шаардлага болон тодорхойлсон чадвар, мэдлэгийн дутагдал, хүрэлцээгүй байдлыг нөхөх зорилготой тасралтгүй бөгөөд жил бүр эргэн хянаандаг үйл явц юм.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл:

Банк нь харилцагчийн өмнөөс төлбөр төлөх магадлал бүхий баталгаануудыг гаргах боломжийг бий болгодог. Ийм төлбөрийг аккредитивийн нөхцөлд тулгуурлан харилцагчдаас эргүүлэн татдаг. Эдгээр нь банкинд зээлтэй нэгэн адил эрсдэлийг учруулах ба түүнийг мөн зээлийн үйл ажиллагааны бодлого журмаар зохицуулдаг.

Эдгээр хэрэгслийдийн гол зорилго нь харилцагчийг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино. Баталгаа ба нээлттэй аккредитивууд нь харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах цуцлашгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм.

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээг авч үзвэл:

Доорх хүснэгт нь тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээний өртөлтийг харуусан байна. Дээд өртөлтийг барьцаа хөрөнгө ашиглаж эрсдэл бууруулах нөлөөний өмнөх нийт дүнгээр илэрхийлсэн болно.

	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2010 мян. төгр	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2009 мян. төгр
Тодруулга		
Төв банкинд байршуулсан бэлэн мөнгө (гар дээрх бэлэн мөнгийг оруулаагүй)	11	77,498,911
Бусад банкинаас авах авлагы	12	249,898,638
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	13	4,486
Борлуулхад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт	14	7,457,330
Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт	14	355,658,482
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө оруулалт	14	345,472
Урвуу репо хэлцэл	15	3,997,668
Зээл ба урьдчилгаа	16	784,604,947
Бусад авлагы	19	1,377,620
Нийт	1,480,843,554	955,506,628
Хүлээж болзошгүй үүрэг	29	83,703,986
Болзошгүй төлбөр	29	27,142,064
Нийт	110,846,050	75,326,647
Нийт зээлийн эрсдэлийн өртөлт	1,591,689,604	1,030,833,275

Бодит үнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэгслийн хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдэлийн өртөлтийг харуулсан боловч энэ нь ирээдүйд үнэ цнэ өөрчлөгдхөөс шалтгаалж бий болж болох эрсдэлийн дээд хэмжээ биш юм.

Санхүүгийн хэрэгслийн анги тус бүр дэх зээлийн эрсдэлийн өртөлтийн дээд хэмжээний талаарх илүү нарийвчилсан мэдээг тусгайлан холбогдох тодруулгуудад хаанаас харж болохыг заасан байх болно. Барьцаа хөрөнгө болон бусад эрсдэлийг бууруулах арга техникиудийн нөлөөллийг дор харуулав.

Зээлийн эрсдэлд дээд хэмжээгээр өртөх эрсдэлийн төвлөрөл

Эрсдэлийн төвлөрөлийг харилцагч тал/үйлчлүүлэгч ба эдийн засгийн салбар тус бүрээр ангилан зохицуулна. 2010 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар аливаа харилцагч тал/үйлчлүүлэгчээс учирч болох зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээ нь 35,932 сая төгрөг (2009 онд 30,198 сая төгрөг) байв.

Бусад банк болон санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж болон бусад хөрөнгө болох 189,727 сая төгрөг (2008 онд 195,162 сая төгрөг)-өөс бусад банкны бүх хөрөнгө болон өр төлбөр нь газарзүйн хувьд Монгол Улсад төвлөрч байна.

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн сайжруулалтыг тооцохоос өмнөх Банкны санхүүгийн хөрөнгийн эдийн засгийн салбарын шинжилгээ:

	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2010 мян. төг	Нийт өртөлтийн дээд хэмжээ 2009 мян. төг
Хөдөө аж ахуй	18,957,486	6,199,095
Барилга	65,441,303	49,583,201
Өргөн хэрэглээ	150,250,984	69,982,834
Боловсрол	4,522,363	6,087,277
Эрчим хүч, газрын тос	29,156,678	24,820,421
Санхүүгийн үйлчилгээ	725,808,819	464,983,698
Эрүүл мэнд	6,664,384	4,415,462
Өрхийн бизнес	467,443	66,737
Зочид буудал, зоогийн газар	16,861,982	8,734,404
Олон улсын байгууллага	-	14,701
Засвар үйлчилгээ	5,764,651	3,264,542
Боловсруулах үйлдвэрлэл	74,088,332	54,219,674
Уул уурхай, хайгуул	133,588,123	91,819,017
Олон нийтийн үйлчилгээ	-	4,186,392
Үл хөдлөх хөрөнгө	35,971,657	21,300,503
Нийгмийн үйлчилгээ	15,806,291	2,039,588
Аялал жуулчлал	18,169,791	967,044
Тээвэр ба харилцаа холбоо	39,704,891	20,465,886
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	119,042,709	110,844,786
Бусад	20,575,667	11,511,366
	1,480,843,554	955,506,628

Барьцаа ба зээлийн бусад сайжруулалтууд

Барьцаа хөрөнгийн шаардагдаж буй хэмжээ ба төрлийг зээлдэгч талын зээлийн эрсдэлийн шинжилгээнд үндэслэн тогтооно. Зөвшөөрч болохуийц барьцаа хөрөнгийн төрлүүд болон үнэлгээний параметрүүдийг тодорхой удирдамж, журмаар зохицуулдаг.

Гол барьцаа хөрөнгийн төрлүүд:

- (i) "Аж ахуйн нэгжийн зээл: Үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, автомашин."
- (ii) Жижиг бизнесийн зээл: Үл хөдлөх хөрөнгө.
- (iii) Хэрэглээний зээл: Автомашин, орлого
- (iv) Орон сууцны зээл: Амьдрах зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Мөн Банк нь охин компанид зээл олгоходоо толгой компаниар батлан даалт хийлгэж болдог. Гэхдээ эдгээр боломжит эрсдэлээс хамгаалсан хэмжээг дээрх хүснэгтэд тусгаагүй болно.

Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд удирдлагууд хяналт тавьдаг. Үндсэн гол гэрээ хэлэлцээрт зохицуулагдсанаар тухайн зээлд нэмж барьцаа хөрөнгө барьцаалахад удирдлагууд мөн хяналт тавьдагаас гадна эдгээр барьцаа хөрөнгийн зах зээлийн үнийг зээлийн үнэ цэнийн бууралтын санг зохистой эсэхийг шалгах явцдаа давхар хянадаг.

Барьцаа хөрөнгөнд тооцогдсон хураагдсан эд хөрөнгийг цэгцтэй арга замаар борлуулах нь Банкны нэг бодлого юм. Олсон орлогыг төлөгдөөгүй үлдсэн зээлийн хэмжээг багасгах, барагдуулахад ашигладаг. Банк хураагдсан эд хөрөнгийг өөрийн бизнесийн хэрэглээнд ашигладаггүй.

Санхүүгийн хөрөнгийн ангилал тус бүрийн зээлийн чанар

Банк нь өөрийн санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарыг дотооддоо ашигладаг зээл зэрэглэлийн системээр удирдагддаг. Доорхи хүснэгт нь зээлийн чанарыг хөрөнгийн төрөл тус бүрээр банкны зээлийн дотоод зэрэглэлийн системд суурилсан зэрэглэлийг харуулна.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгийн ангиалал тус бүрийн зээлийн чанар (Үргэлжлэл)

2010.12.31-ний өдрийн байдлаар	Тодруулга	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй зээл			Хугацаа Стандартаас доогуур зэрэглэл мян. төг.	Хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай мян. төг.	Нийт мян. төг.
		Өндөр зэрэглэл мян. төг.	Стандарт зэрэглэл мян. төг.	Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай мян. төг.			
Бусад банк санхүүгийн байгууллага дахь дахь харилцах, хадгаламж	12	129,380,712	47,728,663	72,789,263	-	249,898,638	
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	13	4,486	-	-	-	4,486	
Санхүүгийн хөрөнгө оруулалт							
- борлуулахад бэлэн	14	-	4,053,873	-	3,403,457	7,457,330	
- дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших	14	355,658,482	-	-	-	355,658,482	
- арилжаалах зорилгоор эзэмшиж буй	14	-	345,472	-	-	345,472	
Урвууrepo хэлцэл	15	3,997,668	-	-	-	3,997,668	
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа							
- Бизнесийн зээл	16	399,715,064	73,303,926	40,648,733	15,697,475	529,365,198	
- Жижиг бизнесийн зээл	16	83,523,150	6,446,493	12,886,970	13,958,752	116,815,365	
- Хэрэглээний зээл	16	55,439,572	734,213	8,452,644	3,209,128	67,835,557	
- Орон сууцны зээл	16	53,965,087	13,367,225	8,032,477	5,441,657	80,806,446	
		592,642,873	93,851,857	70,020,824	38,307,012	794,822,566	
Нийт		1,077,682,067	145,634,393	142,810,087	41,710,469	1,407,837,016	

**Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн
бууралтгүй зээл**

2010.12.31-ний өдрийн байдлаар	Тодруулга	Өндөр зэрэглэл мян. төг.	Стандарт зэрэглэл мян. төг.	Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай мян. төг.		Нийт мян. төг.
				Стандартаас доогуур зэрэглэл мян. төг.	Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнийн бууралттай мян. төг.	
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	12	108,698,757	105,391,608	2,421,073	-	216,511,438
Санхүүгийн хөрөнгө оруулалт						
- борлуулахад бэлэн	14	-	837,370	-	189,326	1,026,696
- дуусгавар хугацаа хүртэл нь эээмших	14	118,518,578	-	-	-	118,518,578
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа						
- Бизнесийн зээл	15	203,623,118	51,634,672	19,397,055	27,149,742	301,804,587
- Жижиг бизнесийн зээл	15	84,730,938	15,494,637	8,581,039	26,313,210	135,119,824
- Хэрэглээний зээл	15	5,124,689	285,838	282,091	6,028,526	11,721,144
- Орон сууцны зээл	15	17,714,879	6,807,803	4,354,016	9,126,522	38,003,220
- Бусад	15	27,203,307	8,847,130	138,685	502,500	36,691,622
		338,396,931	83,070,080	32,752,886	69,120,500	523,340,397
Нийт		565,614,266	189,299,058	35,173,959	69,309,826	859,397,109

Хугацаа хэтэрсэн зээл ба урьдчилгаанд зөвхөн цөөн хоногийн хугацаа хэтэрсэн тохиолдлуудыг оруулдаг. Зээлүүдийн хугацаа хэтрэлтээрх шинжилгээг дор үзүүлэв. Хугацаа хэтэрсэн зээлүүдийн дийлэнх нь үнэн цэнийн бууралтгүй гэж үзсэн.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

31.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Хугацаа хэтэрсэн, гэхдээ үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн анги бүрээрх насхилтын шинжилгээ

2010.12.31-ний өдрийн байдлаар	30 хоногоос бага мян. төг.	31-60 хоног мян. төг.	61-90 хоног мян. төг.	91-ээс дээш хоног мян. төг.	Нийт мян. төг.
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа					
- Бизнесийн зээл	-	2,654,601	-	3,284,539	5,939,140
- Жижиг бизнесийн зээл	2,806,062	1,545,344	1,954,785	3,558,440	9,864,631
- Хэрэглээний зээл	1,769,288	184,363	170,095	937,119	3,060,865
- Орон сууцны зээл	1,572,475	1,423,417	723,851	1,140,159	4,859,902
	6,147,825	5,807,725	2,848,731	8,920,257	23,724,538
2009.12.31-ний өдрийн байдлаар					
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа					
- Бизнесийн зээл	7,122,020	5,163,447	6,545,392	4,945,313	23,776,172
- Жижиг бизнесийн зээл	11,983,176	1,158,567	1,499,881	3,270,018	17,911,642
- Хэрэглээний зээл	3,517,383	231,782	307,403	1,194,266	5,250,834
- Орон сууцны зээл	6,610,271	1,079,855	539,260	105,072	8,334,458
- Бусад	333,086	169,414	-	-	502,500
	29,565,936	7,803,065	8,891,936	9,514,669	55,775,606

Хугацаа хэтэрсэн гэхдээ, үнэ цэнийн бууралтгүй нийт зээл ба урьдчилгааны барьцаа хөрөнгийн бодит үнэлгээ нь 2010 оны 12 сарын 31-ний байдлаар 72.60 тэрбум төгрөг (2009 онд 374.48 тэрбум төгрөг) байв. Барьцаалсан барьцаа хөрөнгийн төрлүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 31.2 буюу “Барьцаа ба зээлийн бусад сайжруулалтууд” -аас үзнэ үү.

Гэрээнийх нь нөхцлийг өөрчилсөн санхүүгийн хөрөнгийн ангилал тус бүрийн бүртгэлийн дүн

Гэрээнийх нь нөхцлийг өөрчилсөн санхүүгийн хөрөнгийн бүртгэлийн дүнг ангилал бүрээр үзүүлэв.

	2010 Мян. төг	2009 Мян. төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		
Бизнесийн зээл	23,517,195	11,212,951
Жижиг дунд бизнесийн зээл	7,310,836	12,831,423
Хэрэглээний зээл	8,398,273	43,748
Орон сууцны зээл	610,944	442,327
Бусад	-	77,843
	39,837,248	24,608,292

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Зээлийн үндсэн ба хүүгийн графикт төлбөр 90-с дээш өдрөөр хугацаа хэтэрч байгаа, эсхүл зээлдэгчийн мөнгөн урсгалд хүндрэл гарсан нь мэдэгдэж буй, зээлийн үнэлгээ доогуур гарсан, зээлийн гэрээний эх нөхцлүүд зөрчигдсөн тохиолдуудыг үнэ цэнийн бууралтын шинжилгээ хийх явцад авч үздэг. Банк нь үнэ цэнийн бууралтын шинжилгээг дараах хоёр байдлаар ялган хийдэг: бүлгээр үнэлэгдсэн сан ба дангаар (тусгай) үнэлэгдсэн сан.

Тусгай үнэлгээгээр үнэлэгдсэн зээлийн эрсдэлийн сан

Банк нь дангаараа чухал зээлүүдийг ялган авч нэг бүрчлэн эрсдэлийн тохирох санг байгуулдаг. Үнэ цэнэ бууралтын хэмжээг тодорхойлоход зээлдэгчийн бизнес төлөвлөгөөний тогтвортой байдал, түүний санхүүгийн бий болсон

хүндрэлийг арилгах чадавхи, төсөөлсөн орлого, дампуурал гарсан тохиолдолд дагаж гарч болзошгүй холбогдох ногдол ашигийн болон бусад төлбөрүүд, бусад санхүүгийн дэмжлэгийн боломж ба барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ болон төлөвлөж буй мөнгөн урсгалын орж ирэх хугацаа зэргийг нэг бүрчлэн авч үздэг. Гэнэтийн үйл явдлын улмаас илүү нухацтайгаар анхаарахыг шаардсанаас бусад тохиолдолд үнэ цэнэ бууралтын алдагдал нь жил бүрийн тайлагналын өдрөөр үнэлэгдэн тооцогддог.

Бүлгийн үнэлгээгээр үнэлэгдсэн зээлийн эрсдэлийн сан

Дангаараа чухал бус бүх зээл ба урьдчилгаа (зээлийн карт, орон сууцны зээл, болон бусад бүх хэрэглээний зээлийг оролцуулаад), мөн дангаараа чухал боловч тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурах нотолгоо байгаагүй зээл ба урьдчилгааны хувьд бүлгээр нэгтгэн ангилж, бүлэг тус бүрт эрсдэлийн алдагдлыг тооцно. Бүлгийн үнэлгээг жил бүрийн тайлагналын өдрөөр бүлэг тус бүрт ялгаатай шинжилгээнд үндэслэн хийнэ.

Бүлгийн үнэлгээнд тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй боловч тэдгээрийг оруулсан багцийн түвшинд оршин байх магадлалтай үнэ цэнийн бууралтыг тооцдог. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараахаа мэдээлэлд үндэслэн тооцдог. Үүнд: бүлгийн алдагдлын түүхэн мэдээ, өнөөгийн эдийн засгийн байдал, алдагдал гарсан гэж таамаглаж буй үе болон тус алдагдлыг танин илрүүлсэн үе хоорондын ойролцоолсон хугацаа мөн үнэ цэнийн бууралттай гэж тогтоогдоны дараа хүлээгдэж буй эргэн төлөлт, орлого орно. Бүлгийн үнэлгээ нь нэг жилийн давтамжтайгаар хийгдэх ба Банкны удирдлага энэхүү давтамжийг өөрчлөх эсэхийг шийднэ. Үнэ цэнийн бууралтын сангт Банкны ерөнхий бодлоготой нийцэж байгаа эсэхийг хянуулах үүднээс Зээлийн удирдлагаар шалгуулдаг.

Санхүүгийн баталгаа болон аккредитивыг үнэлж санг нь зээлийнхтэй ижил хэлбэрээр байгуулдаг.

31.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон хүндрэлийн үед Банк харилцагчийн өмнө хүлээсэн төлбөрийн үргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлийг Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг. Ирээдүйн мөнгөн урсгал, өдөр тутмын төлбөрийн чадварт мониторинг хийх, шаардлагатай түвшинд хөрвөх актив барих, тогтвортой эх үүсвэр татах замаар банк энэхүү эрсдэлийг удирддаг. Төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлагад хүлээгдэж буй мөнгөн урсгалын үнэлэлт, шаардлагатай тохиолдолд нэмэлт эх үүсвэр татахад ашиглагдах өндөр зэрэглэлтэй барьцааг мөн хамруулдаг.

Банк бэлэн мөнгөний хүлээгдээгүй хүндрэлд орох үед зах зээлд маш хялбарханаар борлогдох төрөл бүрийн активуудаас бүрдэх багцыг барьж байдаг. Банк мөн төлбөрийн чадварын хүндрэлд орох үед ашиглах зорилгоор зээлийн шугамын эрх авсан байдаг. Үүнээс гадна харилцагчаас татсан хадгаламжийн 5% (2009 онд 5%)-тай тэнцүү дүнтэй бэлэн мөнгийг хууль ёсны дагуу Монголбанкинд (Төв банк) байршуулдаг. Төлбөрийн чадварыг зах зээлийн болон банктай холбоотой стресс хүчин зүйлсийг тооцсон янз бүрийн нөхцөл байдалд үнэлж удирддаг. Эдгээр төлбөрийн чадварын удирдлагуудаас зах зээлийн нөхцөл байдлын нөлөөг тусгасан цэвэр хөрвөх активыг харилцагчаас татсан эх үүсвэрт харьцуулсан харьцаанд лимит тавих нь банкны зүгээс хамгийн чухал удирдлага болдог. Бэлэн мөнгө, богино хугацаагаар банкинд байршуулсан харилцах, хадгаламж, түргэн борлогдох үнэт цааснаас нэг сарын дотор төлөгдөх ёстой бусад банкнаас татсан хадгаламж, зээлийг хасч цэвэр хөрвөх активыг гаргадаг. Энэ харьцаа тайлант жилийн хувьд дараах байдалтай байв. Үүнд:

	2010 %	2009 %
12 сарын 31	51.2%	51.7%
Тайлант жилийн дундаж	45.2%	44.8%
Хамгийн их	51.2%	57.2%
Хамгийн бага	38.1%	35.4%

Дараахи хүснэгтэнд 2009 ба 2010 онуудын 12 сарын 31-ний байдлаарх банкны санхүүгийн дискаунтлаагий өр төлбөрийн эргэн төлөгдөх хугацааг дурсэлсэн. Эдгээр өр төлбөрийн хүлээгдэж буй эргэн төлөгдөх хугацааг "Актив пассивын эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ" гэсэн Тодруулга 30-өөс харна уу. Урьдчилан мэдэгдсэнд үндсэн дээр төлөгдөх ёстой өр төлбөрийг мэдэгдэл нь ирсэн гэж тооцов. Хэдий тийм боловч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ гаргахгүй гэж үзж буй ба. Банк хадгаламжийн түүхэн үлдэцээр тодорхойлогдон хүлээгдэж буй мөнгөн урсгалын нөлөөг хүснэгтэнд тусгаагүй болно.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)
31.3 Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөр	Хугацаагүй мян.төг	6 хүртэлх сар мян.төг			6 - 12 сар мян.тө	1 - 5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	Дискаунтлаагүй санхүүгийн нийт өр төлбөр мян.төг
2010 оны 12 сарын 31								
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	70,762,777	6,727,307	4,025,713	-	-	-	81,515,797	
Харилцагчдын харилцах, хадгаламж	898,566,566	185,758,421	262,309,950	3,596,516	-	-	1,350,231,453	
Зээлээр авсан санхүүжилт	1,721,579	1,126,219	2,061,345	17,569,376	10,625,097	33,103,616		
Хоёрдогч өглөг	494,296	465,154	930,308	49,608,196	-	-	51,497,954	
Бусад пассив (хойшлогдсон орлого орохгүй)	13,494,041	477,002	2,706,749	-	-	-	16,677,792	
Нийт	985,039,259	194,554,103	272,034,065	70,774,088	10,625,097	1,533,026,612		
2009 оны 12 сарын 31								
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	49,303,978	-	3,898,393	-	-	-	53,202,371	
Харилцагчдын харилцах, хадгаламж	607,810,948	109,159,369	96,453,121	-	-	-	813,423,438	
Зээлээр авсан санхүүжилт	3,317,256	615,207	43,919,978	12,784,989	10,337,255	70,974,685		
Хоёрдогч өглөг	99,218	-	299,859	15,010,336	-	-	15,409,413	
Бусад пассив (хойшлогдсон орлого орохгүй)	12,691,167	-	-	-	-	-	12,691,167	
Репо хэлцэл	7,744,869	-	-	-	-	-	7,744,869	
Нийт	680,967,436	109,774,576	144,571,351	27,795,325	10,337,255	973,445,943		

Доорх хүснэгтэнд Банкны хүлээж болзошгүй өр төлбөр болон үүргүүдийг гэрээт эргэн төлөгдөх хугацаагаар нь харуулав.

Хугацаагүй мян.төг	3 хүртэлх сар мян.төг			3-12 сар мян.тө	1-5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	Дискаунтлаагүй санхүүгийн нийт өр төлбөр мян.төг
2010 оны 12 сарын 31							
Болзошгүй өр төлбөр	61,298,639	11,161,552	9,760,020	1,483,775	-	83,703,986	
Үүрэг	15,714	8,518,961	12,700,887	5,906,502	-	27,142,064	
Нийт	61,314,353	19,680,513	22,460,907	7,390,277	-	110,846,050	
2009 оны 12 сарын 31							
Болзошгүй өр төлбөр	39,605,322	5,586,818	11,845,350	6,540,785	-	63,578,275	
Үүрэг	958,842	1,575,120	3,342,960	5,861,097	10,353	11,748,372	
Нийт	40,564,164	7,161,938	15,188,310	12,401,882	10,353	75,326,647	

31.4 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүү, ханш зэрэг зах зээлийн хувьсагчуудад орсон өөрчлөлтөөс болж санхүүгийн хэрэгсэлийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн урсгал өөрчлөгдөх эрсдэлийг хэлнэ. Банк нь энэ төрлийн эрсдэлийг VaR болон мэдрэмжийн шинжилгээ хийх замаар хянаж, удирддаг. Гадаад валютын төвлөрөлөөс бусдаар зах зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц төвлөрөл байхгүй байна.

Хүүгийн эрсдэл

Хүүгийн аливаа хөдөлгөөн нь санхүүгийн хэрэгсэлийн үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөө үзүүлж болохос хүүгийн эрсдэл үүсдэг. Тодорхой хугацаанд байж болох хүүгийн зөрүүгийн хязгаарлалтыг ТУЗ-өөс тогтоож өгдөг. Хүүгийн нээлттэй позицуудыг өдөр тутам хянадаг бөгөөд тогтоосон хязгаарт байлгахын тулд хэджинг буюу хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Доорхи хүснэгт нь бусад бүх нөхцөл байдал өөрчлөгдөөгүй байхад хүүгийн боломжит хөдөлгөөн банкны орлого, үр дүнгийн тайланд хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна.

Орлогын тайлангийн мэдрэмтгийн байдал нь 2010 болон 2009 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх хөвөгч хүүтэй санхүүгийн актив болон пассивийн хүүний түвшний өөрчлөлтийг даган өөрчлөгдөх нэг жилийн цэвэр хүүний орлогын өөрчлөлт дээр сууриссан байна.

Валютын нэгж	Суурь цэгийн өөрчлөлт	Хүүгийн цэвэр орлогын мэдрэмж мянтэг
2010 оны 12 сарын 31		
Доллар	+120	(626,485)
Төгрөг	+120	(441,414)
Доллар	-120	626,485
Төгрөг	-120	441,414
 2009 оны 12 сарын 31		
Доллар	+120	(318,074)
Төгрөг	+120	(384,602)
Доллар	-120	318,074
Төгрөг	-120	384,602

Ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн хөдөлгөөн нь банкны санхүүгийн төлөв байдал, мөнгөн урсгалд нөлөөлж болох эрсдэлд Банк өртдөг. Банкны удирдлагаас өдөртөө байж болох хоног дамжиж болох нээлттэй позицийн хязгаарлалтыг нэг валют (ихэвчлэн америк доллараар) болон нийт валютын нийлбэр дүнгээр тогтоон өдөр болгон хянаж явдаг байна.

ТУЗ-өөс гадаад валютын багцын тухайд хүлээж болох эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоож өгсөн. 99%-ийн магадлалтайгаар банкны нээлттэй позицийг үнэлэх, Монголбанкны ханшийн өөрчлөлтийг хэд хэдэн үзүүлэлт болон төсөөлөлтэйгээр авч үзэн, үүнээс учирч болох эдийн засгийн алдагдлыг тооцоолох VaR аргыг Банк хэрэглэж байна. VaR нь тодорхой цаг хугацааны хүрээнд, тодорхой магадлалтайгаар Банкны гадаад валютын багцын ашиггүй хөдөлгөөн, өөрчлөлтийг тооцох замаар банкинд учирч болох санхүүгийн эрсдэлийг тодорхойлох аргачлал юм.

VaR аргын зорилго, сүл талууд

Өнгөрсөн нэг жилийн мэдээлэл дээр суурilan гадаад валютын багцын боломжит өөрчлөлтийг тооцоолох зорилгоор банк VaR-ын Делта нормал, Монте Карло, Түүхэн загварчлалын аргуудыг хэрэглэж байна. VaR аргачлал нь зах зээлийн ердийн нөхцөл байдалд гадаад валютын эрсдэлийг тооцоход зориулагдсан. Делта нормал, Монте Карло, Түүхэн загварчлалын аргуудад хэвийн зах зээлийн орчинд нөлөөлөгч эрсдэлийн хүчин зүйлсийн аливаа өөрчлөлт нь хэвийн тархалттай гэж үздэг. Эдгээр хоёр VaR арга нь тодорхой дутагдалтай талуудтай учир нь эдгээр аргууд нь гадаад валютын түүхэн корроляци, хэлбэлзэлд үндэслэдэг ба ирээдүйн валютын ханшийн өөрчлөлт хэвийн тархалттай гэж таамагладаг.

31. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

VaR аргын зорилго, сул талууд (Үргэлжлэл)

VaR арга нь түүхэн өгөгдөл үндэслэдэг болохоор эрсдэлийн хүчин зүйлсийн ирээдүйн өөрчлөлтийг сайн тусгаж чадахгүй байх талтай бөгөөд хэвийн тархалтын таамаглалд эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлт нь нийцэгүй тохиолдолд гадаад валютын ханшны их хэмжээний өөрчлөлтийг дутуу үнэлж болох талтай. VaR нь эрсдэлийн хүчин зүйлсийн хоорондын хамаарал, эрсдэлийн хүчин зүйлсүүдэд тавьсан таамаглалаас шалтгаалж эрсдэлийг дутугаар эсвэл илүүгээр үнэлэх боломжтой. Гадаад валютын позици өдрийн турш өөрчлөгддэг боловч VaR нь зөвхөн өдрийн төгсгөлд хаагдсан багцын эрсдэлийг хэмждэг ба 99% итгэх завсараас хэтэрч алдаж болзошгүй алдагдлын дүнг тооцож чадахгүй.

Практикт гадаад валютын бодит үр дүнгүүд VaR тооцооллоос зөрдөг. Тухайлбал, хэвийн бус зах зээлийн нөхцөлд тооцоолол бодит ашиг алдагдалтай уялдаж чаддаггүй. VaR загварын бодит байдалтай нийцж буйг тодорхойлохын тулд бодит үр дунгүүдийг тодорхой хугацааны /гурван сар/ давтамжтайгаар VaR тооцоололтой харьцуулж үзэн Backtesting хийдэг. Зах зээлийн онцгой хүндрэлийн нөлөөг Банк даван туулж чадах эсэхэд баталгаатай байх үүднээс банк гадаад валютын багцдаа тогтмол стресс тест хийдэг.

VaR таамаглалууд

Банк 99%-ийн итгэх завсар ашиглан VaR тооцдог тул гадаад валютын нээлттэй позиц нэг өдрийн турш өөрчлөгдөхгүй гэж үзвэл боломжит алдагдлын хэмжээ VaR-aас их байх бараг боломжгүй. Нэг өдрийн хугацаанд 99%-ийн итгэх завсартай VaR гэдэг нь аливаа 100 өдрийн бодит ашиг алдагдлын дүн тооцоолж гаргасан VaR-с дунджаар нэг удаа их байхыг илтгэнэ.

VaR нь банкны гадаад валютын эрсдэлийн салшгүй хэсэг тул гадаад валютын нээлттэй позицуудад VaR лимит тоогосон бөгөөд эдгээр лимитүүдтэй нээлттэй позицийн дүнг өдөр тутам харьцуулж хянаж байдаг. Загварт Монголбанкны гадаад валютын ханшны эрсдэлийг VaR аргаар хэмжих аргачлалын таамаглалуудаас нэгтгэж өгсөн байдаг.

	Делта нормал мян.төг	Монте Карло мян.төг	Түүхэн загварчлал мян.төг
2010 – 12 сарын 31	129,230	133,856	160,262
2010 - Өдрийн дундаж	147,612	148,882	190,809
2010 - Хамгийн их	342,395	347,259	408,306
2010 - Хамгийн бага	43,671	44,471	53,374
2009 - 12 сарын 31	99,715	104,379	163,116
2009 - Өдрийн дундаж	149,305	153,118	212,716
2009 - Хамгийн их	205,868	238,618	317,353
2009 - Хамгийн бага	36,368	36,971	44,419

Урьдчилгаа төлбөрийн эрсдэл

Урьдчилгаа төлбөрийн эрсдэл нь харилцагч эсвэл гэрээнд оролцогч тал төлбөрөө урьдчилж төлөх, эсвэл төлбөрөө хугацаанаас өмнө хийхийг хүссэнээс банк алдагдалд орох эрсдэлийг хэлнэ. Тухайлбал, тогтмол хүүтэй орон сууцны зээлийн хувьд хүү буурах үед зээлдэгчид зээлээ урьдчилж төлснөөс энэ хэлбэрийн эрсдэл үүсдэг.

Банк өөрийн дотооддо боловсруулсан загвар ашиглан хүүгийн цэвэр орлогодоо урьдчилгаа төлбөрийн янз бүрийн нөлөөллийг тооцолдог.

Өнгөрсөн жилийн урьдчилгаа төлбөрийн түвшинг суурь болгон авч бусад бүх хувьсагчид тогтмол гэж үзэн жилийн эхэнд төлөгдөхөөр тооцон үзэхэд татварын өмнөх жилийн ашигт дараах хэлбэрийн нөлөөлөл гарч байна.

	Хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөлөл 2010 сая.төг	Хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөлөл 2009 сая.төг
Харилцагчаас авах зээл ба урьдчилгаа		
Байгууллагын	(880)	(537)
Жижиг дунд бизнесийн	(350)	(190)
Хэрэглээний	(109)	(54)
Орон сууцны	(104)	-
Бусад	-	(287)
	(1,443)	(1,068)

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн догоилдол, хүний алдаа, залилан болон бусад гадаад хүчин зүйлээс банкинд учирч болох алдагдлын эрсдэлийг хэлнэ. Хяналт сүл үед үйл ажиллагааны эрсдэл нь банкны нэр хүндэд хохирол учруулах, хууль зохицуулалтын асуудалд оруулах, улмаар санхүүгийн алдагдалд хүргэх болно. Банк хэдийгээр үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн арилгах бололцоогүй ч хяналт, мониторинг сайжруулах замаар энэ төрлийн эрсдэлийг удирдаж болно. Эрхийн хэм хэмжээг зөв тогтоох, боловсон хүчиний сургалт, боловсрол, доодоо хяналт зэрэг нь хяналтын арга хэмжээнд орно.

32. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

Банкны энгийн хувьцааны 100%-ийг эзэмшдэг Бодь Интернэйшнль ХХК нь Банкыг хянаж байдаг.

Бизнесийн хэвийн нөхцөлд олон тооны банкны гүйлгээг холбоотой талуудтай хийдэг. Эдгээр гүйлгээнд зээл, хадгаламж, валютын гүйлгээнүүд ордог. Эдгээр гүйлгээг арилжааны нөхцлөөр, зах зээлийн ханшаар хийдэг.

12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны холбоотой талууд (Банкны ТУЗ-ийн гишүүд томоохон хувь эзэмшдэг аж ахуйн нэгжүүд)-тай хийсэн гүйлгээний үлдэгдэл дараахь байдалтай байна.

	2010 Мян. төг	2009 Мян. төг
а) Холбоотой талуудад олгосон зээл ба урьдчилгаа		
Бодь Автомотив ХХК	3,617,832	2,340,000
Бодь Электроникс ХХК	1,705,030	718,965
Бодь Пропретийз ХХК	-	2,776,024
Сар Шинэ Интернэйшнль ХХК	1,370,007	1,928,249
Хонка Лог Хөөм ХХК	67,289	1,083,276
Монгол Лизинг ХХК	1,856,400	2,029,133
	8,616,558	10,875,648

Толгой болон бусад охин компаниудад олгосон зээл нь барьцаатай, жилийн 12.00% - 21.60% (2009 онд 10.68% - 24.00%) хүү тооцдог ба 1-6 жилийн дотор эргэн төлөгдөх хугацаатай. Тайлант жилд тус зээлүүдээс хүлээн авсан хүүгийн орлого нь 1,361.30 сая төгрөг (2009 онд 806.69 сая төгрөг) байна.

32. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2010 Мян. төг	2009 Мян. төг
б) Холбоотой талуудаас хүлээн авсан харилцах, хадгаламж:		
Толгой компани	85,522	355,311
Бусад охин компаниуд	3,379,024	1,769,709
	3,464,546	2,125,020

Дээрх холбоотой талуудын байршуулсан харилцах, хадгаламж нь 2010 онд жилийн 0% - 10.80% (2009 онд жилийн 0% - 10.44%)-ийн хүү тооцдог. Тайлант жилд эдгээр холбоотой талуудад төлсөн хүүгийн зардал 139 сая төгрөг (2009 онд 35 сая төгрөг) байсан.

	2010 Мян. төг	2009 Мян. төг
в) Бусад охин компаниудаас худалдан авсан компьютер, програм хангамж		
	335,569	191,273

	2010 Мян. төг	2009 Мян. төг
г) Холбоотой талуудаас хүлээн авсан барилга байшин		
Бодь Интернэйшнль ХХК (Толгой компани)	5,613,216	-
Бодь Пропретииз ХХК	10,219,680	-
Хонка Лог Хөтүм ХХК	2,149,630	-
	17,982,526	-

	2010 Мян. төг	2009 Мян. төг
д) Гол удирдах албан тушаалтнуудад олгосон нөхөн олговор		
Ажилчдад олгосон богино хугацаат тэтгэмж		
Цалин	299,054	104,004
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	36,567	21,841
	335,621	125,845

е) Бодь Интернэйшнль ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээ

2002 оны 11 дүгээр сард Банк нь "Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар хот, Монгол улс" хаягтай өөрийн шинэ ажлын байранд нүүн орсон. 2009 оны 10 дугаар сард Баянгол дүүрэгт "Москва" салбарын шинээр нээсэн. Эдгээр барилгыг Банкны толгой компани болох Бодь Интернэйшнль ХХК эзэмшдэг. 2010 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Банк нь "Москва" салбарын барилгыг өөрийн толгой компаниас худалдан авсан. Дүнг Тодруулга 32 (г)-д толилуулсан байгаа.

Банк нь төв оффисын барилгыг 2014 оны 1-р сарын 1-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаанд, Москва салбарын барилгыг 2014 оны 10-р сарын 1-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаанд түрээслэх гэрээг 2009 онд байгуулсан. Банк 2009 онд 3.9 тэрбум төгрөг ба 885.60 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг тус төлсөн. 2010 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар дээрх урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдэл 2.4 тэрбум төгрөг (2009 онд 3.22 тэрбум төгрөг ба 841.32 сая төгрөг тус тус байсан) байсан. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 29-өөс харна уу.

33. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Банк бизнесийн салшгүй эрсдэлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үр ашигтай удирддаг. Бусад арга хэмжээнүүдээс гадна Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг.

Өнгөрсөн жилийн турш Банк нь өөрийн хөрөнгөд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

Капиталын удирдлага

Банкны капиталын удирлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба бизнесээ дэмжиж хувь нийлүүлэгчдийн үнэлэмжийг ихэсгэхийн тулд зээлийн эрсдэлийн чансааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна. Банк капиталынхаа бүтэцээ хадгалах эсвэл тохируулахын тулд хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, хувь нийлүүлэгчид хөрөнгийг нь эргүүлэн төлөх, шинээр өөрийн хөрөнгийн хэрэгсэл гаргах, эсвэл өөрийн хөрөнгөд уялдсан үнэт цаас гаргах зэрэг арга замуудыг ашигладаг байна.

Зохицуулалттай капитал

Монголбанкнаас арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хамгийн багадаа 6% (2009 онд 6%), өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын харьцааг 12% (2009 онд 12%)-иас дошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдэлийн уг шинж чанараар нь тохируулсан актив болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг дараах үзүүлэв.

	2010	2009
	Мян. төг	Мян. төг
Өөрийн хөрөнгийн харьцаа	8.85%	10.91%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	13.47%	13.36%
 I зэрэглэлийн хөрөнгө		
Дүрмийн сан	21,934,142	21,934,142
Хуримтлагдсан ашиг	62,161,346	42,108,598
Нийт I зэрэглэлийн хөрөнгийн дүн	84,095,488	64,042,740
 II зэрэглэлийн хөрөнгө		
Хоёрдогч өглөг	43,976,450	14,428,400
Нийт капитал/капиталын суурь	128,071,938	78,471,140

12 сарын 31-ний байдлаар эрсдэлээр нь жигнэсэн активуудыг эрсдэлийн ангилал тус бүрээр үзүүлбэл

33. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (ҮРГЭЛЖЛЭЛ)
Зохицуулалттай капитал (Үргэлжлэл)

%	2010		2009	
	Актив мян.төг	Эрсдэлээр жигнэсэн мян.төг	Актив мян.төг	Эрсдэлээр жигнэсэн мян.төг
0	477,360,275	-	264,506,870	-
20	230,662,704	46,132,541	245,472,675	49,094,535
50	127,035,722	63,517,861	66,211,173	33,105,587
100	832,133,598	832,133,598	505,034,385	505,034,385
150	5,951,836	8,927,754	-	-
Нийт	1,673,144,135	950,711,754	1,081,225,103	587,234,507

34. ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант жилийн толилуулгатай нийцүүлэх үүднээс дараах харьцуулсан үзүүлэлтүүдийг дахин ангилсан.

Өөрчлөлтийн утга	Өмнө тайлагнааснаар мян.төг	Өсөлт/ (Бууралт) мян.төг	Дахин тайлагнааснаар мян.төг
Дэлгэрэнгүй орлогын тайлан			
Хураамж, шимтгэлийн орлого	10,580,138	(1,146,999)	9,433,139
Хүү, түүнтэй адилтгах зардлууд	57,904,980	(48)	57,904,932
Арилжааны цэвэр орлого	12,577	176,315	188,892
Үйл ажиллагааны бусад орлого	4,905,675	913,440	5,819,115
Үйл ажиллагааны зардлууд	16,712,030	(57,196)	16,654,834

35. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд зөрүү ялгаа гарах тохиолдолд Англи хувийг дагах болно.